

"АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР"-ИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ 2021 ОНЫ ХЭРЭГЖИЛТ

ЗГҮАХ-т тусгагдсан, зорилт	Дугаар	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Үндсэн хэрэгжүүлэх байгууллага	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр /сая төгрөг/	Суурь түвшин	Зорилтот түвшин, үр дүн		Хэрэгжилтийн хувь
							Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн	
1	2	3	4	5	6		8		9
НЭГ."КОВИД-19" ХАЛДВАРТ ЦАР ТАХЛААС ҮҮДЭЛТЭЙ ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ									
	1.1	"Ковид-19" халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах арга хэмжээг хэрэгжүүлнэ							
"Ковид-19" халдварт цар тахлын үед иргэн, аж ахуйн нэгжийг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлнэ	1.1.1.1	Аж ахуйн нэгж, хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд хөдөлмөрийн аюулгүй байдал, ариун цэвэр, халдваргүйн горимыг хангахад шаардлагатай мэдээлэл, сурталчилгаа хийх, сургалт зохион байгуулж, ажлын байраа хадгалах, орлоготой байх нөхцөлийг бүрдүүлнэ.	2021-2023	АЗДТГ, ХХҮГ	30	0	10	МХГ-аас хүнсний худалдаа, үйлдвэр үйлчилгээ эрхлэгч нийт 24 сумын 537 аж ахуйн нэгжээс худалдаа, үйлдвэрлэл, түгээлтийн үйл ажиллагаа эрхлэгч 445 аж ахуйн нэгж, иргэн хэвийн үйл ажиллагаа явуулж байгаагаас давхардсан тоогоор 627 иргэн, аж ахуйн нэгжийн 44765 мкв талбайд мэргэжлийн тусгай зөвшөөрөл бүхий байгууллагаар, 562 аж ахуйн нэгж, иргэний 48450 мкв талбайг харъяа эрүүл мэндийн байгууллагаар урьдчилан сэргийлэх ариутгал халдваргүйтгэл хийлгэж, Коронавируст халдвар (Ковид-19)-ын батлагдсан тохиолдол болон ойрын хавьтал үйлчлүүлсэн 234 худалдаа үйлчилгээ, 2249 айл өрх, 57 эрүүл мэндийн байгууллага, 31 тусгаарлан ажиглах байр, 733 бусад байгууллагын нийт 566801 мкв талбайд голомтын эцсийн халдваргүйтгэл хийхэд хяналт тавин 18 ариутгалын бодис, 6 ажлын уусмалаас дээж авч итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээнд хамруулсан. Өнөөдрийн байдлаар давхардсан тоогоор нийт 2174 байгууллага, аж ахуйн нэгж, иргэний үйл ажиллагаанд өдөр тутам хяналт хийж 7164 зөрчил дутагдал илрүүлж 6232 (87%-ийг арилгуулсан. Зөрчлийг арилгуулахаар 2050 зөвлөмж, сэрэмжлүүлэг, мэдэгдэл, тусгай шаардлагыг хүргүүлэн, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн. Коронавируст халдвар (Ковид-19)-т цар тахалт өвчний үед аймгийн Мэргэжлийн хяналтын газраас 2021 оны 11 дүгээр сарын байдлаар 24 хяналтын чиглэлээр албан шаардлага 373, зөвлөмж 127, акт 26, дүгнэлт 137 үйлдэж хүргүүлсэн байна.	90
	1.1.1.2	Аж ахуйн нэгж, байгууллагуудын ариутгал халдваргүйжүүлэлтийг тогтмолжуулж, хяналт тавьж ажиллана.	2021-2023	АЗДТГ, ХХҮГ	20	45	85	Коронавируст халдвар (Ковид-19) бүртгэгдсэн Шилүүстэй, Тосонцэнгэл, Их-уул, Нөмрөг, Сонгино, Цэцэн-Уул, Завханмандал, Улиастай сумдад халдваргүйжүүлэлтийн багууд ажиллаж батлагдсан тохиолдлын ажлын газар, үйлчлүүлсэн байгууллага, гэр, орон сууц, орц гэх мэт 3304 объектийн 566801 м.кв талбайд голомтын эцсийн халдваргүйтгэл хийхэд хяналт тавьсан. ЗӨСТ, Ариусгал Завхан, Монклиен ХХК болон 12 байгууллагын халдваргүйжүүлэлтийн бодис, ажлын уусмалаас химийн лабораторийн шинжилгээнд хамруулан идэвхит хлорын агууламж үзүүлэлтээр стандартын шаардлага хангаж буй эсэхэд үнэлэлт, дүгнэлт өгч ажиллалаа. Тусгай зөвшөөрөлтэй 2 байгууллагууд нь албан байгууллага, аж ахуйн нэгж, худалдаа үйлчилгээний байгууллагуудад урьдчилан сэргийлэх халдваргүйжүүлэлт, шавж мэрэгч устгалыг гэрээний дагуу 1 сард 1 удаа тогтмол хийж гүйцэтгэсэн. Нийт 117890 кг аюултай хог хаягдлыг халдваргүйжүүлэн устгах явцад хяналт хийсэн.	90
1.1 дүгээр зорилтын дүн									90
	1.2	"Ковид-19" халдварт цар тахлын эрсдэлээс урьдчилан сэргийлж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангахтай холбоотой төсвийн санхүүжилтийг нэмэгдүүлнэ.							
	1.2.1.1	Цар тахлын үед ажилласан албан хаагчдад олгох цалин, урамшуулал, дэмжлэгийг нэмэгдүүлнэ	2021-2022	АЗДТГ,ЭМГ	50	0	20	Тосонцэнгэл сумын нэгдсэн эмнэлэг, Шилүүстэй, Их-уул сумын эрүүл мэндийн төвүүдэд Коронавирусын батлагдсан тохиолдолд ажилласан эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд эрүүл мэндийн тухай хуулийн 30.1 дэх заалтын дагуу ажилласан хугацааны цалин 3 дахин, тандал судалгааны баг, эрүүл мэндийн штабын жижүүрт гарсан мэргэжилтний илүү цагийн хөлсөнд 68.2 сая төгрөгийн цалин хөлс олгоосон. 2021 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн ЭМС-ын А/298 тоот тушаалаар Коронавирусын халдварын эрсдэлтэй бүсэд ажил үүргээ гүйцэтгэж байгаад халдвар авсан 7 эмч мэргэжилтэн тус бүр нэг сая төгрөг, улаан бүсэд ажилласан 48 эмч мэргэжилтэнд тус бүр 500.0 мянга, ПСРшинжилгээ авахад сайн ажилласан 13 лаборантад тус бүр 300.0 мянга, нийт 40 сая төгрөгийг дэмжлэг үзүүлсэн. Салбарын 995 эмч ажилтанд 7-р сард тус бүр 1 сая, 10-р сард тус бүр 400.0 мянган төгрөг, нийт 1 тэрбум 394.4 сая төгрөгийг нэг удаагийн тэтгэмж олголоо.	100

"Ковид-19" халдварт цар тахлын эрсдлээс урьдчилан сэргийлж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангахтай холбоотой төсвийн санхүүжилтийг нэмэгдүүлнэ	1.2.1.2	Гамшгийн үеийн нөхцөл байдалтай уялдуулан стратегийн хүнсний бүтээгдэхүүний нөөц бүрдүүлнэ	2021-2023	АЗДТГ, ЭМГ	40	7	10	Эрүүл мэндийн штабын тандалт судалгааны баг бүрэлдэхүүн / МХГ, ЦГ, Тагнуулын алба, ОБ-н мэргэжилтнүүд хамрагдсан/-ний гүйцүүдийн ая тухтай байдлыг ханган ажиллаж, байрлан ажиллаж байгаа үед шаардлагатай хоол тэжээлээр ханган ажилласан. 27 нэгж байгууллага батлагдсан төсөвт багтаан тухай бүр 7-10 хоногийн хүнсний нөөц бүрдүүлэн ажилласан. Коронавирусын дэгдэлтийн үед шаардлагатай хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэлтийн гэрээтэй ажиллаж байна.	100
	1.2.1.3	Шинэ болон сэргэн тархаж байгаа халдвараас сэргийлэх мэдээлэл, сургалт, сурталчилгаа зохион байгуулна	2021-2023	АЗДТГ, ЭМГ	5	200	250	ЭМЯ, НЭМУТ-с бэлтгэн гаргасан мэдээ, мэдээлэл, зөвлөмжийг Завхан Эрүүл мэндийн газар цахим хуудас, 34 нэгжийн фэйсбүүк группээр дамжуулан 296 төрлийн мэдээлэл хандалт 73628, зурагт хуудас 302 ш - хандалт 92117 байна. Улиастай сумд Сэжигтэй тохиолдлын хавьтал илрүүлэх үйл ажиллагаатай холбоотой 2, Ковид-19 халдвараас сэргийлэх тухай 6 удаагийн шуурхай зар 152183 хэрэглэгч хандалт хийсэн. Мэргэжлийн эмчийн 22 видео зөвлөмж байршуулан 84614 хэрэглэгчид хүрсэн байна. 37 төрлийн аж ахуй нэгжид зориулсан зөвлөмж зэрэг мэдээлэл сурталчилгааны материалыг байгууллагын цахим хуудас, болон 82000, 21000 гишүүнтэй Завхан аймгийн хамгийн том фэйсбүүк групп, Хариуцлагатай Завханчууд фэйсбүүк группд байршуулсан. Боловсролын салбарын 100 удирдах ажилтанд цахимаар, Амь-Ус трейд ХХК-н 16 ажилтан, Доной нисэх буудлын 20 ажилчдад танхимаар сургалт зохион байгуулсан. Хувийн хамгаалах хувцас хэрэгслийн өмсөж тайлах, амны хаалт зүүх, Ковид 19 халдвараас сэргийлэх, гар угаах, маскаа зүүх, хүн хоорондын зай барих, Дархлаажуулалтын 1, 2, 3 дугаар тундаа хамрагдах, Ковид-19 халдвараар өвдсөний дараа хийх дасгал хөдөлгөөн, Ковид 19 халдварын үед суралцагчдын нийгэм сэтгэл зүйг дэмжих, Жирэмсэн болон төрсний дараах эрүүл мэндийн тусламж үйлчилгээг авах эрхийн талаар зэрэг 31 төрлийн 24244 ш зурагт хуудас аймгийн хэмжээнд Эрүүл мэндийн төв, халуун ус, худаг, дэлгүүр худалдааны төв, худаг, автобусны буудал зэрэг газруудад байршуулсан. Орон нутгийн AIR1, Шинэ Завхан, Zavkhan new social, телевизээр 31 төрлийн дүрс бичлэг дамжуулж байна.Завхан сонинд 2 удаагийн мэдээ, Монголын радиод 1 удаагийн мэдээлэл, аймаг сумдын хөдөлгөөнт болон суурин зарын цэгээр 126892 удаагийн зарлал, сэрэмжлүүлэг, уриалга явуулсан байна. Эрсдэлийн мэдээлэл харилцааны багийн санаачилгаар Ковид-19 халдвараас сэргийлэх, Гэрийн тусгаарлалт, хөл хорионы талаар иргэдийн санал бодол чиглэлээр 2 удаа Google forms-оор орон нутгийн иргэдийн дунд судалгаа, Коронавируст халдвар (ковид-19)-ын үеийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж байгаа эмнэлгүүдийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдалд хяналт, үнэлгээний баг ажиллан 115 иргэнээс санал асуулга авч дүнг нэгтгэн тайлагнасан.	100
	1.2.1.4	Шинэ коронавирусний халдварыг тодорхойлох оношлуур, эм эмнэлгийн хэрэгсэл, хувийн хамгаалах хэрэгсэл, ариутгал халдваргүйтгэлийн бодисын нөөц бүрдүүлнэ	2021-2023	АЗДТГ, ЭМГ	20	2	3	Эрүүл мэндийн яамнаас нийт 9 удаагийн татан авалтаар 660,8 сая төгрөгний хувийн хамгаалах хэрэгсэл татан авч сумын эрүүл мэндийн төв, аймгийн нэгдсэн эмнэлэг, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд нийт 505,1 сая төгрөгний хувийн хамгаалах хэрэгслийг хуваарилсан. 2021.11.05-ны өдрийн байдлаар Эрүүл мэндийн газарт 11 нэр төрлийн 155,7 сая төгрөгний нөөцтэй, 13 удаагийн татан авалтаар 243,4 сая төгрөгний 4 нэр төрлийн вирусн зсрэг эмийн татан авалт хийснээс 197,8 сая төгрөгний хуваарилалт хийгдэж, 45,6 сая төгрөгний 4 нэр төрлийн эмийн нөөцтэй, 4 удаагийн татан авалтаар 115,3 сая төгрөгний түргэвчилсэн оношлуур, АЗДТГ-с хандив тусламжаар 30,0 сая төгрөгний түргэвчилсэн оношлуур, өөрийн хөрөнгөөр 85,0 сая төгрөгний түргэвчилсэн оношлуурын нөөц бүрдүүлснээс 108,2 сая төгрөгний оношлуурыг АНЭ, СЭМТ, ӨЭМТ хуваарилсан. Одоо ЭМГ-т 108,2 сая төгрөгний 7460 ширхэг түргэвчилсэн оношлуурын нөөц байна.	100
	1.2.1.5	Аймгийн нэгдсэн эмнэлэг, зарим "А" зэрэглэлийн эмнэлэг, оношилгоо эмчилгээний төвүүдийг РТ-ПРС төхөөрөмжөөр хангана	2021-2023	АЗДТГ, ЭМГ		0		Аймгийн Нэгдсэн эмнэлэгт PCR шинжилгээний аппарат, бусад дагалдах хэрэгсүүдийг суурилуулан, 05 дугаар сарын 01-ны өдрөөс PCR шинжилгээг хийж байна. Аймгийн хэмжээнд нийтдээ 29007 иргэний ПГУ-н шинжилгээнд хамруулсан.	100

1.2.1.6	Цар тахлын голомтод ажиллаж буй алба хаагчдыг эрүүл мэндийн эрсдэлээс хамгаалах ажлыг зохион байгуулна	2021-2023	АЗДТГ,ЭМГ	15	0	2	Завхан аймгийн "Үйлдвэрчний эвлэлийн хороо" "Хамтын хүчээр халдвараас сэргийлье" аянд нэгдэн байгууллага бүрээс хандив цуглуулан аймгийн Онцгой комисст хүлээлгэн өгсөн. ХӨСҮТ-тэй хамтран аймгийн нэгдсэн эмнэлэг, ЗӨСТ-ийн лаборант нарыг үе шаттайгаар чадавхижуулах ажлын хүрээнд 2021.02.10-2021.03.10 хүртэл сарын хугацаанд АНЭ-ийн лабораторийн эмч, лаборант нар "Түргэвчилсэн шинжилгээ авах арга зүй" сургалтад, 2021.03.18-2021.04.25 хүртэл АНЭ-ийн лабораторийн их эмч, ЗӨСТ-ийн их эмч нар PCR аппарат ажиллуулах ажлын байрны сургалтад хамрагдсан. "Ковид -19 өвчний эмчилгээнд Тоцилизумаб эмийг аюулгүй зохистой хэрэглэх" талаар мэдлэг олгох цахим сургалтад ЭМГ-ын 2 мэргэжилтэн, АНЭ-ийн ЭМТҮЧАБ, Тосонцэнгэл сумын чанарын менежер нийт 6 эмч, мэргэжилтэн хамрагдсан. "Коронавируст халдварын нянгийн эсрэг эмийн эмчилгээ, сонголт, зохистой хэрэглээ", "Үйлчлүүлэгчийн аюулгүй байдлын дэлхийн өдөр" –ийг угтан "Жирэмсний хяналтын чанар, аюулгүй байдал", "Нярайн тусламжийн онцлог, тулгамдсан асуудал" сэдэвт цахим сургалтад харьяа эрүүл мэндийн байгууллагын 54 эмч, мэргэжилтэн хамрагдсан. АШҮҮИС, ЭХЭМҮТ-тэй хамтран өрх, сумын эрүүл мэндийн төвийн эмч нарт "Коронавируст халдварын хяналт ба эмнэлзүйн менежмент" сэдвийн хүрээнд өдрийн сургалтыг зохион байгуулан, нийт 35 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан байна. ХӨСҮТ-ийн эмч мэргэжилтнүүдийн баг "Халдварын сэргийлэлт хяналтын үйл ажиллагаа" сэдэвт сургалтыг танхимаар зохион байгуулж 60 эмч мэргэжилтэн, цахим хэлбэрээр сумын эрүүл мэндийн байгууллагуудтай холбогдон 100 гаруй эмнэлгийн мэргэжилтэн хамрагдсан.	100
1.2 ДУГААР ЗОРИЛТЫН ДҮН							100	
НЭГДҮГЭЭР БҮЛГИЙН ДҮН							95	
ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО								
2.1	Өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тогтолцоог бэхжүүлж, орчин үеийн оношилгоо, эмчилгээний технологийг өргөжүүлэн, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна							
2.1.1.1	Эх хүүхдийн эрүүл мэндийг хамгаалж, нялхсын эндэгдлийг бууруулна.	2021-2024	ЭМГ, АЗДТГ	40.0	эх/э-0, нялхас-16.1	эх/э-0, нялхас 15.1	2021 оны 10 дугаар сарын байдлаар аймгийн хэмжээнд нийт 1066 эх төрсөн нь өмнөх оноос 58 төрөлтөөр буюу 5.7 хувиар өссөн, 1071 хүүхэд амьд төрсөн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 5,5 хувиар өссөн, нийт төрсөн хүүхдийн 4,2 хувь нь 2500 гр-аас доош жинтэй, 1,4 хувь нь төрөлхийн хөгжлийн гажигтай төрсөн байна. Төрөөд 1 цагийн дотор хөхөө амласан хүүхдийн эзлэх хувь 98,2%, амьгүй төрөлтийн түвшин 4,6 байна. Нялхсын эндэгдлийн 25 тохиолдол бүртгэгдэж, 1000 амьд төрөлтөд 23,3 байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 8,5 промиллоор өссөн үзүүлэлттэй. Эхийн ноцтой хүндрэл 1, эхийн эндэгдлийн 1 тохиолдол бүртгэгдсэн. Эрүүл мэндийн газрын даргын тушаалаар "Жирэмсэн болон төрсөн эхчүүд, нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн нэрийн хяналт" хийх журмыг баталж хэрэгжүүлэн, Өндөр эрсдэлтэй жирэмсэн нэрийн эхийн хяналтыг нэвтрүүлэх нь" сэдэвт цахим хэлэлцүүлэг, сургалт зэргийг зохион байгуулж жирэмсэн эхийн хяналтыг сайжруулж байна. 519 жирэмсэн эмэгтэйдээс 222 нь өндөр эрсдэлтэй жирэмсэн байна. 2021 онд жирэмснээс сэргийлэх аргын 13 нэр төрлийн эм, хэрэгслийг 9,0 сая төгрөгийн санхүүжилтээр гэрээ хийгдэн сум, өрхийн Эрүүл мэндийн төвийг ханган ажилласан. Хүүхдийн эндэгдлийг бууруулах ажлын хүрээнд: НҮБХСангаас амьсгалын аппарат,нярайн фото аппарат 2, кардиомонитор 3 дуслын болон тариурын автомат шахуурга 2 ширхэг, автоклав 2 ширхэгийг тус тус нийлүүлсэн. Олон нийтийн эрүүл мэндийн ажилтан 107-г бэлтгэж 18 сая төгрөгийн дэмжлэг авч харьяа эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлсэн. Тосонцэнгэл сумын хүүхдийн эмч, эх баригч нарыг түнхний үений эхо харах чиглэлээр 3 хоногийн сургалтад хамруулсан. Аймгийн Нэгдсэн эмнэлгийн нүдний эмчийг дутуу нярайн ретинопатийг эрт илрүүлэх 14 хоногийн сургалт, эх барихын 1 эмчийг ургийн гажигийг эрт илрүүлэх танхимын 1 сар, цахимаар 2 сарын сургалтад хамруулж чадавхижуулсан. АНУ ын ТББ- аас аймгийн Нэгдсэн эмнэлгийн нярайн тасагт 102 сая, хүүхдийн тасагт 260 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг хандив тусламжаар нийлүүлсэн.	0
2.1.1.2	Эмнэлгийн тусламж үйлчилгээнд цахим үйлчилгээний төрлийг нэмэгдүүлнэ.	2021-2024	ЭМГ, АЗДТГ	40.0	2	4	Коронавируст халдвартай холбоотойгоор эрүүл мэндийн салбарт tandalt.gerege.mn, burtgel.mohs.mn, 1119.mn, Khynalt.za.gov.mn зэрэг сайтууд ашиглатанд орж, салбарын үйл ажиллагааны мэдээллийн нэгдсэн 11141 иргэний бааз үүсгэн, иргэдэд шинжилгээний хариуг цахимаар өгч, албан байгууллагуудаар үйлчлүүлж буй иргэдийг бүртгэн ажиллаж байна. Аймгийн Нэгдсэн эмнэлэг нь группын хурлыг онлайнаар зохион байгуулан 10 дугаар сарын байдлаар 2047 иргэний асуудлыг шийдвэрлэсэн. 7577-9944 дугаараар иргэдэд цахимаар цаг товлон үйлчилгээг нэвтрүүлж нийт 4475 иргэн үйлчлүүлсэн нь эмнэлгийн ачаалалыг 20%-иар бууруулсан байна. Өвчний түүх бичилт аймгийн Нэгдсэн эмнэлэгт бүрэн цахимжсан. "Цахим эрүүл мэнд төсөл - II " төсөл хэрэгжиж байна. 2021 оны 1 сараас эхлэн өрх, сумын Эрүүл мэндийн төв, Нэгдсэн эмнэлгийн эмч нар UrTo Date олон улсын цахим платформыг өдөр, тутмын оношилгоо, эмчилгээндээ ашиглан, 180 эмч, эмнэлгийн ажилчид хэрэглэж, дунджаар 4-10 СМЕ буюу кредит цуглуулсан байна.	70

Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлнэ	2.1.1.3	Сумдад явуулын амбулаторийн цогц үйлчилгээг хүргэнэ	2021-2024	ЭМГ, АЗДТГ	25.0	16827	16900	Жилийн төлөвлөгөөнд "Халдварт болон халдварт бус өвчний цогц илрүүлэг үзлэг"-ийг сумдад зохион байгуулахаар зорилтод арга хэмжээг тусган хэрэгжүүлж байна. Арга хэмжээг зохион байгуулахад ОНХС-гаас 20.0 сая төгрөгийн дэмжлэгийг үзүүлсэн. Зохион байгуулах ажлын хэсэг аймгийн Засаг даргын 2021 оны 367, 427 дугаар захирамжаар тус тус байгуулагдаж, удирдамжийг батлуулан Их-Уул, Тосонцэнгэл, Түдэвтэй, Асгат, Баянтэс, Баянхайрхан, Тэс зэрэг 7 сумдад ажилласан. Эрт илрүүлэг, үзлэгийг дотор, зүрх судас, сүрьеэ, эмэгтэйчүүд, дүрс оношилгоо, хэвлийн эхо, нүд, бэлгийн замын халдвар зэрэг 7 чиглэлээр зохион байгуулан давхардсан тоогоор 7649 иргэн хамрагдаж зорилтот хүн амын 15 хувь байна. Үзлэгийн үр дүнд элэгний хавдар-4, хавдар төст- 4, нүдний болор цайлт-24, бөөр болон цэсний хүүдийн хавдар төст өөрчлөлт-2, зүрхний ишеми-2, Артерийн даралт ихдэлт-59 , чихрийн шижин-31, умайн хэзүүний хавдар-3, Хавдрынурьдал-52, хөхний үүсгэвэр-4, тэмбүү-3, сүрьеэгийн магадлалтай тохиолдол-3, уушгины хавдар төст өөрчлөлт 4 зэргийг илрүүлж дараагийн шатлалын эмнэлэгт шилжүүлж, эмчилгээ, оношилгооны асуудлыг шийдвэрлэсэн. Цэрний шинжилгээг 36 хүнээс авч нян судлалд илгээсэн байна.	70
	2.1.1.4	Уламжлалт анагаах ухааны үйлчилгээг өргөжүүлнэ	2021-2024	ЭМГ, АЗДТГ	35.0	4700	5000	2021 онд Уламжлалт анагаах ухааны төв, аймгийн НЭ-ийн уламжлалтын тасаг, Үе залгамжлагч элит сувилалаар 5003 үйлчлүүлэгч хэвтэн үйлчлүүлсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 6.4 хувиар өссөн байна. Эрүүл мэндийн Сайдын 2021 оны 188 тушаалын дагуу "Монголын анагаах ухаанаар шинэ төрлийн титэмт вируст уушигны хатгалгаа өвчний үрвэслийг сэргийлэн эмчлэх" гарын авлагыг хүргэж ажлыг зохион байгуулж 200 номыг хуваарилан олгосон. Уламжлалт Анагаах Ухаан, Технологийн Хүрээлэн, Уламжлалт Анагаах Ухаан Эмч Судлаачдын Нийгэмлэг, Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их сургууль хамтран 5 удаагийн цахим сургалтыг зохион байгуулж, "Ясны сийрэгжилтийг уламжлалт анагаах ухаанаар эмчлэх, урьдчилан сэргийлэх аргууд" цуврал лекцэнд 99 эмч, мэргэжилтэн хамрагдсан байна.	100
	2.1.1.5	Зүрх судасны тусламж үйлчилгээг тэргүүлэх чиглэл болгон хөгжүүлнэ	2021-2024	ЭМГ, АЗДТГ	35.0	20.1	19.5	Зүрх судасны шалтгаант нас баралт аймгийн хэмжээнд 10000 хүн амд 15.8 байна. MN cardio цахим программаар нийт 560 өвчтөний өвчлөлийн мэдээллийг оруулсан байна. Лавлагаа шатлалын төвүүдэд 12 өвчний мэдээллийг телемедицин ашиглан Зүрх судасны эрдэмтэн, доктор, профессор эмчээс зөвлөгөө авсан. ЛЮКСЕМБУРГИЙН Засгийн газрын буцалтгүй тусламжаар зүрх судасны салбарт хэрэгжиж буй төслийн хүрээнд аймгийн Нэгдсэн эмнэлэг, өрхийн эмнэлгийн 22 эмч нарт зүрх судасны эмгэг, зүрхний эхон дүгнэлтийг хэрхэн унших талаар сургалт хийгдсэн. Уухаар антикоагулянт болон саибутрил/валсартан эмийг эмчилгээнд нэвтрүүлэн NT pro BNP шинжилгээг зүрхний архаг дутагдалтай нийт 35 үйлчлүүлэгчид хийж, эмчилгээний үр дүнг хянаж байна. Аймгийн 24 сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд зүрх судасны тусламж үйлчилгээг анхан шатанд нь сайжруулах зорилгоор МОНГ-ПЕН төслийн нээлтийг хийж, НЭМҮТ, ДЭМБ-тай хамтран сум, өрхийн 50 эмч нарт 4 өдрийн сургалтыг зохион байгуулж, сургалтад хамрагдсан эмч нарт 12 модуль зөвлөгөө өгөх гарын авлага тараагдсан. Алдархаан сумын эмнэлэг, Улиастай сумын 2 өрхийн эрүүл мэндийн төвд төслийн өмнөх хяналт хийгдсэн байна. Энэхүү санаачилгыг орон нутагт үр дүнтэй хэрэгжүүлснээр артерийн даралт ихсэлт, зүрх судасны өвчний 10 жилийн эрсдэлт хүчин зүйлийг бууруулах юм.	70
	2.1.1.6	Эмийн зохистой хэрэглээ, аюулгүй байдлыг ханган, эмийн сангийн үйл ажиллагааг тогтворжуулна	2021-2024	ЭМГ, АЗДТГ	0.0	9	40	Аймгийн Засаг даргын 2021 оны 02 дугаар сарын 02-ний өдрийн А/48 дугаар захирамжаар батлагдсан удирдамжын дагуу Идэр, Тэлмэн, Нөмрөг, Сонгино, Тэс, Их-Уул, Улиастай, Тосонцэнгэл, Отгон, Цагаанхайрхан, Дөрвөлжин сумдад 24 хувийн эмийн санд хяналт үнэлгээ хийснээс бүрэн хангалттай 6, хангалттай 7, хэрэгжих шатны 8, сайжруулах шаардлагатай 3, 20 хувийн эмнэлэгт хяналт үнэлгээ хийснээс бүрэн хангалттай 7, хангалттай 8, хэрэгжих шатанд 3, сайжруулах шаардлагатай 2 эмнэлэг байсан. Хяналт үнэлгээнд хамрагдаагүй 6 байгууллага, Тусгай зөвшөөрөл хүчингүй болгох саналтай 6 байгууллагын асуудлыг шийдвэрлэсэн. Коронавируст цар тахлын дэгдэлттэй холбогдуулан аймгийн хэмжээнд үйл ажиллагаа эрхэлж буй эмийн бөөний төв, эмийн сангуудад аймгийн Засаг даргаас эмийн үнийг өсгөхгүй байх иргэдэд ээлтэй үйлчилгээг хүргэх, ариутгал халдваргүйжүүлэлтийг тогтмол хийх чиглэлээр үүрэг чиглэлийг албан тоотой хүргүүлж хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 11 дүгээр сард Төрийн аудитын газраас "Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого"-ын хэрэгжилтэд хяналт, үнэлгээг хийж байна.	70
	2.1.1.7	Эрүүл мэндийн байгууллагуудад парк шинэчлэлт хийж, зарим сумыг яаралтай тусламжийн бүрэн тоноглогдсон автомашинаар хангана	2021-2024	ЭМГ, АЗДТГ	327.0	56	59	Онцгой байдлын Ерөнхий газраас Нөмрөг, Тэс сумын Эрүүл мэндийн төвд тус бүр 36.0 сая төгрөгийн үнэтэй УАЗ-22069 маркийн фургон авто машин, Алдархаан сумын Эрүүл мэндийн төвд 40.0 сая төгрөгийн үнэтэй УАЗ-22069 маркийн фургон авто машин , Орон нутгийн хөгжлийн сангаас аймгийн Нэгдсэн эмнэлэгт Grand starex маркийн ойрын түргэн тусламжийн үйлчилгээ үзүүлэх суудлын 2 автомашин, Зоонозын өвчин судлалын төвд Mitsubishi L-200 маркийн автомашин, Тосонцэнгэл сумын Нэгдсэн эмнэлэгт ойрын түргэн туслажийн үйлчилгээнд тоёота pelitr маркийн автомашинаар хангасан байна. Хандив тусламжаар: Тосонцэнгэл сумын Нэгдсэн эмнэлэг УАЗ-22069 маркийн фургон авто машин, Дөрвөлжин сумын Эрүүл мэндийн төв Nissan krovap маркийн суудлын автомашин, нийт 2021 онд 8 ширхэг 252.0 сая төгрөгийн авто машины парк шинэчлэлт хийгдсэн байна.	100
	2.1.1.8	Улиастай, Тосонцэнгэлийн нэгдсэн эмнэлэгт шаардлагатай тасаг, нэгжийг байгуулна	2021-2024	ЭМГ, АЗДТГ	30.0	14	14	Тосонцэнгэл сумын Нэгдсэн эмнэлэгт "гемодиализийн тасаг"-ийг байгуулж гемодиализийн 2 зом аппаратаар ханган, эмч, сувилагчийг мэргэшүүлэн төрийн сангийн зардлаар сурган, үйл ажиллагааг явуулж байна. 2021 оны 11 дүгээр сарын байдлаар 1 өвчтөн диализийн аппаратанд тогтмол орж байна.	100

2.1.1.9	Эрүүл мэндийн байгууллагуудыг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана.	2021-2024	ЭМГ, АЗДТГ	450.0	10	15	Эрүүл мэндийн сайдын 2021 оны 01 дүгээр сарын 20-ний өдрийн А/122 тушаалын дагуу аймгийн Нэгдсэн эмнэлэгт амьсгалын аппарат 3, хүчилтөрөгчийн баллон, чийгшүүлэгч урсгал тохируулагч, редуктор 5, зэрэг 11 нэр төрлийн 70.2 сая төгрөгийн эмнэлгийн тоног төхөөрөмж, Тосонцэнгэлийн Нэгдсэн эмнэлэгт амьсгалын аппарат 2, диализийн аппарат 1, нийт 14 нэр төрлийн 224.3 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн байна. Тосонцэнгэл сумын Нэгдсэн эмнэлэгт унтуулгын аппарат, биоаюулгүйн шүүгээ, Аймгийн Нэгдсэн эмнэлэгт унтуулгын аппарат, хүчилтөрөгч өтгөрүүлэгч 4 ширхэг, биоаюулгүйн шүүгээ, Нөмрөг сумын Эрүүл мэндийн төвд 3D эхо, Сантмаргаз сум биохимийн анализатор аппарат, Цэцэн-уул, Алдархаан, Сантмаргаз, Цагаанхайрхан, Ургамал, Идэр сумдад Хүчилтөрөгч өтгөрүүлэгч аппарат Тэс, Тэлмэн суманд цусны дэлгэрэнгүй шинжилгээний аппараттаар тус бүр хангаж 523.1 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийсэн байна. Гадаадын хандив тусламжаар: Азийн хөгжлийн банкны ЭТСХХ-5 нэмэлт төслийн санхүүжилтээр Ларингоскоп 2, Сүвэн -Уул ХХК-с, ТНЭ,Түдэвтэй, Алдархаан, Цэцэн-Уул, Идэр, Завханмандал, Цагаанчулуут, Отгон СЭМТөвүүдэд 6 нэр төрлийн 15,3 сая төгрөгийн тоног төхөөрөмж багаж хэрэгсэл, НҮБХСангаас Их-Уул, Шилүүстэй СЭМТ, АНЭ, ТНЭ-үүдэд 6 нэр төрлийн нийт 111.2 сая төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлэгдсэн. Хандиваар: АНЭ-т Биоаюулгүйн шүүгээ 1, хүчил төрөгч өтгөрүүлэгч 2, Идэр ЭМТ –д Биохимийн хагас анализатор 1, Асгат ЭМТ-д хүчилтөрөгч өтгөрүүлэгч 1, нийт 24.4 сая төгрөгийн эмнэлгийн тоног төхөөрөмж, эд хогшил, Тэс суманд 6 нэр төрлийн 4,2 сая төгрөгийн эмнэлгийн тоног төхөөрөмж багаж хэрэгсэлээр тус тус хангагдсан байна.	100
2.1.1.10	Эрүүл мэндийн бодлого хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох бодлогын зөвлөлийг байгуулж ажиллуулна.	2021-2024	ЭМГ, АЗДТГ	2.0	0	1	Аймгийн хэмжээнд эрүүл мэндийн бодлого, хөгжлийн чиг хандлага тодорхойлох бодлогын зөвлөлийг аймгийн Эрүүл мэндийн газарт байгуулан, салбар дундын хамтын ажиллагааг өргөжүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.	0
2.1.1.11	Рашаан сувиллын үйлчилгээний чанарыг сайжруулахад дэмжлэг үзүүлнэ.	2021-2024	ЭМГ, АЗДТГ	3.0	20.0	0.0	Отгонтэнгэр рашаан сувилал нь чанартай эмчилгээ үйлчилгээг үзүүлэх, рашаан сувиллын дэд бүтцийг хөгжүүлэх, ашиглалтын техник, тоног төхөөрөмжийг шинэчлэн хөрөнгө оруулалт хийж сувиллыг өргөтгөх, технологийн шинэчлэл хийх, сэргээн засварлах улмаар амарч сувилуулах таатай нөхцлийг бүрдүүлэх зорилгоор сувиллын газрын гал тогоо, амрагчдын 1-р байр, эмнэлгийн барилгын засварын ажлыг эхлүүлж, шавар эмчилгээний байрны чанарыг сайжруулахад нийт 926.7 сая төгрөгийн санхүүжилт зарцуулсан. 3 дугаар улирлын байдлаар амралт, сувилалын үйлчилгээнд 312 иргэн хамрагдсан байна.	100
2.1.2.1	Зөнхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчний гаралтыг бууруулна.	2021-2024	ЭМГ, АЗДТГ	0.0	7269.2	7200	Аймгийн ЭМАШТУ-ний түвшинд ДЭМБ-ын ХБӨ/ЗСӨ-ий урьдчилан сэргийлэлт, хяналтын нэн шаардлагатай тусламж, үйлчилгээний багц (PEN/HEARTS)-ыг нэвтрүүлэх талаар эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн мэдлэг, дадлыг дээшлүүлэхэд чиглэсэн сургалтыг зохион байгуулан, өрх, сумын 50 эмч хамрагдсан. "Халдварт бус өвчинтэй тэмцэх" үндэсний дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн хүрээнд: Артерийн гипертензийн үзлэгт 47311 хүн хамрагдахаас 15830 иргэн хамрагдаж 33.4%, чихрийн шижин хэв шинж 2 өвчнийг эрт илрүүлэх үзлэгт 13850 иргэн хамрагдаж 29%, хөхний хорт хавдрын эрт илрүүлэгт 3456 иргэн хамруулахаас 3379 иргэн хамрагдаж 97.7%, умайн хүзүүний хорт Хавдрын эрт илрүүлэгтэнд 5262 иргэн хамрагдахаас 1938 иргэн буюу 37% хамрагдсан байна. Глобал сан болон Засаг даргын дэмжлэгтэйгээр аймгийн 24 суманд "халдварт болон халдварт бусын үзлэг"-ийг зохион байгуулахаар төлөвлөж 7 (Тосонцэнгэл, Их-уул, Түдэвтэй, Асгат, Баянтэс, Баянхайрхан, Тэс) суманд үзлэг зохион байгуулан давхардсан тоогоор 7649 иргэн хамрагдаж зорилтот хүн амын 15 хувь байна. Үзлэгийн үр дүнд элэгний хавдар-4, хавдар төст- 4, нүдний болор цайлт-24, бөөр болон цөсний хүүдийн хавдар төст өөрчлөлт-2, Зүрхний ишеми-2, Артерийн даралт ихдэлт-59 Чихрийн шижин-31, Умайн хүзүүний хавдар-3, хавдрын урьдал-52, хөхний үүсгэвэр-4, Тэмбүү-3, Сүрьеэгийн магадлалтай тохиолдол-3 илэрч, нийт цэрний шинжилгээг 36 хүнээс авч нян судлалд илгээсэн, уушгины хавдар төст өөрчлөлт-4 тус тус илрүүлж, дараагийн шатлалд шилжүүлж, эмчилгээ, оношилгооны асуудлыг шийдвэрлэсэн. 10 дугаар сарын байдлаар сүрьеэгийн 25 тохиолдол бүртгэгдэж, уушгины бус 7, уушгины 18 байна. Уушгины түрхэц зэрэг тохиолдлуудын сөрөгт шилжилт 80 хувь байна. Эдгэрэлтийн түвшин 100, уушгины сүрьеэгийн оношийн баталгаажилт 78.5 хувь байна.	70
2.1.2.2	Эрүүл мэндийг дэмжигч байгууллагуудын тоог нэмэгдүүлнэ	2021-2024	ЭМГ, АЗДТГ	8.0	83	88	Эрүүл мэндийг дэмжигч байгууллага, Эрүүл ажлын байр шалгаруулах ЭМС-ын 2017 оны А/472 –р тушаалын дагуу 7 сумын 20 байгууллагад цахимаар сургалт, мэдээлэл хийснээр ЭМДБ-д 24, ЭАБ-нд 8 байгууллага тайлангаа ирүүлсэн. Шалгаруулалтыг хийж гэрчилгээжүүлэн урамшуулах ажлыг төлөвлөгөөний дагуу зохион байгуулж байна. Шалгаруулалтын 2 дугаар шатыг зохион байгуулан үр дүнг тооцоход урьдчилсан байдлаар 21 байгууллага болзолыг хангаснаар аймгийн хэмжээнд "Эрүүл мэндийг дэмжигч" 89 байгууллага байна. Эрүүл мэндийг дэмжигч байгууллага, Эрүүл ажлын байр шалгаруулах үйл ажиллагаанд аймгийн Засаг даргын 2021 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн А/430 дугаар захирамжаар аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 5.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.	100

Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.	2.1.2.3	Иргэдэд эрүүл мэндийн мэдлэг олгох сургалт, сурталчилгааг тогтмол зохион байгуулна	2021-2024	ЭМГ, АЗДТГ	5.0	70%	72%	НЭМҮТ-с зохион байгуулсан КОЙКА-гийн эрүүл мэндийн мэдлэг хуваалцах сургалтад Ерөнхий боловсролын 12 сургуулийн эрүүл мэндийн багшийг хамруулж сургалтын 5 төрлийн хичээлийн материалыг тухайн багш нарт хүргүүлж, анхан шатны байгууллагуудын нийгмийн эрүүл мэнд хариуцсан мэргэжилтнүүдэд түгээсэн. Эрүүл мэндийн яам ДЭМБ-ын дэмжлэгтэйгээр баруун аймгуудаас Завхан аймагт "МонПэн" төслийг хэрэгжүүлэхээр шийдвэрлэж арга зүйн сургалтыг зохион байгуулан нийт 23 сум, 3 өрийн эрүүл мэндийн төв, ЭМГ, НЭ, ЗДТГ, ЭМДХ-ийн 50 эмч мэргэжилтэнг 4 өдрийн танхимын сургалтад хамруулан шаардлагатай эм эмнэлгийн хэрэгсэл, сургалтын баг гарын авлага, сүүлийн үеийн өндөр хүчин чадал бүхий суурин компьютер, ширээ сандал бүхий 150 сая төгрөгийн санхүүжилтыг ДЭМБ-с нийлүүлсэн. AIR 1 телевизтэй хамтран гар угаах, амны хаалт зүүх, зай барих сургалтыг хүүхдэд ойгомжтой тогтоомын аргаар зааж богино хэмжээний дүрс бичлэг бэлтгэн зорилтот бүлгийн 17 хүүхдэд цахимаар зааж цайны материалыг түгээж дүрс бичлэгийг байгууллагын цахим хаягаар дамжуулан аймгийн хэмжээнд фэйс бүхийн 16 бүлэгт хуваалцаж өссөн дүнгээр 26154 хандалт авсан. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, соёлын төвийн удирдлагуудад зориулсан "Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, Хичээл-үйл ажиллагаа эхлүүлэх бэлэн байдлыг хангах нь" сэдэвт цахим сургалтыг аймгийн ЗДТГ, БСУГ-тай хамтран зохион байгуулж аймгийн хэмжээний сургууль, цэцэрлэг, соёлын төвүүдийн захирал, эрхлэгч нарыг бүрэн хамруулсан. Сургалтад 100 гаруй хүн хамрагдаж, Ковид 19 халдвараас сэргийлэх, гар угаах, маскаа зүүх, Ковид 19 халдварын үед суралцагчдын нийгэм сэтгэл зүйг дэмжих, Халад бүхий хувийн хамгаалах хэрэгсэл өмсөх, тайлах зэрэг 6 төрлийн 306 ширхэг зурагт хуудас тараасан.	100
	2.1.2.4	Хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлсэд тандалт судалгаа хийнэ	2021-2024	ЭМГ, АЗДТГ	1.0	1	1	Улаан хоолой, ходоодны хорт хавдрын эрсдэл, түүнээс сэргийлэх аргын талаарх мэдлэгийг үнэлэх мөн эрсдэлт хүчин зүйлс урьдчилан сэргийлэлт, оношилгоо, эмчилгээнд хандаж буй хандлага, дадал үнэлгээ өгөх зорилгоор аймгийн 17-80 насны 100 хүнийг санамсаргүй түүврийн аргаар хамруулсан ба олон нийтийн сүлжээ ашиглан мэдээллийг цуглуулан судалгаа хийхэд аймгийн иргэдийн дунд улаан хоолой, ходоодны хорт хавдрын талаарх мэдлэг, түүнд хандах хандлага, дадлын түвшин дундаж байна. Судалгаанд хамрагдсан иргэдэд нөлөөллийн үйл ажиллагаа явуулсны дараа иргэдийн мэдлэг 30.2%, хандлага 6.2%, дадал 7.7%- иар тус тус өссөн ба мэдлэг, хандлага, дадлын түвшин хангалтгүй байсан иргэдийн мэдлэг 7.2%, хандлага 1.6%, дадал 7.2%- иар буурсан байна. Судалгаанд хамрагдагсдын хандлага, дадал мэдлэгийн түвшинтэй хамааралтай байгаа тул цаашид энэ талын мэдлэг олгох сургалт, сурталчилгааны ажлуудыг улам эрчимжүүлэх улаан хоолой, ходоодны хорт хавдраас хэрхэн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэгт цаг алдалгүй хамрагдах талаар хүн амын мэдлэгийг дээшлүүлэх нь хавдрын шалтгаант нас баралтыг бууруулах зөв хандлага, дадал хэвшүүлэхэд чухал ач холбогдолтой юм.	100
	2.1.2.5	Нийгмийн эрүүл мэндийн үеийн хариу арга хэмжээний бэлэн байдлыг бэхжүүлнэ	2021-2024	ЭМГ, АЗДТГ	2500	178.8	2500	Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн хариу арга хэмжээний бэлэн байдлын төлөвлөгөөг боловсруулан батлуулан, тухай бүрт тодотгол хийж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 2021-03-03-ны өдөр Завхан аймгийн Шилүүстэй сумд Коронавируст халдвар (Ковид-19)-ын халдварын тохиолдол анх бүртгэгдсэн. 2021-10-31-ны өдрийн байдлаар 11057 иргэн батлагдаж 10421 иргэн эдгэрсэн, нийт ПГУ-н шинжилгээг 29007 иргэнд, түргэвчилсэн шинжилгээг 36881 иргэнд тус тус хийсэн байна. Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангах хүрээнд ОНХС-аас 13 нэр төрлийн хувийн хамгаалах хувцас хэрэгсэл 74.3 сая, 3000 ширхэг оношууур-53.0 сая, 15 нэр төрлийн 300 гаруй сая төгрөгийн 86 сая төгрөгийн тоног төхөөрөмж 3 автомашин зэрэг хөрөнгө оруулалт хийгдсэн. Ковид-19 цар тахлын үед ажилласан эмч, эмнэлгийн ажилчдын илүү цагийн нэмэгдэлд 24 сумын 851 эрүүл мэндийн ажилтанд-190.2 сая төгрөг зарцуулсан байна. Орон нутгийн хөгжлийн сангаас 22 эмч мэргэжилтэнд тус бүр 1.0 сая нийт 22.0 сая төгрөгийн урамшуулал олгосон.	100
	2.1.2.6	"Эрүүл, идэвхтэй амьдрал" арга хэмжээ	2021-2024	ЭМГ, АЗДТГ	0.0	0	30	Эрүүл мэндийн яам, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвөөс жил бүр зохион байгуулдаг архи, согтууруулах ундааны хэрэглээг иргэдийн дунд бууруулах эрүүл мэнд, эдийн засаг, нийгэмд үзүүлэх хор уршгаас сэргийлэх мэдээлэх зорилгоор үндэсний хэмжээний "Архигүй амьдралыг цогцлоо" аяныг 2021 оны 7 дугаар сарын 01-нээс 10 дугаар сарын 01-ний хооронд зохион байгуулан, "Архигүй ажлын байр" уралдааныг зохион байгуулж туг болон дэвтрийг байгууллагуудаар 8 дугаар сарын 10-аас 10 дугаар сарын 01-ний хооронд аялуулан, албан байгууллагуудад архинаас шалтгаалсан ажил таслалт буурч, аянд оролцсон байгууллагууд дотооддоо архи согтууруулах ундааны хор уршгийн талаар нийт 15 удаагийн сургалт хийсэн. Тамхины хэрэглээг бууруулах, тэглэх хүчин чармайлтыг идэвхижүүлэх КОВИД-19 цар тахлын үед амьсгалын замын болон зүрх судасны өвчлөлөөс сэргийлэх, дам тамхидалтаас хойч үеэ хамгаалах, шинэ санаачлагыг дэмжих, харилцан туршлага судлах зорилгоор "ТАМХИДАЛТЫН ЭСРЭГ ХУВЬСГАЛ-2" мэдээлэл, сургалт сурталчилгааны талаарх цахим сургалтыг ЗДТГ, Улиастай сум, аж ахуй нэгжийн төлөөллийн дунд зохион байгуулсан. Дэлхийн алхалтын өдрийг тохиолдуулан "Эрүүл мэндийнхээ төлөө- Алхангаа ярилцъя" сэдэвт арга хэмжээний хүрээнд "Дагсал хөдөлгөөн хийцгээ" нэг сарын аян зохион байгуулан, "Старва" аппликейшн дээр "Zavkhan Running 2021" гүрл нээж 630 хүнийг хамруулсан байна.	100

2.1.2.7	"Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх" арга хэмжээ	2021-2024	ЭМГ, АЗДТГ	5.0	0	30	<p>Дархлаажуулалтын бүрэн тунгийн хамралт өмнөх онтой харьцуулахад 1.2%-аар өссөн байна. Вакцин тус бүрээр: БЦДЖ – 98.3%, Халдварт саагийн эсрэг вакцин – 99.5%, Тавт вакцин – 99.5 %,В вирус гепатитын эсрэг вакцин – 98.4%, А вирус гепатитын эсрэг вакцин – 99.6%, УГУ эсрэг вакцин – 99.6% хамралттай байна. Харьяаллын 3 хүртэлх насны хүүхдийн бүртгэлийг шинэчлэх, түр оршин суугч, бүртгэлгүй хүүхдийг бүртгэлжүүлэх цахим бүртгэлийн программыг нэвтрүүлэх бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Цагаанчулуут сумын ЭМТ-ийн МК-074 маркийн хөргөгчийг ХӨСҮТ-ээс хүлээн авсан. Эрүүл мэндийн газарт 220V-ийн хүчин чадал бүхий тогтворжуулагч 3-ийг авч, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг ханган ажилласан. Томуугийн эсрэг вакцинаар 1150 эмч эмнэлгийн ажилчдыг дархлаажуулж, сайн дурын дархлаажуулалтаар 0-15 насны 373 хүүхэд, жирэмсэн, өндөр настан, архаг хууч өвчтэй 450 хүн дархлаажуулсан байна. Томуу, томуу тест өвчлөлтэй холбоотой 0-5 насны хүүхэдэд 11 нэр төрлийн 16,7 сая төгрөгийн эмийг хөнгөлөлттэй жороор олгосон. Хүн амын үндны усны талаарх мэдлэг, хандлага, дадлыг үнэлэх судалгааны ажлыг АШҮҮИС-тай хамтран хийж, нийт 2520 насанд хүрэгч, хүүхдээс асуумж судалгаа авч, 1262 айлын үндны ус болон усны савны эрүүл ахуйн байдлыг үнэлж, лабораторийн шинжилгээ хийсэн. Аймгийн хэмжээнд сүрьеэгийн нийт 25 тохиолдол бүртгэгдэн, үүнээс уушгины бус 7, уушгины 18, уушгины түрхэц эерэг тохиолдлуудын сөрөгт шилжилт 80% байна. Эдгэрэлтийн түвшин 100%, уушгины сүрьеэгийн оношийн баталгаажилт 78.5% байна. Глобал сан болон Засаг даргын тамгын газрын дэмжлэгтэйгээр Завхан аймгийн 24 суманд Халдвар болон халдварт бусын үзлэг зохион байгуулахаар төлөвлөж 7 суманд үзлэг зохион байгуулан нийт 1800 иргэнд үзлэг хийн 3 сүрьеэгийн сэжигтэй тохиолдол илрүүлж 1 онош батлагдан эмчилгээнд хамруулсан. "Зөв ханиаж найтааж хэвшье" 3 сарын аяныг эрүүл мэндийн байгууллагуудын дунд өрнүүлж, давхардсан тоогоор 6480 иргэн сургалтад хамрагдаж, 4500 гарын авлага тараасан байна. Аянд ЕБС-ын сурагчдад цэгэн илгээ хийхийн ач холбогдол, содын уусмал ашиглан ам зайлах аргуудыг зааж сургасан. Эрүүл мэндийн байгууллагуудын цахим хуудсанд "Сүрьеэ эдгэрдэг өвчин" видео мэдээллийг байршуулан,1467 хандалт хийж, иргэд олон нийтийг мэдээлээр хангасан.</p>	70
2.1.2.8	"Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд" арга хэмжээ	2021-2024	ЭМГ, АЗДТГ	0.0	0	30	<p>Эрүүл мэндийн сайдын 2020 оны 06 сарын 04-ны өдрийн А/318 дугаар тушаал, Эрүүл мэндийн газрын даргын 2020 оны 01 сарын 09-ний өдрийн "Жирэмсэн болон төрсөн эхчүүд, нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн нэрийн хяналт хийх журам"-ын дагуу сар бүрийн 01, 15-ны өдөр жирэмсэн эмэгтэйчүүдийн мэдээг харьяа эрүүл мэндийн байгууллагуудаас авч нэгтгэн хяналт тавин ажиллаж байна. 2021 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар орон нутгийн хэмжээнд нийт 519 жирэмсэн эмэгтэйчүүд хянагдаж байгаагаас өндөр эрсдэлтэй 222 жирэмсэн байна. Нэрийн хяналтыг сайжруулах, аймгийн нэгдсэн эмнэлэг, сум, өрхийн эрүүл мэндийн төвийн хамтран ажиллах уялдаа холбоог чанаржуулах зорилгоор 2021 оны 10 дугаар сарын 12-ны өдөр "Өндөр эрсдэлтэй жирэмсэн эхийн нэрийн хяналтыг нэвтрүүлэх нь" цахим хэлэлцүүлгийг АНЭ-тэй хамтран зохион байгуулсан. Эх барих эмэгтэйчүүдийн зөвлөх эмч, эх барихын мэргэжилтэнтэй хамтран 23 сумын эх баригч нартай ZOOM-р холбогдож, жирэмсний хяналтыг сайжруулах, эрсдэлтэй жирэмсэн эхийг хянах талаар зөвлөгөө сургалт зохион байгуулсан. Умайн хүзүүний эсийн шинжилгээнд хамрагдах, Дотоод агаарын бохирдлоос сэргийлэх чиглэлээр Угаарын хийн хордлого, Эх хүүхдийг Дам тамхидалтаас сэргийлэх зарлал, мэдээлэл сурталчилгааг цахим хуудсаар дамжуулан түгээж байна. 2021 оны 10 дугаар сарын 25-ны өдөр хүний эрхийн үндэсний комисстой хамтран "Нөхөн үржихүй хүний эрх болох нь" сэдэвт сургалтыг АНЭ,ЭМГ, ӨЭМТ-ийн нийт 15 эмч, эрүүл мэндийн ажилтнуудад зохион байгуулсан. Жирэмсэн болон хөхүүл эх, 6-23сартай хүүхдийн олон найрлагат бичил тэжээлийн бэлдмэлийг давхардсан тоогоор 742 жирэмсэн эмэгтэйд 21246 ширхэг, 853 хөхүүл эхэд 19594 ширхэг, 6-23сартай 3146 хүүхэдэд 3146ширхэгийг тус бүр тарааж зөвлөгөө өгсөн байна. Завхан аймгийн "Залуус" хөтөлбөрийн хүрээнд балгийн цоцг боловсрол олгох "Үе тэнгийн сурагч" бэлтгэх сургалтанд нийт 25 сурагч бэлтгэгдсэн бөгөөд эрэгтэй 3, эмэгтэй 22 сурагч хамрагдсан. Сарын тэмдгийн эрүүл ахуйн өдөр, Эхийн сүүгээр хооллолтыг дэмжих 7 хоног, Хүүхдийн хорт хавдраас сэргийлэх өдрүүлэх орон нутгийн AIR1, ШЗТ-үүдээр дамжуулан 6 төрлийн шторкыг тус бүр 10 хоног нийт 3462 удаагийн цацалтаар олон нийтийн хүртээл болгосон.</p>	70
2.1.2.9	"Хавдрын эсрэг" арга хэмжээ	2021-2024	ЭМГ, АЗДТГ	0.0	0	30	<p>Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан "Хавдрын эсрэг" арга хэмжээний (2021-2024 он) төлөвлөгөө Эрүүл мэндийн сайдын 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн А/360 дугаар тушаалаар батлагдсан төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Аймгийн Засаг даргын 2021 оны 10 дугаар сарын 28-ний өдрийн А/427 дугаар захирамжаар "Халдварт болон халдварт бус өвчний эрт илрүүлэг үзлэгийг" 2021 оны 10 дугаар сарын 29-ны өдрөөс 11 дүгээр сарын 04-ний хооронд Глобал сан болон аймгийн Засаг даргын Тамгын газрын санхүүжилтээр үзлэгийг зохион байгуулан, үзлэгийн үр дүнд элэгний хавдар-4, хавдар төст- 4, Умайн хүзүүний хавдар-3, Хавдрын урьдал-52, хөхний үүсгэвэр-4 илэрсэн байна. Аймгийн хэмжээнд Хавдрын хяналтад 659 иргэн хянагдаж байна. Шинээр оношлогдсон элэгний хавдар-52, ходоодны хавдар-34, улаан хоолойн хавдар- 12, уушгины хавдар-9,умайн хүзүүний хавдар-7 байна. Хавдрын шалтгаант нас баралт-117 үүнээс элэгний хавдар -41, ходоодны хавдар- 31, улаан хоолой хавдар- 10, уушгины хавдар-7, умайн хүзүүний хавдар-4, бусад- 24 байна.</p>	70

	2.1.2.10	"Элэг бүтэн Монгол" арга хэмжээ	2021-2024	ЭМГ, АЗДТГ	0.0	56.5	70	Элэг бүтэн Монгол хөтөлбөрийн хүрээнд 2019 онд 50740 иргэн хамрагдахаас 15-39 насны 13372, 40-65 насны 15316 буюу нийт 29788 иргэн хамрагдаж, хамралт 58,7%, мөн эрүүл мэндийн даатгалгүй 1028 иргэн хамрагдсан. В вирусн халдвартай 3026, С вирусн халдвартай 2538, хавсарсан халдвартай 179 иргэн байна, 1912 иргэн ачаалал тоолох шинжилгээнд хамрагдаж, 176 иргэн С вирусн эмчилгээнд, 251 иргэн В вирусн эмчилгээнд хамрагдсан. С вирусн эмчилгээнд хамрагдалт 6,6%, В вирусн эмчилгээнд хамрагдалт 5,8% байна. Эрүүл мэндийн даатгалын сангаас С вирусн эмийн хөнгөлөлтөд 37 иргэнд 7,9 сая төгрөг, В вирусн эмийн хөнгөлөлтөд 551 иргэнд 25,9 сая төгрөг, нийт 33,8 сая төгрөгийг олгосон байна. Элэгний хорт Хавдрын эрт илрүүлэг үзлэгт 9550 иргэн хамрагдаж 65 тохиолдол шинээр оношлогдсон, үүнээс ЭХО оношилогоонд 8000 иргэн хамрагдаж, орон нутагт 9 хавдар оношилсон. Коронавирусын халдварын улмаас 2021 онд альфафетопротейн тодорхойлох, PIVIKA үзэх онош баталгаажилт хийгдээгүй байна. Халдварыг түргэвчилсэн оношуураар илрүүлж, APRI үнэлгээг үнэлж, дараагийн шатлалд фиброскан,эластография хийлгэн хяналтанд авч байна. Аймгийн хэмжээнд элэгний хатууралтай 47 өвчтөн байнгын хяналтанд байна.	70
	2.1.2.11	"Харшлаас сэргийлэх" арга хэмжээ	2021-2024	ЭМГ, АЗДТГ	5.0	0	30	Аймгийн нэгдсэн эмнэлэг, Тосонцэнгэл сумын нэгдсэн эмнэлэгт арьс, харшлын 3 эмч ажиллаж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг иргэдэд үзүүлэн 2021 оны 10 дугаар сарын байдлаар 2496 иргэнд арьс, харшлын үзлэг хийж тусламж үйлчилгээг үзүүлсэн байна. Халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх эрт илрүүлэг, үзлэгийг зохион байгуулах арга хэмжээний хүрээнд 296 иргэнд арьс, харшлын үзлэг хийгдэж, төрөлхийн арьсны эмгэгтэй 1 хүнийг илрүүлэн эмчилж байна.	50
	2.1.2.12	"Эрүүл чийрэг эр хүн" арга хэмжээ	2021-2024	ЭМГ, АЗДТГ	5.0	0	30	Урологийн чиглэлээр 1, андрологийн чиглэлээр 2 эмч тус тус бэлтгэгдсэн. Аймгийн Нэгдсэн эмнэлэгт эрэгтэйчүүдийн кабинет байгуулахад шаардлагатай санхүүгийн болон бусад судалгаа хийгдэж байна. 2021 оны 10 дугаар сард НҮБ-н Хүүхдийн сангийн дэмжлэгтэйгээр Эрүүл мэндийн газар, Улиастай сумын Ерөнхий боловсролын сургуулиуд хамтран өсвөрийн "Үе тэнгийн сургагч" бэлтгэх төслийг хэрэгжүүлэн, бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол олгох "Үе тэнгийн сургагч" 25 сурагч багш бэлтгэсэн. Хүний эрхийн үндэсний комисстой хамтран "Нөхөн үржихүй хүний эрх болох нь" сэдэвт сургалтыг эмч, эрүүл мэндийн ажилтнуудад зохион байгуулсан сургалтаар эрэгтэйчүүд ба нөхөн үржихүйн эрх сэдвээр мэдээлэл хийсэн.	30
Оношилгоо, эмчилгээний дэвшилтэд технологийг нэвтрүүлнэ	2.1.3.1	Аймгийн Нэгдсэн эмнэлгийг түшиглэн хүчилтөрөгчийн бэсрэг үйлдвэр байгуулна	2021	ЭМГ, АЗДТГ	270.0	0	1	Улсын төсвийн 290.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Аймгийн нэгдсэн эмнэлэгийн хүчилтөрөгчийн бэсрэг үйлдвэрийг 2021 оны 08 дугаар сарын 13-нд "Ньюterra вокс" ХХК барьж гүйцэтгэн ашиглалтанд хүлээлгэн өгсөн. Халдварын тасагт Коронавируст халдварын цар тахалтай холбоотойгоор хүчилтөрөгчийн хэрэгцээ шаардлага нэмэгдэж өдөрт 17-18 баллон хүчилтөрөгчийг зөөвөрлөн ашиглаж байна. Шилүүстэй, Идэр, Цагаанхайрхан, Цагаанчулуут сумын эрүүл мэндийн төвүүд хүчилтөрөгчийн баллоныг цэнэглэн ашиглаж байна.	100
	2.1.3.2	Лавлагаа шатлалд хийгддэг оношилгоо, эмчилгээг аймгийн Нэгдсэн эмнэлэгт нэвтрүүлнэ.	2021-2024	ЭМГ, АЗДТГ	1000.0	2	2	Аймгийн Нэгдсэн эмнэлгийн хүүхдийн тасагт дутуу нярайн сурфактант эмчилгээг 6 нярайд хийж, 3 нярайн эмчилгээг амжилттай хийсэн. ШУГТЭ-н зүрхний төвтэй хамтран цусанд тропинин I, NT pro-BNP, D Dimer-ийг тодорхойлох аргыг 2021 оны 1 дүгээр сараас "Онош зүйн" тасагт нэвтрүүлэн, нийт 46 өвчтөнд оношилгоо хийсэн. Аймгийн Нэгдсэн эмнэлэгт PCR шинжилгээний аппарат, бусад дагалдах хэрэгслүүдийг суурилуулан, 05 дугаар сарын 01-ны өдрөөс PCR шинжилгээг хийж байна. Аймгийн хэмжээнд нийтдээ 29475 иргэнд ПГУ-н шинжилгээнд хамруулсан байна. Тосонцэнгэл сумын хөдөөгийн нэгдсэн эмнэлэгт гемодиализийн тасгийг байгуулж, мэргэжлийн хүний нөөцөө / их эмч, сувилагч / төрийн сангаар сургаж байна. Өнөөдрийн байдлаар 1 өвчтөн диализийн аппаратад тогтмол орж байна.	100
	2.1.3.3	Мобайл технологийг өргөжүүлэн, үйл ажиллагааг эрчимжүүлнэ	2021-2024	ЭМГ, АЗДТГ	30.0	3	10	Аймгийг хөгжүүлэх 2021 оны төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлсэн. Мобайл технологийн тоног төхөөрөмж, урвалж бодисыг ханган нийлүүлэх төндөрийн үйл ажиллагааг аймгийн Орон нутгийн өмчийн газар дээр зохион байгуулсан. "Ашид-Буян"ХХК шалгарч, Их-Уул сумын эрүүл мэнд төвд тоног төхөөрөмжийг урвалж бодисын хамт нийлүүлсэн байна.	100
Эрүүл мэндийн салбарын хүний нөөц, нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлнэ	2.1.4.1	"Чадварлаг эмч" арга хэмжээг хэрэгжүүлнэ	2021-2024	ЭМГ, АЗДТГ	5	0	100	Аймгийг хөгжүүлэх 2021 оны төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлсэн. 2021 онд "Чадварлаг эмч" арга хэмжээг боловсруулах ажлын хэсгийг аймгийн Засаг даргын захирамжаар байгуулан ажилласан. Хэлэлцүүлгийг үе шаттай зохион байгуулан иргэд, ахмад мэргэжилтэн, салбарын эмч ажилчид, төрийн бус байгууллага, иргэдийн саналыг авч боловсруулан аймгийн Засаг даргын Зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн. Хурлаас дэмжигдсэн 4 зорилт 35 арга хэмжээ бүхий төлөвлөгөөг аймгийн Засаг даргын 2021 оны 07 дугаар сарын 07 ны өдрийн А/4 дугаар захирамжаар баталж Эрүүл мэндийн салбарт хүргүүлэн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	70

Эрүүл мэндийн даатгалын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ	2.1.5.1	Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, журмыг иргэдэд сурталчилна	2021-2024	ЭМГ, АЗДТГ	0	0	10	Танхимын сургалтыг Эрүүл мэндийн тухай хууль, Шинээр батлагдсан болон нэмэлт өөрчлөлт оруулсан ЭМДҮЗ-ийн 03, 13, 04, 05, 13, 19 дүгээр тогтоол, тушаал, журмыг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх ажлыг тасралтгүй зохион байгуулж нийт 16 байгууллагын 720 гаруй ажилтан албан хаагчдад, цахим сургалтыг 24 сумын 69 Эрүүл мэндийн байгууллагуудын удирдлага, албан хаагчдад 4 удаа хийж давхардсан тоогоор 1032 ажилтан хамрагдсан байна. Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн Facebook хуудасны хандалтын тоог нэмэгдүүлж ЭМДЕГ-аас гаргасан мэдээ мэдээллийг орон нутгийн хамгийн олон дагагчтай 6, эрүүл мэндийн байгууллагын 5 facebook групп, чатад байршуулж 780 шэйр хийж хандалт 11340 байна.	70
	2.1.5.2	Эрүүл мэндийн даатгалын байгууллагыг чадавхжуулна	2021-2024	ЭМГ, АЗДТГ	0	0	1	Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд өөрчлөлт орсноор эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 13, 03,04,05 дугаар тогтоолын хүрээнд Эрүүл мэндийн даатгалын хэлтсийн дарга, мэргэжилтнүүд давхардсан тоогоор 14 удаагийн цахим сургалтанд хамрагдсан. Эрүүл мэндийн санхүүжилтийн шинэчлэл, стратегийн худалдан авалт, эмнэлгийн хагас бие даасан байдлыг бэхжүүлэх чиглэлээр төрийн болон орон нутгийн өмчит эрүүл мэндийн байгууллагын удирдлагын багийн сургалтанд, Азийн хөгжлийн банкны төслөөр Завхан аймагт эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын бүтэц, чиг үүргийн уялдаа холбоог сайжруулах нь сургалтанд хамрагдсан.	90
2.1 ДҮГЭЭР ЗОРИЛТЫН ДҮН									77.24
	2.2	Нийтийн биеийн тамирыг эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, аж төрөх ёсны салшгүй хэсэг болгож, мэргэжлийн спортыг дэмжин, тамирчдын тив, дэлхий, улсын түвшинд өрсөлдөх чадвар, амжилтыг нэмэгдүүлнэ							
Нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлнэ	2.2.1.1	Спортын холбоо, магадлан итгэмжлэгдсэн клуб, сонирхлын бүлгүүдийн үйл ажиллагааг дэмжинэ	2021-2024	БТСГ, АЗДТГ	5.0	35.0	5.0	Улсын аварга шалгаруулах тэмцээнээс 2020 онд 6 төрлөөр 67 медаль авсан 67 тамирчин, дасгалжуулагч багш нарт 3610.000 (гурван сая зургаан зуун арван мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц сангаас хүн бүрийн дансны жагсаалтыг гаргаж, дансаар нь шилжүүлж олгосон. "ОСЛО-2021" бөхийн чөлөөт барилдааны дэлхийн аваргаас хүрэл медаль хүртсэн Яруу сумын харьяат М.Лхагвагэрэл, амжилттай оролцсон Цэцэн-уул сумын харьяат Э.Даваачимэг, Цагаанхайрхан сумын харьяат Д.Отгонжаргал нарт аймгийн Засаг дарга тус бүр 1,0 сая төгрөгийн урамшууллыг олгосон.	100
	2.2.1.2	Зарим суманд биеийн тамирын арга зүйчийг орон тоогоор ажиллуулна	2021-2023	БТСГ, АЗДТГ	0.0	2	3	2021 оны байдлаар Алдархаан, Сантмаргаз, Цагаанхайрхан, Цэцэн-Уул, Шилүүстэй сумдад биеийн тамирын арга зүйч орон тоогоор ажиллаж байна.	50
	2.2.1.3	"Хөдөлгөөн – Эрүүл мэнд" арга хэмжээг хэрэгжүүлнэ	2021-2024	БТСГ, АЗДТГ	5.0	10%	30%	"Хөдөлгөөн -эрүүл мэнд" арга хэмжээг боловсруулан аймгийн Засаг даргын 2021 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 254 дүгээр захирамжаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж, Боловсрол, Эрүүл мэндийн салбарын зөвлөгөөнд танилцуулгыг хийж олон нийтэд түгээж байна.	100
Үндэсний болон мэргэжлийн спортыг хөгжүүлнэ	2.2.2.1	Үндэсний спортыг хөгжүүлж, улсын чанартай уралдаан тэмцээнийг орон нутагт зохион байгуулна	2021-2024	БТСГ, АЗДТГ	0.00	1	0	Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилтийн хүрээнд хүлээгдэж байна.	
	2.2.2.2	Спортын шүүгч, дасгалжуулагчийг бэлтгэж, хүний нөөцийг бэхжүүлнэ	2021-2024	БТСГ, АЗДТГ	0.0	10	10	Спортын шүүгч, дасгалжуулагчийг чадавхжуулах сургалтыг Биеийн тамир спортын улсын хороотой хамтран цахим сургалтыг 4 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор 100 гаруй хүн хамрагдсан. Аймгийн хэмжээнд чөлөөт бөхийн олон улсын мэргэжлийн шүүгч 1, сагсан бөмбөг, гар бөмбөгийн спортын улсын шүүгч 3 ажилладаг.	90
	2.2.2.3	Аймгийн Засаг даргын дэргэд "Өсвөрийн шигшээ баг"-ийг байгуулна	2021-2024	БТСГ, АЗДТГ	0.00	0	9	Аймгийн Засаг даргын 2021 оны 102 дугаар захирамжаар аймгийн Засаг даргын дэргэд "Өсвөрийн шигшээ" багийг жүдо бөх, чөлөөт бөх, волейбол, сагсан бөмбөг, хөл бөмбөг, үндэсний сур, ширээний теннис, цанын спортын төрлөөр байгуулсан	100
	2.2.2.4	Биеийн тамир, спортын байгууллагыг тоног төхөөрөмжөөр хангахад дэмжлэг үзүүлнэ	2021-2024	БТСГ, АЗДТГ	100.0	0	1	Даян мэргэн арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 8 нэгжийг шагайн сургалтын иж бүрэн хэрэглэгдэхүүнээр хангасан.	70
Хүн амд биеийн тамир, спортын үйлчилгээ үзүүлэх төр, хувийн хэвшлийн байгууллагын тоог нэмэгдүүлж, хамтын ажиллагааг сайжруулна	2.2.3.1	Сургууль түшиглэсэн бялдаржуулах төвүүдийг байгуулахад дэмжлэг үзүүлнэ	2021-2024	БТСГ, АЗДТГ	5.0	2	5	Ерөнхий боловсролын зарим сургуулиудад бялдаржуулах төвүүдийг байгууллагын өөрийн хөрөнгөөр байгуулан ажиллаж байна. Аз жаргалтай ажлын байр зорилтот арга хэмжээг байгууллагуудын дунд уралдаан хэлбэрээр зарлан, байгууллага бүр бялдаржуулах төвийг байгуулан ажиллах зорилт дэвшүүлэн ажиллаж байна.	0

Иргэдэд үйлчлэх нийтийн спорт талбайн хүртээмжийг нэмэгдүүлнэ	2.2.4.1	Нийтийн биеийн тамир, соёл амралтын хүрээлэнг өргөжүүлнэ	2021-2024	БТСГ,АЗДТГ	100.0	12	15	2020-2021 онд Улиастай сумын Жавхлантай цогцолбор сургуулийн 640 хүүхдийн шинэ байр, Идэр, Сонгино, Тэлмэн сумын ЕБС-ын 320 хүүхдийн шинэ байрыг спорт заалны хамт төлөвлөж барилгын ажил 40-70 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна. ХААН банкны дэмжлэгтэйгээр Улиастай сумын Жинст багийн 24 айлын гадна талбайд 3х3 сагсан бөмбөгийн стандарт талбайг байгуулсан.	70
Эрүүл зөв хооллох дадал, хэвшлийг бүх нийтэд түгээн дэлгэрүүлнэ	2.2.5.1	Эрүүл, хооллолт, фитнес клуб, сонирхлын бүлгүүдийн үйл ажиллагааг дэмжинэ	2021-2024	БТСГ,АЗДТГ	2.0	3	5	"АМКА DANCE" бүжгийн сургалтын төвийн үйл ажиллагааг дэмжиж аймгийн Засаг даргын нөөц сангаас 3,0 сая төгрөгийн дэмжлэгийг үзүүлсэн. 2021 оны байдлаар 540 иргэн бүжгийн сургалтад хамрагдаж улсын хэмжээний "Цахим гимнастрада" биеийн тамирын арга хэмжээнд ахлах насны хүүхдүүд оролцож байна.	30
Зорилтот бүлгүүдэд чиглэсэн амралт сувиллын газрын үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ	2.2.6.1	Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан хөдөлгөөн заслын кабинет, талбайг байгуулна	2021-2024	БТСГ,АЗДТГ	0.0	200	250	Аймгийн ахмадын хороонд ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан сувилал ажиллаж хөдөлгөөн засал эмчилгээг хийж байна. Хөдөлгөөн- Эрүүл мэнд арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөөний 2 зорилтын хүрээнд аймгийн Нэгдсэн эмнэлгийн хөдөлгөөн засал, хөдөлмөр засал эмчилгээний тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэхээр төлөвлөж 2022 оны аймгийг хөгжүүлэх жилийн төлөвлөгөөнд саналыг тусгасан.	0
Бие бялдарын сорилыг чанартай зохион байгуулж, хамрах хүрээг нэмэгдүүлнэ	2.2.7.1	Аймгийн хэмжээнд бие бялдарын түвшин тогтоох сорилыг бүх шатанд зохион байгуулна	2021-2024	БТСГ,АЗДТГ	0.0	4.5%	10%	2021 оны 11 дүгээр сараас эхлэн сорилыг зохион байгуулахаар төлөвлөн, үйл ажиллагааг эхлүүлсэн.	30
2.2 ДУГААР ЗОРИЛТЫН ДҮН									58.18
2.3		Хүн бүрт чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, боловсролыг хувь хүний хөгжил, гэр бүлийн амьдралын баталгаа, орон нутгийн хөгжлийн суурь болгон, насан туршдаа суралцах тогтолцоог бэхжүүлнэ.							
Хамран сургалтыг нэмэгдүүлнэ	2.3.1.1	Боловсролын хамран сургалтыг нэмэгдүүлнэ	2021-2024	АЗДТГ,БСУГ	2.0	83.7%	84.7%	2021-2022 оны хичээлийн жилд цэцэрлэгийн үндсэн сургалтанд 3749 хүүхэд суралцаж, цэцэрлэгийн хамран сургалт 79.5% , хувилбарт сургалтанд 248 хүүхэд суралцаж, сургуулийн өмнөх боловсролд нийт 3997 хүүхэд хамрагдаж, хамран сургалт 84.7% байна. 2021 онд Баянтэс сумын 100 хүүхдийн цэцэрлэг ашиглалтанд орж, Тосонцэнгэл сумын 3-р цэцэрлэг, Улиастай сумын 1-р цэцэрлэг, Улиастай сумын 9-р цэцэрлэг, Баянхайрхан, Цэцэн-Уул сумын цэцэрлэгийн шинэ барилга ашиглалтанд орсноор хамран сургалт нэмэгдэх нөхцөл бүрдэнэ. Хамран сургалтыг нэмэгдүүлэх зорилгоор цэцэрлэгт хамрагдаж чадахгүй байгаа малчин болон алслагдсан хязгаар бүсэд амьдарч байгаа өрхийн 3-5 насны хүүхдийн судалгаа хийгдэж байна."Ковид-19" цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалж 4,5 настай хүүхдүүд цэцэрлэгт хамрагдаж 3 настай хүүхэд зайнаас суралцаж байна.2021-2022 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын 29 сургууль, СУИС-ийн харьяа хөгжим бүжгийн коллеж нийт 30 сургуульд 631 бүлэгт 15767 хүүхэд суралцаж байна.Бага боловсролын хамран сургалт 95.1%, суурь боловсролын хамран сургалт 94.0% байна.	100
	2.3.1.2	Тусгай хэрэгцээ шаардлагатай хүүхдийг боловсролын үйлчилгээнд тэгш хамруулна	2021-2024	АЗДТГ,БСУГ	10	30%	35%	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын хурлаар 2021 онд 0-16 насны 104 хүүхэд хөгжлийн бэрхшээлтэй гэж тогтоогдсон ба нийт 170 хүүхэд байна. 2021-2022 оны хичээлийн жилд цэцэрлэгт 17, ерөнхий боловсролын сургуульд 110 хүүхэд суралцаж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн 64.7 хувь боловсролын үйлчилгээнд хамрагдаж байна.	90
	2.3.1.3	Насан туршийн боловсрол олгох үйл ажиллагааг өргөжүүлнэ	2021-2024	АЗДТГ,БСУГ	0	23%	30%	Насан туршийн боловсролын Үндэсний төв болон нэгжээс цахимаар зохион байгуулсан гэр бүлийн боловсрол, амьдрах ухааны боловсрол, ес зүй харилцаа хандлагын сургалт, бичиг үсгийн сургалт, дүйцсэн хөтөлбөрийн сургалтанд 5300 иргэд залуучууд хамрагдаж, "Ковид-19" цар тахлын улмаас Энэтхэг улсаас 40 лам хүүхэд ирж, дүйцсэн хөтөлбөрийн сургалтаар нийт 334 хүүхэд ерөнхий боловсролын сургуульд шилжин суралцсан байна. 2021-2022 оны хичээлийн жилд дүйцсэн хөтөлбөрөөр 283 суралцагч сурч байна. Үүнээс бага боловсролд 15, суурь боловсролд 128, бүрэн дунд 140 байна. Насан туршийн боловсролын төвийн барилгын ажил эхэлж суурь тавигдах ажил эхэлж байна. НТБҮТ төвтэй хамтран хөдөө мал маллаж байгаа малчин иргэдэд Эрүүл мэндийн боловсрол олгох сургалтыг Отгон, Идэр, Их-Уул, Дөрвөлжин, Тэс сумдын 500 иргэнд амьдрах ухааны боловсрол олгох сургалтыг зохион байгуулсан.	100

Бүх шатны сургалтын байгууллагын сургалтын чанарыг дээшлүүлнэ	2.3.2.1	Бүх шатны сургалтын байгууллагын чанарын үнэлгээний судалгаанд амжилттай хамруулна	2021-2024	АЗДТГ,БСУГ	10	38%	45.0%	Олон улсын PISA үнэлгээний туршилтын судалгаанд ерөнхий боловсролын лаборатори Чандмань-Эрдэнэ сургуулийн 2005 оны 16 настай 17 хүүхэд хамрагдлаа. Боловсрол, шинжлэх ухааны сайдын "Төлөвлөгөө баталж,хэрэгжүүлэх тухай" 2021 оны 05 дугаар сарын 21- ний өдрийн А/190 дүгээр тушаалын 3,5 дахь заалтыг хэрэгжүүлэхтэй холбогдон, суралцагчдын эзэмшвэл зохих агуулгын хоцрогдлыг тодорхойлох "ОНОШЛОХ ҮНЭЛГЭЭ" г 2021 оны 09 дүгээр сарын 23,24 ний өдрүүдэд зохион байгууллаа. "ОНОШЛОХ ҮНЭЛГЭЭ" д ерөнхий боловсролын сургуулийг түүврийн аргаар хамруулсан бөгөөд манай аймгаас 24 сургуулийн 2-12 дугаар ангийн 8904 шалгуулагч сонгогдлоо. БШУ-ны сайдын 2021 оны 06 дугаар сарын 23- ны өдрийн "Төлөвлөгөө хэрэгжүүлэх тухай" А/240 дүгээр тушаалын 2 дахь заалтыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан суралцагч бүрийн хичээл сургалтын агуулгын хоцрогдлыг оношлох, тодорхойлох, хариу арга хэмжээ авах зорилготой ерөнхий боловсролын сургуулийн 30 сургуулийн 2-12 дугаар бүх суралцагчдаас бүх судлагдахуунаар "СУРГУУЛЬД СУУРИЛСАН ҮНЭЛГЭЭ"-г 2021 оны 10 дугаар сарын 13-27- ны өдрүүдэд амжилттай зохион байгуулж дууслаа. Одоо мэргэжлийн багш болон сургалтын менежер, судлагдахуун хариуцсан мэргэжилтэн бүр материалыг засан оноожуулж, мэдээллийг өгөгдсөн загварын дагуу сургууль, аймгийн түвшинд нэгтгэх үйл ажиллагаа явагдаж байна. Чанарын үнэлгээ улсын хэмжээнд 2020, 2021 онд ковид-19 цар тахлын улмаас хийгдээгүй.	100
	2.3.2.2	Элсэлтийн ерөнхий шалгалтын хэмжээст оноог дээшлүүлэхэд чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлнэ	2021-2024	АЗДТГ,БСУГ	50	24 сургуулийн хэмжээст оноо 478	480	Элсэлтийн ерөнхий шалгалтанд давхардсан тоогоор 3198 суралцагч бүртгүүллээ. БШУ-ны сайдын баталсан давтлага зохион байгуулах зааврын дагуу элсэлтийн ерөнхий шалгалтанд бэлтгэх давтлагыг зохион байгуулж, 1375 хүүхэд хамрагдаж байна.Төгсөх ангийн суралцагчтай гурвалсан гэрээ байгуулж, хичээл сонголтонд зөвлөн тусалж ажилласан ба 10 судлагдахуунаар 1-11 удаагийн сорил авахад хэмжээст онооны дундаж 487.0 байна. 2021 оны элсэлтийн ерөнхий шалгалтын хэмжээст онооны дундаж 483.1 байна.	50
	2.3.2.3	Олимпиад, уралдаан тэмцээнд оролцогчдын амжилтыг ахиулна	2021-2024	АЗДТГ,БСУГ	30	0	3%	"Ковидгүй Завхан" цахим аяны хүрээнд "Уран бичигтэн" уралдаанд ахлах ангийн 56 суралцагч хамрагдсан байна."Covid 19" цар тахалтай холбогдуулан улс, бүс аймгийн хэмжээнд олимпиад, уралдаан тэмцээн зохион байгуулагдаагүй байна.	30
	2.3.2.4	Танхимын сургалтыг цахим сургалттай хослуулан хэрэгжүүлнэ	2021-2024	АЗДТГ,БСУГ	10	100%	100%	Багшийн мэргэжил дээшлүүлэх институтээс ЕБС-ийн сурагчдын сурлагын хоцрогдлыг нөхөх, танхим ба цахим хосолсон сургалтыг сургуулийн хэмжээнд нэгдмэлээр зохион байгуулах арга зүйд дэмжлэг үзүүлэх, Мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтын дараах дам, нөлөөт үр дүнг илрүүлэх мониторинг хийх зорилго бүхий сургалт, зөвлөн туслах, мониторинг хийх зорилготой тус үйл ажиллагаа 11 дүгээрын 8-9- ний өдрүүдэд Улиастай сумын Чандмань Эрдэнэ сургуулийг түшиглэн зохион байгуулагдлаа. "ХОСОЛСОН СУРГАЛТЫН АРГА ЗҮЙД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ" сэдэвт тус сургалтад Ерөнхий боловсролын 30 сургуулийн сургалтын менежер, бага боловсролын багш, дунд, ахлах ангийн багш, судлагдахуун хариуцсан мэргэжилтэн 106 багш удирдах ажилтан хамрагдлаа.	90
	2.3.3.1	Сургалтын байгууллагын хичээлийн болон дотуур байрын орчны гэрэлтүүлэг, камержуулалтыг нэмэгдүүлнэ	2021-2024	АЗДТГ,БСУГ	24	66%	70%	2020-2021 оны хичээлийн жилд Улиастай сумын Чандмань эрдэнэ лаборотори сургуулийн дотуур байр, Шилүүстэй, Нөмрөг, Цагаанхайрхан, Их уул, сумдын дотуур байруудад шинээр гэрэлтүүлэг хийж, Улиастай сумын 2.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 7 дугаар цэцэрлэгт 9 камер суурилуулан орчин нөхцөлөө сайжруулсан байна.	50
	2.3.3.2	Боловсролын байгууллагыг стандартад нийцсэн ус, ариун цэврийн байгууламжаар хангахад дэмжинэ	2021-2024	АЗДТГ,БСУГ	100	24	26	БШУЯ-ны хөрөнгө оруулалтаар Сантмаргаз, Түдэвтэй, Нөмрөг, Сонгино, сумдын дотуур байруудын ариун цэврийн өрөөг засварлаж стандартад нийцсэн жишиг ариун цэврийн өрөөг тохижуулахаар засварын ажил эхэлж байна. Мөн НҮБ-ын хүүхдийн сангийн санхүүжилтээр Дотуур байрыг түшиглэн байрын хүүхдэд халуун усанд орох боломжыг хангах зорилгоор Тэс, Цэцэн уул, Идэр, Ихуул, Тэлмэн сумдад халуун ус барьж ашиглалтанд оруулсан. Энэ хичээлийн жилд шинээр Сонгино сумын дотуур байрын дэргэд халуун ус барихаар барилгын ажил нь эхэлсэн байна.	50
	2.3.3.3	ЕБС-ийг хүүхэд тээврийн зориулалтын автомашинаар үе шаттай хангана	2021-2024	АЗДТГ,БСУГ	35	7	7	Аймгийн хүүхдийн 30 дугаар чуулганыг зохион байгуулж, Улиастай сумын ерөнхий боловсролын сургуулийн хүүхэд тээвэрлэх автобусны тоог нэмэгдүүлэх зорилт дөвшүүлэн ажиллаж байна.	0

Сургалтын орчны аюулгүй байдлыг сайжруулна.	2.3.3.4	"Хүүхдэд ээлтэй дотуур байр" арга хэмжээг хэрэгжүүлнэ	2021-2024	АЗДТГ,БСУГ	2800	8	11	"Хүүхдэд ээлтэй дотуур байр" арга хэмжээг 4 зорилтын хүрээнд 46 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр боловсруулж, аймгийн Засаг даргын зөвлөлд хэлэлцүүлэн, захирамжаар баталгаажуулан хэрэгжүүлж байна. Багшийн мэргэжил дээшлүүлэх институттай хамтран зохион байгуулсан "Хамтдаа хөгжье" хөтөлбөрийн хүрээнд сургуулийн дотуур байрын багш нарт "Хүүхдийн хөгжил төлөвшилд багшийн үүрэг оролцоо" сэдэвт 8 цагийн онлайн сургалтанд 25 багш хамрагдлаа. Асгат, Баянхайрхан, Баянтэс, Тэс, Сантмаргаз, Сонгино, Ургамал, Нөмрөг, Дөрвөлжин, Отгон сумын сургуулийн дотуур байранд ус, ариун цэврийн байгууламж байгуулахаар суурь судалгаа хийгдэж засварын ажил эхэлсэн байна. Мөн Дотуур байрны багш бүр сум сургуулийнхаа онцлогт тохирсон "Хүүхдэд ээлтэй дотуур байр" төлөвлөгөөг тус бүрдээ боловсруулан ажиллаж байна. Цаашид арга хэмжээ хөтөлбөрийн хүрээнд дотуур байрын хүүхдүүдийн орчин нөхцөлийг сайжруулах зорилгоор 5 бүсэд номын өргөө байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.	70
	2.3.3.5	Сургалтын байгууллагын материаллаг бааз, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, хичээлийн хэрэглэгдэхүүнийг сайжруулна	2021-2024	АЗДТГ,БСУГ	85	18	26	БШУ-ны яам, БОАЖ-ын яамнаас Монгол улс, ХБНГУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн хүрээнд Германы сэргээн босголтын эзэлийн банкаар дамжуулан хэрэгжүүлж буй "Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох" төслийн хүрээнд Алдархаан, Их-Уул, Идэр, Завханмандал, Отгон, Сантмаргаз, Цэцэн-Уул, Эрдэнэхайрхан, Тосонцэнгэл сумын 2-р сургуульд Эко кабинет байгуулагдсан ба "Байгаль орчны мэдээлэл" сургалтын төв, төслийн багаас 2021.04.09-нд зохион байгуулсан сургалтаар төслийн сургалтын үр дүн болон Эко кабинетад олгогдсон багаж, тоног төхөөрөмжийн талаарх мэдээллийг нэгтгэн танилцууллаа. Цэцэрлэгт шаардлагатай байгаа 8 төрлийн 14.0 сая төгрөгийн тавилга, тоног төхөөрөмж, ЕБС-д 3 төрлийн 33.6 сая төгрөгийн тавилга тоног төхөөрөмжийн жагсаалтыг БШУ-ны яаманд албан бичгээр хүргүүлсэн байна.	70
	2.3.3.6	Ерөнхий боловсролын сургуульд "Үдийн хоол" арга хэмжээг хэрэгжүүлнэ	2021-2024	АЗДТГ,БСУГ	1052	0	47%	"Үдийн хоол" арга хэмжээг 4 зорилтын хүрээнд 18 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр боловсруулж, аймгийн Засаг даргын зөвлөлд хэлэлцүүлэн, захирамжаар баталгаажуулан ЕБ-ын 29 сургуулидад хүргэж 2021-2022 оны хичээлийн жилд үдийн хоол хөтөлбөр хэрэгжиж сургуулиуд 5 өдөр махан хоол болон багцын хоолоор сурагчдад үйлчилж байна. Мөн үдийн хоол хэрэгжиж байгаатай холбогдуулан хүний нөөц болон тоног төхөөрөмжийн судалгааг БШУЯ-нд хүргэж байна. Мөн Ерөнхий боловсролын сургуульд "Үдийн хоол" арга хэмжээг хэрэгжүүлж байгаатай холбоотой Их-Уул, Баянтэс сумдын ерөнхий боловсролын сургуульд Хоол зүйчийг ажиллуулахаар материалыг БШУ- ны Яаманд хүргүүлсэн.	70
Хүүхдийн хөгжил хамгаалал, авьяас, ур чадвар, техник сэтгэлгээг хөгжүүлнэ	2.3.4.1	Хүүхэд залуучуудыг гадны сөрөг нөлөө, бусдын дарамт, гэмт хэрэгт өртөх, мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэхээс урьдчилан сэргийлэх, цахим орчин дахь аюулгүй байдлыг хангах арга хэмжээг хэрэгжүүлнэ.	2021-2024	АЗДТГ,БСУГ	34	30%	100%	НҮБ-ын Хүүхдийн сан, "Fargo foundation" ТББ-тай хамтран Хүүхэд, залуучуудад цахим орчны зөв зохистой хэрэглээг төлөвшүүлэх, нийгмийн сүлжээнд зэрэг харилцааг үүсгэж, цахим гадуурхал цаашлаад цахим гэмт хэргээс сэргийлэх чадваруудыг эзэмшүүлэх чиглэлээр "Digital literacy" сургалтыг зохион байгуулж 32 сургуулийн 64 сурагч багшийг бэлтгэсэн. Цаашид тус аргагчлаар сургууль бүрт сургалт зохион байгуулагдана. НҮБ Хүүхдийн сан, Харилцаа холбооны зохицуулах газраас гаргаж буй "Эцэг эхийн хяналт" цахим программыг орон нутгийн хэмжээнд туршин хэрэгжүүлэхэд бэлэн болсон.	70
	2.3.4.2	Хүүхдийн хөгжил, төлөвшил, ёс зүйд чиглэсэн зөвлөх үйлчилгээг хүргэхэд дэмжлэг үзүүлнэ	2021-2024	АЗДТГ,БСУГ	40	14	16	НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран Хүүхдийн хөгжил, оролцоо, амьдрах ур чадварыг дэмжих зорилгоор "Миний гэр бүл", "Миний ертөнц", "Уур амьсгалын өөрчлөлт ба Хүүхдийн эрх-10" зэрэг хүүхэд хөгжлийн хөтөлбөрийг 2021 онд нийт 685 хүүхдэд хэрэгжүүлсэн бол , 2022 онд 11913 хүүхдэд хэрэгжүүлэхээр төлөвлөвд байна.	70
	2.3.4.3	Суралцагчдын авьяас чадварыг хөгжүүлж, Аймгийн Засаг даргын нэрэмжит "Өсвөрийн морин хуурч" уралдааныг зохион байгуулна.	2021-2024	АЗДТГ,БСУГ	10	300	500	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2021 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн 18 дугаар тогтоолоор хассан.	0

Багшийн хөгжлийг дэмжиж, нийгмийн баталгааг хангана	2.3.5.1	"Чадварлаг багш" арга хэмжээг хэрэгжүүлнэ	2021-2024	АЗДТГ,БСУГ	10	20%	30%	"Чадварлаг багш" арга хэмжээг 3 зорилтын хүрээнд 28 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр боловсруулж, аймгийн Засаг даргын 2021.06.17-ны өдрийн А/243 захирамжаар батлан хэрэгжүүлж байна. Монгол Улсад орчин цагийн боловсрол үүсч хөгжсний 100 жил, далхийн багш нарын 27, Монголын багш нарын 55 дахь өдрийг тохиолдуулан "Чадварлаг багш" арга хэмжээний хүрээнд сумдын 26 Шилдэг багш болон "Далхийн том хичээл-тогтвортой хөгжлийн боловсрол" улсын уралдаанд шалгарсан 6 багийн багш нар, элсэлтийн ерөнхий шалгалтанд бэлтгэсэн шавь нь 800 оноо авсан 4 багшийг шагнаж урамшуулахад орон нутгийн төсөөс 8.2 сая төгрөгийг зарцуулсан байна. "Багш-хүүхэд-орчин" хэлэлцүүлэг, зөвлөгөөнд цэцэрлэг, сургуулийн захирал, эрхлэгч, багшийн төлөөлөл, сургуулийн нийгмийн ажилтан, дотуур байрны багш, ахлах тогооч нийт 278 багш, ажилтан оролцож, үйл ажиллагаанд 1.2 сая, эрхэлсэн ажилдаа санаачлагатай сайн ажиллаж байгаа 12 багш, ажилтныг "Засаг даргын жуух" бичгээр шагнаж урамшуулахад 2.4 сая, боловсрол, соёлын салбарт хэрэгжиж байгаа хөтөлбөрүүдээр ном хийхэд 4.8 сая төгрөгийг орон нутгийн төсөөс зарцууллаа.	100
Мэргэжлийн сургуулиудын хөгжлийг дэмжиж, хамтран ажиллана	2.3.6.1	Гадаад, дотоодын захиалгат сургалтын хөтөлбөрүүдийг мэргэжлийн сургуулийг түшиглэн хэрэгжүүлнэ	2021-2024	АЗДТГ,БСУГ	5	0	1	Монгол дахь Австралийн Элчин сайдын яам,Завхан аймгийн Боловсрол соёл урлагийн газар, Австрали улстай хамтран зохион байгуулсан Завхан аймгийн 24 сумын ерөнхий боловсролын сургуулийн 37 англи хэлний багш нарт олон улсын англи хэлний IELTS-н шалгалтад бэлтгэх 3 сарын онлайн сургалтыг Австрали улсын Мелборн хотын олон улсын мэргэшсэн англи хэлний багш Guenter Brook удирдан явуулж багш нарын мэргэжлийн үр чадвар, заах арга зүй дээшлүүлэх сургалт нь амжилттай зохион байгуулагдсан. НҮБ-ын Хүүхдийн сангийн дэмжлэгтэйгээр цэцэрлэг, Ерөнхий боловсролын сургуулийн удирдах ажилтны менежмент, технологи, манлайллын "И-СУРГАЛТ" удирдлагын академийн багш нар 90 удирдах ажилтанд зохион байгууллаа.	90
	2.3.6.2	Аймгийн Засаг даргын ивээл дор Завхан аймгийг тогтвортой хөгжүүлэх эрдэм шинжилгээний хурлыг уламжлал болгон зохион байгуулна.	2021-2024	АЗДТГ,БСУГ	0	2	0	МУИС-ийн Завхан сургуультай хамтран "Орон нутгийн тогтвортой хөгжлийн боловсролын асуудлууд" сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлыг цахимаар зохион байгуулж, 39 илтгэлийг хэлэлцүүлж, шилдэг илтгэлүүдээр эмхтгэл хийх зардалд Засаг даргын нөөц сангаас 3.255.000 төгрөгийн дэмжлэг үзүүлээ.	100
2.3 ДУГААР ЗОРИЛТЫН ДҮН									68.42
	2.4	Судалгааны ажлыг үр дүнтэй зохион байгуулж, орон нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжилд үзүүлэх үр ашгийг нэмэгдүүлсэн байна							
Эрдэм шинжилгээ, судалгаанд зарцуулах зардлыг нэмэгдүүлнэ	2.4.1.1	Мэргэжлийн сургуулийн судалгааны үр дүнг орон нутгийг хөгжүүлэх үйл ажиллагаанд ашиглана.	2021-2024	АЗДТГ,БСУГ	0		0	МУИС-ийн Завхан сургуулиас эрхлэн аймгийн Засаг даргын ивээл дор Орон нутгийн тогтвортой хөгжлийн боловсролын асуудлууд сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлыг зохион байгуулж, шалгарсан илтгэлүүдээр эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэл гаргасан. Энэ арга хэмжээнд аймгийн Засаг даргын нөөц сангаас 3.2 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Мөн МУИС-ийн Завхан сургууль дээр Австралийн засгийн газрын дэмжлэгтэйгээр судалгааны ажлууд хийгдэж байна.	70
	2.4.1.2	Алслагдсан бүс нутагт үүрэн холбооны дахин дамжуулах станц байгуулж, интернетийн сүлжээг өргөжүүлнэ.	2021-2024	АЗДТГ,БСУГ	160	13	2	2021 онд Мобикомын дахин дамжуулах станц Загастайн даваанд хийгдэж ашиглалтад хүлээлгэн өгсөн. "Хур систем" төслийн хүрээнд Алдархаан, Асгат, Баянхайрхан, Дөрвөлжин, Сантмаргаз, Тосонцэнгэл, Ургамал, Цагаанхайрхан, Цэцэн-Уул, Шилүүстэй, Яруу сумдад төрийн цахим үйлчилгээг нэвтрүүлэх 20 м өндөртэй харилцаа холбооны цамхаг угсралтын ажил хийгдэж ашиглалтад хүлээн авсан. Мобиком ХХК-с Алдархаан сумын Бага-Оргих, Оргих дунд, Загастайн даваа, Эрдэнэхайрхан сумын Товшош, Сонгин сумын Дунд улаан, Улиастай сумын Шинэ хороо, Юнител ХХК-иас Улиастай сумын Генерал толгой, ГХБХБГ, Шинэ хороо, Тосонцэнгэл сумын хайрхан багийн ХАА-н 14-1413Б байршилд тус тус үүрэн холбооны шинэ сайтыг барьж, өргөтгөл хийсэн.	70
2.4 ДҮГЭЭР ЗОРИЛТЫН ДҮН									70
	2.5	Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэн нийгмийн халамжийг зорилтот бүлэгт хүргэж, гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийг дэмжин амьдралын чанарыг дээшлүүлнэ							
Ажил эрхэлдэггүй, боловсрол эсвэл сургалтад хамрагдаагүй залуучуудын нийт хүн амд эзлэх хувийг бууруулна	2.5.1.1	Ажил эрхэлдэггүй, боловсрол эсвэл сургалтад хамрагдаагүй залуучуудын нийт хүн амд эзлэх хувийг бууруулна	2021-2024	ХХҮГ,АЗДТГ	10	25.7%	24.5%	Зорилтын хүрээнд нөлөөллийн арга хэмжээ зохион явуулж 163 залуучууд хамрагдсан. Залуучууд хамрагдалт бага байгаа нь 2021 оны 03 сараас хойш ковид-19 цар тахал дэгдсэнтэй холбоотой байна. Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээний загвар төвд залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн чадварт үнэлгээ хийхэд 175, төлөвлөгөө болон үе шаттай модуль сургалтад 375, нийт 500 орчим залуучууд хамрагдсан. Мөн залуучуудыг хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөрийн хүрээнд 77 залуучууд УБ хотод 14 хоногийн сургалтад хамрагдсан.	70

Аймгийн ажиллах хүчний оролцооны түвшинг нэмэгдүүлнэ	2.5.2.1	Аймгийн ажиллах хүчний оролцооны түвшинг нэмэгдүүлнэ	2021-2024	ХХҮГ,АЗДТГ	80%	80%	Ажиллах хүчний оролцооны түвшин 2021 оны 1 дүгээр улирлын байдлаар 67.9% байгаа нь өмнөх оны мөн үеэс 0,2 функтээр бага байна. 2021 оны 10 дугаар сарын 25-ны байдлаар ганцаарчилсан үйлчилгээнд 225, бүлгийн үйлчилгээнд 370 залуучууд нийт 595 залуучуудад нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж, хөдөлмөр эрхлэх түвшинг нь нэмэгдүүлсэн байна. Монгол улсын Засгийн газар, Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамнаас хэрэгжүүлж байгаа "Халамжаас-хөдөлмөрт шилжих" бодлого зорилтын хүрээнд хөдөлмөр эрхлэхгүй байгаа залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих "Оролцоо" төсөлд Завхан аймгаас 77 залуучууд төсөлд хамрагдаж, төгсөн дадлагажих ажлаа амжилттай хэрэгжүүлж байна. Төсөлд хамрагдсан залуучуудын 77 хүний 54 хүн буюу 70% -ийг ажлын байртай болгох зорилтын хүрээнд Завхан аймагт үйл ажиллагаа явуулж буй ажил олгогч нартай гэрээ байгуулан ажиллаж байна.	50	
Эдийн засгийн идэвхтэй хүн амын нийгмийн даатгал төлөлтийг нэмэгдүүлнэ	2.5.3.1	Эдийн засгийн идэвхтэй хүн амын нийгмийн даатгал төлөлтийг нэмэгдүүлнэ	2021-2024	ХХҮГ,АЗДТГ	5	23%	Нийт 13786 хүн нийгмийн даатгалд хамрагдаж, эдийн засгийн идэвхтэй хүн амд нийгмийн даатгалд даатгуулагчийн эзлэх хувь 41.0 хувь байна.	100	
Ажлын байрны захиалгад нийцүүлсэн бодлогоор ажилгүйдлийн түвшинг бууруулна	2.5.4.1	Ажлын байрны захиалгад нийцүүлсэн бодлогоор ажилгүйдлийн түвшинг бууруулна	2021-2024	ХХҮГ,АЗДТГ	20	4.3%	5.6%	2021 оны 3-р улирлын байдлаар ажилгүйдлийн түвшин 11.9% байгаа нь өмнөх оны мөн үеэс 11.4 функтээр нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Ажилгүйдлийн түвшин өсөж байгаа нь аж ахуйн нэгж байгууллагууд ковид-19 цар тахлын нөхцөл байдлын улмаас ажиллахгүй байгаатай холбоотой юм.	30
Хөдөлмөрийн насны хүн амын хөдөлмөр эрхлэлтийн түвшинг нэмэгдүүлнэ	2.5.5.1	Мэргэжлийн сургалтын байгууллагын сургалтын технологи, арга зүй, орчин нөхцөлийг сайжруулна	2021-2024	ХХҮГ,АЗДТГ	50	1	2	ХНХЯ-ны санхүүжилтээр мэдээлэл технологийн операторч мэргэжлийн лабораторыг сүүлийн үеийн 13 иж бүрэн суурин компьютерээр шинэчилсэн. GIZ төслөөс барилга угсралтын мужаан мэргэжлийн дадлагын газарт 30,0 сая төгрөгийн засварын материалаар хангаж, багш хөгжлийн өрөөнд 8,0 сая төгрөгийн онлайн видео хурлын тоног төхөөрөмжөөр хангасан. IT дэд бүтцийг сайжруулах зорилгоор сургуулийн орчин, дадлагын газруудад 63,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн байна.	70
	2.5.5.2	Үйлчилгээний салбарт ажиллагсдыг мэргэжлийн сургуульд бэлтгэнэ	2021-2024	ХХҮГ,АЗДТГ	5	250	280	Завхан аймаг дахь Политехник коллеж 2020-2021 оны хичээлийн жилд 23 мэргэжлээр 239 суралцагч төгсөж төгсөгчдийн ажил эрхлэлтийн хувь 65%-тай байна. 2021-2022 онд 24 мэргэжлээр 396 суралцагч элсүүлэн суралцаж байна.	30
Аймгийн хэмжээнд хувийн хэвшилд ажиллагсдын тоог нэмэгдүүлнэ	2.5.7.1	Хөдөлмөрийн үнэлэмжийг цагаар болон хоноогоор тооцох аргачлалыг мөрдлөг болгох нөлөөллийн ажлыг зохион байгуулна	2021-2024	ХХҮГ,АЗДТГ		4	6	"Хөдөлмөрийн норм норматив тогтоох аргачлал"-ын тухай цуврал мэдээлэл бэлтгэн цахимд байршуулахад орон нутагт үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж буй 30 аж ахуйн нэгж байгууллагын 90 ажилтан, 32 ажил олгогч нар ганцаарчилсан зөвлөгөө авч, 10 аж ахуйн нэгж нь ажил мэргэжлийг бүлэглэж, зэрэглэх аргачлалын талаар мэргэжил арга зүйн зөвлөгөөг үүрэн холбооны утсаар мэдээлэл авч хуваалцсан. Тус арга хэмжээний хүрээнд "Ажлын байрны соёл 5С" -ийг "Илч Дөл" ХХК, "Ургамал сүлжээ" ХХК, "Богдын гол УЦС" ХХК, "Баялаг ундраа" хоршоо, "Санмин" нөхөрлөл, "Илч дөл" хоршоо, "Цогц гоёл" ХХК, "Өрнөх-Оёдол" цех, "Цэцэглэн" цех, "Тэгш дүүрэн" хоршоо, "Уран мандал" хоршоо, "Жаргалант эх булаг" цех, "Атар" цех, "Дөл-зайрмаг" цех, "Торго"цех зэрэг 15 аж ахуйн нэгж байгууллагын удирдлага, хүний нөөц, санхүүгийн ажилтнуудад ажлын байрны тодорхойлолтыг үндэслэн мэргэжлийн зэрэг, хөдөлмөрийн нөхцлийн бусад нэмэгдлийг олгох, цалин хөлсний зохистой тогтолцоо бүрдүүлэн ажиллах талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласны үр дүнд 8 аж ахуйн нэгж байгууллага нь аргачлалыг хэрэгжүүлэн ажиллаж байна.	70
Гэр бүлд чиглэсэн арга хэмжээний чанар хүртээмжийг сайжруулна.	2.5.8.2	"Залуу гэр бүл" арга хэмжээг хэрэгжүүлнэ	2021-2024	ХХҮГ,АЗДТГ	0	523	586	Гэр бүлийн боловсрол олгох 17 удаагийн сургалт, хэлэлцүүлэг, аян, цахим уралдаанд давхардсан тоогоор 7005 хүн хамрагдсан. Гэр бүлийн боловсрол олгох, гэр бүлийн хөгжлийг дэмжих сургалт, нөлөөллийн арга хэмжээг 4 удаа зохион байгуулж 652 гэр бүлийн 729 хүн хамрагдсан. Тогтвортой амьдрал амгалан гэр бүл арга хэмжээний хүрээнд 2021 онд 16 удаагийн сургалт, үйл ажиллагаа зохион байгуулагдаж нийт гэр бүлийн 19.5 хувь /4272 гэр бүл/ нь хамрагдсан байна. Эдгээр үйл ажиллагаанд нийт 88.8 сая төгрөгийг зарцуулсан байна.	70
Хүүхэд хөгжил, хамгааллын үйл ажиллагааг өргөжүүлнэ	2.5.9.1	Хүүхэд хөгжил, хамгааллын үйл ажиллагааг өргөжүүлнэ	2021-2024	ХХҮГ,АЗДТГ	5	5%	10%	2021 оны 11 дүгээр сарын байдлаар хүүхэд хамгааллын үйл ажиллагааны зардалд улсын төсвөөс 20.8 сая төг, орон нутгийн төсвөөс 5.0 сая төгрөг зарцуулсан. НҮБ-ийн Хүүхдийн сангаас 112.2 сая төгрөгийг гэр бүл, хүүхдийн хөгжил, оролцоо хамгааллын үйл ажиллагааг бэхжүүлэх, өргөжүүлэхэд зарцуулсан байна. Нийт зарцуулсан төсөв 138.1 сая төг зарцуулсан байна. "Уур амьсгалын өөрчлөлт ба хүүхдийн эрх" сэдэвт аймгийн хүүхдийн нэгдсэн 30 дугаар чуулганыг цахим болон танхимаар зохион байгуулахаар хөтөлбөрийг аймгийн Засаг даргаар батлуулан бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Тус чуулганд төлөөлөгчөөр 427 хүүхэд оролцоо юм. Уг цахим чуулганы үйл ажиллагааг "Хүүхэдээ ээлтэй орон нутаг" хөтөлбөрийн хүрээнд НҮБ-ын Хүүхдийн сангийн дэмжлэгтэйгээр 15.5 сая төгрөг зарцуулан зохион байгуулах юм.	70
Гэр бүлийн хүчирхийллийн хоширогчийг хамгаалах үйлчилгээний	2.5.10.2	Архины хамааралтай гэр бүлд чиглэсэн арга хэмжээ зохион байгуулна	2021-2024	ХХҮГ,АЗДТГ	20	43	56	НҮБ-ын Хүүхдийн сангийн дэмжлэгтэйгээр архины хамааралтай иргэдэд зориулсан "Сэтгэл зүй оюун санааны эмчилгээ" сургалтыг тусгай хөтөлбөрийн дагуу Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн эмч, мэргэжилтнүүдтэй хамтран зорилгод өрхүүдээс 115 иргэнийг сонгон сургалтад хамруулан ажилласан.	100

Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээний чанарыг сайжруулна	2.5.11.1	Хамтарсан багийн үйл ажиллагааг сайжруулна	2021-2024	ХХҮГ,АЗДТГ	5	270	270	Аймгийн ГБХЗХГ-аас 2021 онд шинэчлэгдэн байгуулагдсан хамтарсан багийн судалгааг авч нэгтгэсэн. 24 суманд 30 хамтарсан багийн 282 гишүүн ажиллаж байна. 2021 оны эхний 11 сарын байдлаар хамтарсан багаар 37 кейсийг шийдвэрлэж, одоогийн байдлаар 30 кейс дээр ажиллаж байна. Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдод дараах хариу үйлчилгээний үзүүлсэн. Үүнд: 5 хүүхэд, 15 насанд хүрэгчдэд эмнэлгийн тусламж үйлчилгээ, 24 хүүхэд, 35 насанд хүрэгчдэд сэтгэл зүйн зөвлөгөө, 56 хүүхэд, 60 насанд хүрэгч, 45 гэр бүлд нийгмийн халамжийн үйлчилгээ, 11 хүүхэд, 29 насанд хүрэгчдэд эрх зүйн туслалцаа, 419 хүүхдэд хүүхэд хамгааллын үйлчилгээг тус тус үзүүлж, 14 хүүхэд, 8 насанд хүрэгчдийг холбогдох байгууллагууд руу нь холбон зуучилж өгсөн байна. Урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд 84 удаагийн сургалтыг зохион байгуулж 3317 хүнийг хамруулсан. Мөн цахим болон танхимаар 167 удаагийн сургалт, сурталчилгаа, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж 7229 иргэнийг хамруулсан. Дэлхийн зөн Олон Улсын байгууллагын дэмжлэгээр 1.4 сая төгрөг зарцуулан 24 сумын 30 хамтарсан багийн 164 гишүүнийг хамруулан чадавхжуулах сургалтыг цахимаар зохион байгуулсан.	70	
	2.5.11.2	Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйл ажиллагааг сайжруулна	2021-2024	ХХҮГ,АЗДТГ	2	95%	95%	Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо хуралдаагүй. Аймгийн гэмт хэрэг зөрчилд холбогдсон хүүхдийн тоо 19 байгаа боловч гадны харьяалалтай хүүхдийн тоо орсон болно. 1 хүүхэд зөрчлийн хуулиар арга хэмжээ авагдсан. Энэ онд бэлгийн хүчирхийлэлд хамрагдсан тохиолдол байхгүй байгаа нь сайшаалтай байна. 2020 оны бэлгийн хүчирхийллийн хохирогч 4, зөрчлийн хэрэгт холбогдсон 1, зам тээврийн хэргийн хохирогч 2, зөрчлийн хэргийн хохирогч 2, хүүхдэд хууль ёсны төлөөлөгчөөр ажиллаж, эрүүгийн хэргийн шүүх хуралд 5 удаа, зөрчлийн хэргийн шүүх хуралд 3 удаа оролцож хүүхдийн эрхийг хангах хамгаалах үүрэг гүйцэтгэж ажилласан. Хүүхдийн болзошгүй эрсдэл, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилготой "Хүүхэд хамгаалагч" төслийг хичээлийн шинэ жил эхэлсэнтэй холбоотойгоор цагдаагийн дөрвөн ахмад ажилтантай гэрээ байгуулан ажиллаж сургуулиудад ажиллаж мэдээлэл, зөвлөгөөг 4211 хүүхдэд өгч, брошур гарын авлага тараасан.Иргэний хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргаагүй. Засгийн газрын 2021 оны 06 дугаар сарын 01-ны өдрийн 159 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд эцэг эх асран хамгаалагч нь хүүхдээ асран хамгаалах, тэжээн тэтгэх үүргээ үл биелүүлсэн гомдол, өргөдөл 4 ирснийг шуурхай судлан шийдвэрлэж, байцаагчийн дүгнэлт гаргаж 2 хүүхдийн мөнгө түр зогсоож, 2 хүүхдийн мөнгийг хугацаатай хадгаламжийн дансанд шилжүүлж ажилласан. Сум дундын шүүхийн шүүгчийн 6 захирамж ирсэнээс 1 захирамж өөрийн хүсэлтээр цуцлагдаж, 5 гэр бүлийн 11 хүүхдэд асран хамгаалагч тогтоох шинжээчийн дүгнэлт гарган ажиллаж, хүүхдийн эрх ашиг хамгаалагдсан.	70	
Хөдөлмөр эрхлэлтийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх ахмадуудыг дэмжинэ	2.5.13.1	Зөвлөх үйлчилгээ үзүүлэх ахмадуудын мэдээллийн санг бий болгоно	2021-2024	ХХҮГ,АЗДТГ		175	200	Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл, ХНХЯ түүний харьяа байгууллагууд ахмад мэргэжилтнүүдийн ажил хөдөлмөрт оролцох оролцоог нэмэгдүүлэх, мэдээллийн сан үүсгэн тэдний мэдлэг, ажлын туршлагыг өсвөр хойч, залуу үеийнхэнд өвлүүлэх, зөвлөн туслах үйлчилгээг үзүүлэх болон хувиараа аж ахуй эрхэлж орлогоо нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилго тавин ажиллаж байна. 2021 онд Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөлөөс 15 ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээний төслийг шалгаруулан 12.6 сая төгрөгийн санхүүжилт олгохоор гэрээ байгуулан ажиллаж байна. Тус үйлчилгээг 13 суманд 21 ахмад мэргэжилтэн төрийн захиргаа, боловсрол, эрүүл мэндийн чиглэлээр үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулан ажиллаж байна. Аймгийн ХХҮГ дээр ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ үзүүлдэг ахмадуудын мэдээллийн санд 2021 онд нэмж 21 хүн нэмж бүртгэгдсэн байна.	90	
	2.5.13.2	Сумын ахмадын хорооны үйл ажиллагааг дэмжинэ	2021-2024	ХХҮГ,АЗДТГ	8	0	8	Сумын ахмадын хорооны үйл ажиллагааг дэмжиж аймгийн ахмадын хороо, Монголын ахмадын холбоо, Ганабелл сургалтын төвтэй хамтран бүх сумын ахмадын хорооны дарга, идэвхтэн, гишүүд, ахмадуудыг чадавхжуулах сургалтыг төлөвлөгөөний дагуу 4 удаа зохион байгуулсан. Бүх сумын ахмадын хороог нэгтгэсэн цахим групп ажиллуулж, мэдээллийг цаг тухай бүрт хүргэдэг. Аймгийн ахмадын хорооноос сумын ахмадын хороонд жилд 1.2 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлсэн. Аймгийн хэмжээнд ахмадуудын зөвлөн туслах үйлчилгээг магадлан итгэмжлэгдсэн 5 байгууллага үзүүлж байна.	90	
Залуучуудын хөгжлийн төвийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ	2.5.14.1	Зарим суманд залуучуудын хөгжлийн төв байгуулна	2021-2022	ХХҮГ,АЗДТГ	удалдан авалт	1	1	Сум бүрт залуучуудын хөгжлийн зөвлөлийг сайн дурын оролцоотойгоор зохион байгуулж YDC.mn сайтад бүртгүүлсэн. Эдгээр зөвлөлүүдийн үйл ажиллагааг дэмжих хүн амын төвлөрөл ихтэй Тосонцэнгэл зэрэг суманд залуучуудын хөгжлийн төв байгуулах төслийг олон улсын байгууллагуудад бичиж хүргүүлсэн.	0	
	2.5.14.2	Аймгийн залуучуудын хөгжлийн төвийн үйл ажиллагааг дэмжинэ	2021-2024	ХХҮГ,АЗДТГ		15	622	725	Ковидын үед "Хөл хориог хөгжих боломж болгов" цахим уралдааныг аймгийн Засаг даргын санаачлагаар зохион байгуулж, тус уралдаанд 23 залуучууд оролцсон. Амжилттай оролцсон залуучуудад 600.000 төгрөгийн урамшууллыг орон нутгийн төсөөс гаргаж урамшуулсан. Залуучуудын хөгжлийн төвийг жишиг болгон тохижуулах, Гэр бүлийн радио FM 104.5 салбар байгуулах ажил улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 75.0 сая төгрөг шийдвэрлэгдсэн, тендер шалгаруулалтын үйл ажиллагаа явагдаж байна.	50
Гэр бүлийн гишүүдийн жөндөрийн эрх тэгш байдлын талаарх ойлголт хандлагыг нэмэгдүүлэх нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулна	2.5.15.1	Гэр бүлийн гишүүдийн жөндөрийн эрх тэгш байдлын талаарх ойлголт хандлагыг нэмэгдүүлэх нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулна	2021-2024	ХХҮГ,АЗДТГ		3	0%	2%	"Жөндөрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоног"-ийн аян жил бүрийн 11-р сарын 25-наас (Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг таслан зогсоох олон улсын өдөр) 12-р сарын 10-ны (Олон улсын хүний эрхийн өдөр) хооронд тохиодог. Энэ хүрээнд 16 хоногийн аяныг "Хүчирхийлэл хүн бүхэнд хамаатай" сэдвийн дор үндэсний хэмжээнд зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.	30

Халамж зайлшгүй хүрэх шаардлагатай зорилтот бүлгүүдэд халамжийн үйлчилгээг хүртээмжтэй хүргэнэ	2.5.16.1	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх дэмжлэгийн хүртээмжийг нэмэгдүүлнэ	2021-2024	ХХУГ,АЗДТГ	2239	2209	Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөлийн 2021 оны 4 сарын 22-ны өдрийн 02 тоот тогтоолоор Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ, хөтөлбөрүүдийн хуваарийг батлуулсан. 24 сумын Засаг дарга, хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн нарт цахим ZOOM программ ашиглан, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэх тухай дүрэм, журмыг танилцуулсан. Хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөлөөс баталсан хуваарийн дагуу нийт 83 төсөл хүлээн авч 8 сумын 22 иргэний сонгон шалгаруулан ХЭДС-аас тус бүр 4 сая төгрөгийг 36 сарын хугацаанд 50 хувь эргэн төлөгдөх нөхцөлтэй 88.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олголоо.	30	
	2.5.16.2	"Хүнсний талон" олгох үйл ажиллагааг зорилтот өрхөд хүргэнэ	2021-2024	ХХУГ,АЗДТГ	1206	1190	2021 оны эхний 11 сарын байдлаар хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд гэрээ байгуулсан 40 хүнсний дэлгүүрээр дамжуулан 934 өрхийн 4664 иргэнд 724.7 сая төгрөг зарцуулсан байна. 2021 онд цахим монгол арга хэмжээний хүрээнд хүнсний эрхийн бичгийн үйлчилгээг НӨАТ олгодог хүнсний дэлгүүр, бөөний төвөөс авах ажлыг зохион байгуулсан. -Энэ ажлын хүрээнд хүнсний эрхийн бичгийн үйлчилгээг авдаг 1086 өрхүүдийн хүнсний эрхийн бичгийн картгы төрийн банктэй хамтарч пин коджуулсан. - Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ үзүүлж байсан 40 дэлгүүрийг банк болон систем нийлүүлэгчдийн холбоотой хамтарч программын шинэчлэл хийж 10 сараас эхлэн шинэ системд шилжүүлж өрхүүд программын хөгжүүлэлт хийлгэсэн дэлгүүрүүдээс сонгож үйлчилгээгээ авах боломжтой болсон. Өмнө нь өрхүүд зөвхөн гэрээ байгуулсан дэлгүүрүүдээс авдаг байсан бол одоо програмын хөгжүүлэлт хийлгэсэн НӨАТ олгодог бөөний болон хүнсний дэлгүүрүүдээс сонгон үйлчлүүлдэг болсон.	70	
2.5 ДУГААР ЗОРИЛТЫН ДҮН								61.05	
Үндэсний үнэт зүйл, уламжлалт өв соёлоо дээдэлж, иргэдийг соён гэгээрүүлэн, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлнэ									
"Үндэсний бахархал, Монгол өв соёл" арга хэмжээг хэрэгжүүлнэ	2.6	Үндэсний үнэт зүйл, уламжлалт өв соёлоо дээдэлж, иргэдийг соён гэгээрүүлэн, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлнэ							
	2.6.1.1	Суралцагчдад зориулсан Монгол эх оронч үзэл төлөвшүүлэх нөлөөллийн ажлыг нэмэгдүүлнэ	2021-2024	БСУГ,АЗДТГ	50	1500	2500	Аймгийн Засаг даргын санаачилгаар суралцагчдад эх оронч үзлийг төлөвшүүлэх, эх орныхоо түүх соёл, ёс заншил, өв уламжлалаараа бахархдаг иргэн болгон төлөвшүүлэх зорилгоор цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдын дунд "Миний эх орон-Монгол" цахим уралдааныг дараах төрлүүдээр зохион байгууллаа. Үүнд: цэцэрлэгийн насныханд "Миний эх орон" сэдэвт гар зургийн уралдаан, бага ангийнханд "Миний монгол бахархал" сэдэвт зурагт альбом хийх, дунд ангийнханд Цэрэг эх орны сэдэвт шүлгийг монгол бичгээр бичих, ахлах ангийнханд "Миний эх орон Монголын сайхан орон" видео контент бэлтгэх ангиллаар зохион байгуулж цэцэрлэгийн бэлтгэл бүлгийн 104 хүүхдийн, ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн 98, дунд ангийн 45, ахлах ангийн 34, нийт 281 бүтээл ирж, шалгарсан 16 хүүхдийг шагнаж урамшууллаа. Мөн Боловсрол, соёл урлагийн газар, аймгийн Музей хамтран "Би монгол хүүхэд" цахим уралдааныг зохион байгуулж, ерөнхий боловсролын сургуулийн 200 гаруй суралцагчид оролцсон байна.	70
	2.6.1.2	Монгол зан заншил, өв соёлыг сурталчлан таниулах сургалтын танхим байгуулахад дэмжлэг үзүүлнэ	2021-2024	БСУГ,АЗДТГ	60	1500	5000	Боловсрол, соёл урлагийн газраас сумдын соёлын төв, ерөнхий боловсролын сургуулиуд Монгол ёс заншлын өргөө байгуулах чиглэл өгч ажилласан ба Их-Уул, Идэр, Тэс сумын соёлын төвийн байгуулсан "Ёс заншлын өргөө" шилдгээр шалгарсан байна. эдгээр ёс заншлын өргөөг жишиг болгон 23 сумын соёлын төв, Ерөнхий боловсролын 29 сургуульд монгол ёс заншлын өргөөг сургалтанд ашиглах боломжтой байдлаар байгуулж тохижуулах чиглэл, өргөөнд байх хэрэглэгдэхүүний жагсаалтыг төсөл байдлаар хүргүүлж, жишиг монгол ёс заншлын өргөөний тэргүүн туршлагыг баримтат нэвтрүүлэг болгон олон нийтэд түгээх, туршлага судлуулах, хүүхэд залуучууд, суралцагчдад монгол ахуй амьдрал, өв уламжлалыг сурталчлан таниулах цогц хэрэглэгдэхүүнээр хангахад анхаарч байна.	50
	2.6.1.3	Соёлын биет бус өвийг өвлөн тээгчдийг бүртгэн баримтжуулж, түгээн дэлгэрүүлэхэд дэмжлэг үзүүлнэ	2021-2024	БСУГ,АЗДТГ	30	550	555	Соёлын биет бус өвийн цахим бүртгэлийн систем нэвтрэх гэж байгаатай холбогдуулан аймгийн соёлын биет бус өвийн550 өвлөн уламжлагчдын гэрэл зургийн бүрдлийг хийж, Соёлын өвийн Үндэсний төвд хүргүүлээ. Соёлын яамнаас Түүх соёлын үл хөдлөх дурсгалын улсын тооллого болон соёлын биет бус өвийн үзлэгийг зохион байгуулах чиглэлийг ирүүлсэнтэй холбогдуулан бэлтгэл ажлыг хангаж байна. Аймгийн Засаг даргын санаачилгаар зохион байгуулсан "Ковидгүй Завхан" цахим аяны "Ахмадын сургаал арт" уралдааны хүрээнд, 24 ахмад настан нутаг орныхоо түүх, өв соёл, үлгэр домог, сонин содон үйл явдлын тухай хуучлах, уламжлалт тоглоом наадагйг зааж сургах чиглэлээр видео бичлэг хийж, цахим орчинд байршуулан оролцож, шалгарсан ахмадуудын шагналд Орон нутгийн төсвөөс 1.5 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна. Соёлын яам, Соёлын өвийн үндэсний төв хамтран зохион байгуулсан "Соёлын биет бус өв, өвлөн уламжлагчийн бүртгэлийн программыг ашиглах арга зүй" цахим сургалтад БСУГ-ын мэргэжилтэн, аймгийн музейн бүртгэл мэдээллийн санч, эрдэм шинжилгээний ажилтан, сан хөмрөгч нар хамрагдлаа. Соёлын биет бус өвийн бүртгэлийн программд аймгийн 548 өвлөн уламжлагч бүртгэгдсэн. "Улсын тэргүүний ардын авьяастан" цол тэмдгээр 8 өвлөн уламжлагч шагнагдсан байна.	90

	2.6.1.4	Өрх бүр угийн бичгээ хөтөлж хэвшинэ	2021-2024	БСУГ,АЗДТГ	10	5500	8000	"Угийн бичиг" хөтөлдөг айл өрхийг нэмэгдүүлэх талаарх уулзалт, хэлэлцүүлгийг Монголын Угийн бичгийн академийн Завхан аймаг дахь салбар, ахмадын хороотой хамтран цахимаар 3 удаа, хамтран арга зүйн сургалтыг 10 байгууллага, 2 сумд зохион байгуулж, угийн бичгээ хөтөлдөг айл өрхийн судалгааг сум бүрээр нэгтгэхэд, 4500 өрх угийн бичгээ хөтөлж байгаа гэсэн судалгаа гарсан байна. Мөн Идэр сум "Төрд данстай өвөг дээдэс", "Өвөг дээдсийн залгамж, өнөөгийн бид" нэртэй 3 боть ном гаргасан байна. Ахмад багш Янжинхүүтэй хамтран "Угийн бичиг хөтөлж арга зүй" сургалтыг төрийн 50 гаруй байгууллагын 1000 гаруй албан хаагчдад зохион байгуулж, монгол угийн бичиг хөтөлж ирсэн уламжлалыг түгээн дэлгэрүүлэх ажлыг цахимаар болон танхимаар зохион байгуулж 50.000 гаруй иргэнд мэдээлэл хүргээд байна. НҮБ-ын дэмжлэгтэйгээр Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газарт МУБИС-ийн багш доктор н.Оюун-Эрдэнэ "Гэр бүлийн боловсрол" сургалтыг зохион байгуулж сумдын соёлын төвийн ажилтан, ГБХЭХГ, БСУГ-ын мэргэжилтнүүд хамрагдаж сургагч багшаар бэлтгэгдсэн байна. Угийн бичиг хөтөлж арга туршлагыг 23 сумын соёлын төвүүдийн нэгдсэн группт байршуулж цахим хэлбэрээр сурталчилсан.	50
Соёлын биет болон биет бус өвийн судалгаа, мэдээллийн нэгдсэн сан бий болгож, өвлөн уламжлагчдыг өсвөр үе, залуучуудад сурталчлан таниулж, өвлөн уламжлуулна	2.6.2.1	Соёлын биет болон биет бус өвийн судалгаа, мэдээллийн нэгдсэн сан бий болгоно	2021-2024	БСУГ,АЗДТГ	25	0	10	Түүх соёлын үл хөдлөх дурсгалын RICH программ, биет бус өвийн Register программыг ашиглан цахим мэдээллийн сан бий болгох ажлын хүрээнд Соёлын өвийн Үндэсний төв, Боловсрол, соёл урлагийн газар, Мэргэжлийн хяналтын газар, аймгийн музей хамтран чадавхжуулах сургалтыг цахимаар зохион байгуулж 23 сумын соёлын төвийн 46 ажилтан хамрагдсан."Эх нутаг өв соёлоо эрхэмлэн дээдэлье" монгол түмний их аяны хүрээнд Тахилга шүтлэгт газар нутгийн бүртгэлийн программ болох www.tahilga.mongoluv.mn програмд Завхан аймгийн тахилга шүтлэгт 113 газрын мэдээлэл, "Соёлын биет бус өвийн бүртгэлийн www.ich.mongoluv.mn программд Завхан аймгийн 548 өвлөн уламжлагчийн ерөнхий мэдээллийг оруулсан нь хүүхэд залуучууд тус программд нэвтрэн СББӨ-ийн өвлөн уламжлагчдын дэлгэрэнгүй мэдээллийг үзэх боломжтой боллоо.	70
	2.6.2.2	Биет бус өвийг хамгаалах, өвлүүлэхэд зориулж видео контент бэлтгэнэ	2021-2024	БСУГ,АЗДТГ	18	1	5	Соёлын яамнаас санаачлан хэрэгжүүлсэн 21 аймгийн авьяаслаг суралцагч, хүүхэд багачуудын төлөөлөл оролцсон "Бид-Ирээдүйн эзэд" видео контентод Дэвшил сургуулийн 4а ангийн суралцагч С.Анунгоо Завхан аймгаас төлөөлөн амжилттай оролцож, Олон Улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөрөөр уг контент Үндэсний олон нийтийн телевизээр үзэгчдийн хүртээл болсон байна. Түдэвтэй сумын соёлын төв дуу бичлэгийн студээ түшиглэн Соёлын биет бус өвлөн уламжлагчдаа сурталчлан таниулсан видео контентыг бүтээн цахим орчинд байршуулсан. Мөн Сонгино, Тэс, Цагаанхайрхан сумын соёлын төвийн музейн ажилтнууд "Ахмадын сургаальт" аяныг амжилттай хэрэгжүүлж 8 видео контентыг бүтээж цахимаар сурталчилсан.	50
	2.6.2.3	Аймаг байгуулагдсаны 100 жилийн ойг тохиолдуулан "Дилов хутагт" баримтат кино бүтээхэд дэмжин ажиллана	2021-2021	БСУГ,АЗДТГ	50	0	1	"Дилов хутагт" бүрэн хэмжээний уран сайхны киноны зохиол бичигдэж, зураг авалтын ажил 2022 оны 2 сард эхлэхээр төлөвлөгдөж байна.	0
	2.6.2.4	"Отгонтэнгэрийн төрийн их тахилга"-ыг тохиолдуулан "Очирвааний орон" кино бүтээхэд дэмжлэг үзүүлнэ.	2021-2021	БСУГ,АЗДТГ	50	0	1	"Гэгээн медиа" энтертаймент ХХК-тай гэрээ байгуулан Отгонтэнгэр хайрханы тухай түүх домог, тахилгын онцлог, шүтэх хэлбэр, албан ёсны нэр, нэршлийн утга агуулгын тухай шинжлэх ухааны судалгаанд суурилсан баримтат киног бүтээхэд 20.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгож, киноны эх хувийг ажлын хэсэг хүлээн авсан байна.	100
Номын сангийн цахим сан хөмрөгийн эзлэх хувийг нэмэгдүүлнэ	2.6.3.1	Номын сангийн цахим сан, фондыг баяжуулна	2021-2024	БСУГ,АЗДТГ	0	0	0	2021 онд ном хэвлэлийн зардал 2.8 сая төгрөг төсөвлөгдсөнөөс I-IV-р улиралд 105 ширхэг 2.3 сая төгрөгийн ном, 6 нэр төрлийн 517400 төгрөгийн тогтмол хэвлэлийн худалдан авалт хийсэн байна. Цахим номын сангийн үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн судалгаа хийгдсэн. Монгол улсад хэвлэгдсэн бүх тогтмол хэвлэлийг Үндэсний тогтмол хэвлэлийн мэдээллийн санд оруулах ажлыг улсын хэмжээнд эхлүүлэн Туяа сонины 1947-1990 оны нийт 10114 нүүрийг 100% скайнердаж Омега програмд оруулах ажил 25%-тай явж байна. 2022 оны I улиралд 100% оруулахаар төлөвлөн ажиллаж байна.	50
Үндэсний бахархал, Монгол өв соёлоо өвлүүлэхэд чиглэсэн аялал жуулчлалын шинэ бүтээгдэхүүн бий болгоно	2.6.4.1	Цахим орчин дахь аялал жуулчлалын мэдээллийг нэгдсэн сувгаар түгээнэ.	2021-2024	БСУГ,АЗДТГ		0	50	Байгаль орчин аялал жуулчлалын газраас "Завханаар аялъя" цахим хуудсуудыг бий болгож мэдээ мэдээлэл, аяллын маршрутыг байршуулсан байна.	30
	2.6.4.2	Түүхэн дурсгалт газруудыг аялал жуулчлалын маршрутад оруулна.	2021-2024	БСУГ,АЗДТГ		0	10	Түүхэн дурсгалт газруудын мэдээлэл судалгаа, тайлбар хийгдэж, Байгаль орчин аялал жуулчлалын газраас "Завханаар аялъя" цахим хуудсуудыг бий болгож мэдээ мэдээлэл, аяллын маршрутыг байршуулан сурталчилж байна.	30

Монгол хэл, бичгийн нийтийн болон албан хэргийн хэрэглээг өргөжүүлнэ	2.6.5.1	Аймгийн бүх шатны сургалтын байгууллагын суралцагчдын эх хэл, бичиг соёлыг эзэмшсэн түвшинг ахиулна.	2021-2024	БСУГ,АЗДТГ	20	30%	40%	Аймгийн Засаг даргын санаачлагаар ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдын дунд зохион байгуулсан "Миний эх орон-Монгол" цахим уралдааны "Цэрэг эх орон" ны сэдэвт шүлгийг монгол бичгээр бичих уралдаанд 45 суралцагч амжилттай оролцсон байна."Ковидгүй Завхан" цахим аяны хүрээнд "Уран бичигтэн" уралдаанд ахлах ангийн 56 суралцагч хамрагдсан байна. 9 дүгээр сарын 01-ний Эх хэлний өдрийг тохиолдуулан Хэлний бодлогын үндэсний зөвлөлөөс Монгол бичгийн хичээнгүй бичгийн нэг сарын аяныг зохион байгуулж уг аянд аймгийн 29 ЕБС-ийн дунд ахлах ангийн 8300 суралцагч оролцож сум, сургууль бүр шилдгээ шалгарууллаа.	70
	2.6.5.2	Аймгийн хэмжээнд Үндэсний бичгийн шат дараалсан сургалтыг зохион байгуулна.	2021-2024	БСУГ,АЗДТГ	40	40%	50%	БШУ-ны яам, Хэлний бодлогын Үндэсний зөвлөлтэй хамтран зохион байгуулсан "Монгол бичгийн Үндэсний хөтөлбөр-III"-ыг хэрэгжүүлэх арга зүйн сургалтанд БСУГ-ын Монгол хэл, уран зохиолын судлагдахуун хариуцсан мэргэжилтэн болон ЕБС-ийн Монгол хэл уран зохиолын 30 багш хамрагдлаа. Үндэсний статистикийн газраас зохион байгуулсан "Төрийн албан хаагчдын үндэсний бичгийн түвшин тогтоох судалгаа"-г аймгийн Статистикийн хэлтэс, Хэлний бодлогын салбар зөвлөлтэй хамтран зохион байгуулж, судалгаанд аймгийн төрийн албан хаагчдын 99% хамрагдсан байна.Төрийн албан хаагчдад үндэсний бичиг үсгийн сургалтыг сумдын салбар зөвлөл, монгол хэл бичгийн багш нар хамтран зохион байгуулж албан хаагчдын 45% нь онлайн болон танхимын сургалтад хамрагдсан байна. Мөн УИХ-ын гишүүн Б.Баярсайхан санаачлан Баярсайхан сангаас зохион байгуулсан мэргэжлийн багш нарын зөвлөлдөх онлайн уулзалтыг 2021 оны 05 дугаар сарын 2-нд Үндэсний бичиг үсгийн баярыг тохиолдуулан зохион байгуулж уг уулзалтад УИХ-ын гишүүн Б.Баярсайхан, Хүмүүн бичиг сонинны эрхлэгч судлаач багш Б.Элбэгзаяа, БУТ-ийн Эпсэлтийн ерөнхий шалгалт хариуцсан мэргэжилтэн н.Энхжаргал болон аймгийн монгол хэл бичгийн 16 багш оролцож, ЕБС-д монгол бичиг заах арга зүй, Монгол бичгийн үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга замын талаар ярилцаж, санал бодлоо солилцлоо.	90
	2.6.5.3	Хувийн байгууллагуудын хаягжилт, барааны тэмдэгт, шошго зэрэгт Үндэсний бичгийн хэрэглээг нэмэгдүүлнэ.	2021-2023	БСУГ,АЗДТГ	10	0	50%	Хувийн байгуулага болон аж ахуй нэгжүүдийн хаягжилт, бараа бүтээгдэхүүний нэр шошго зэргийг үндэсний бичгээр бичиж хэвших ажил хангалтгүй байна.	30
Соёлын биет, биет бус өвийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулна	2.6.6.1	Музейн хосгүй ховор үнэт дурсгал, үзмэр эд өлгийн зүйлийг бүртгэлжүүлэн, даатгалд хамруулна	2021-2024	БСУГ,АЗДТГ	20	0	10	Музейн хосгүй ховор үнэт дурсгал, үзмэр эд өлгийн зүйлийн аймгийн хэмжээнд 146, улсын хэмжээнд цам бүжгийн Шүрэн баг, Яруу сумын Намжил баяны эхнэр хүний толгойн гоёл зэрэг 5 үзмэрийг судлан тодорхойлж, баталгаажуулахаар Соёлын яам болон холбогдох газарт хүргүүлээд байна.Соёлын баримат өв эзэмшигчдийн судалгааг аймгийн музей, сумдын соёлын төвийн орон нутаг судлах танхимын ажилтнуудтай хамтран хийж, иргэдийн гар дээр хадгалагдаж байгаа 136 соёлын баримат өвийн судалгааг Соёлын яаманд албан бичгээр хүргүүлсэн	50
	2.6.6.2	Ховор эд өлгийн зүйлс эзэмшигчдэд гэрчилгээ олгож, урамшуулна	2021-2024	БСУГ,АЗДТГ	30	0	1	Баримат өв эзэмшигчдийн судалгааг аймгийн музей, сумдын соёлын төвийн орон нутаг судлах танхимын ажилтнуудтай хамтран хийж, Соёлын яаманд албан бичгээр хүргүүлсэн байна. Аймгийн хэмжээнд 136 соёлын баримат өв иргэдийн гар дээр хадгалагдаж байна.	50
	2.6.6.3	"Соёлын бүтээлч үйлдвэрлэл-II" арга хэмжээг хэрэгжүүлнэ	2021-2024	БСУГ,АЗДТГ	100	90%	92%	Соёлын яамнаас 11 дүгээр сарыг "Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн сар" болгон зарласантай холбогдуулан СУИС-ийн Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн тэнхимийн эрхлэгч Ж.Эрхэмтөгс багштай хамтран 23 сумын соёлын төвийн эрхлэгч нарт Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн талаарх ойлголт сургалтыг 2021 оны 10 сарын 15-ны өдөр зохион байгуулж, соёлын ажилтнуудаа чадавжуулах сургалтад хамруулах, орон нутагт соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хэрхэн хөгжүүлэх талаар санал солилцож хамтран ажиллах төлөвлөлт хийгдэж байна.	30
Соёл урлагийн үйлчилгээний чанар хүртээмж, нэр төрөл, хамтын ажиллагааг өргөжүүлнэ	2.6.7.1	Мэргэжлийн урлагийн байгууллага, соёлын төвүүдийг шаардлагатай хөгжмийн зэмсэг, хувцас, хэрэглэлээр хангана	2021-2024	БСУГ,АЗДТГ	66	35%	38%	Соёлын байгууллагуудад шаардлагатай байгаа ардын хөгжмийн зэмсэг, хувцас хэрэглэлийн судалгааг хийж, "Үндэсний бахархал, Монгол өв соёл" арга хэмжээний 4 дүгээр зорилтод тусган үе шаттай төлөвлөн ажиллаж байна. 2022 оны аймгийн хөгжлийн төлөвлөгөөнд саналыг тусгасан байна.	30
	2.6.7.2	"Цахим соёл" арга хэмжээг хэрэгжүүлнэ	2021-2024	БСУГ,АЗДТГ	70	0%	20%	Соёлын яамнаас хэрэгжүүлсэн "Цахим соёл" аяны хүрээнд Хөгжимт жүжгийн театрын 37 уран бүтээлчдийн цахим тоглолт, музейн 15 удаагийн тайлбарт аялал, ном уншлагыг дэмжих 4 удаагийн цахим аяныг зохион байгуулж ажилласан байна. Мөн Төв номын сангаас санаачлан "Үлгэрийн цаг" ном уншлагын цагийг цахим хэлбэрээр зохион байгуулахаас гадна насанд хүрэгчдэд зориулсан сургажмат өгүүлэлийг ХЖТ-ын уран бүтээлчидтэй хамтран цувралаар хүргэж байна.	70
	2.6.7.3	"Бүх нийтийн соёлын боловсрол" арга хэмжээг хэрэгжүүлнэ	2021-2024	БСУГ,АЗДТГ	40	0%	20%	Бүх нийтийн соёлын боловсрол арга хэмжээний хүрээнд СУИС-ийн салбар Хөгжим бүжгийн коллежтой хамтран ард иргэдэд соёлын боловсрол олгох чиглэлээр цуврал лекц, хичээлүүдийг бэлтгэхээр ажиллаж байна.	30

Соёл урлагийн салбарын хүний нөөцийг чадавхжуулна	2.6.8.1	Соёл урлагийн салбарыг мэргэжлийн боловсон хүчнээр бүрэн хангаж, мэргэшүүлэх ажлыг шат дараатай зохион байгуулна	2021-2024	БСУГ,АЗДТГ	20	65%	66.2%	СУИС-ийн салбар аймгийн Хөгжим бүжгийн коллежид хөгжмийн багш мэргэжлээр Тэлмэн, Нөмрөг, Тосонцэнгэл, Их-Уул сумын хөгжим, бүжгийн багш нар, аймгийн Хөгжимт жүжгийн театрын 2 хөгжимчин суралцаж байна. Мөн Сонгино, Асгат сумын соёлын төвийн дарга нар Газарчин дээд сургуулийн Соёл судлалын магистрын хөтөлбөрт, ХЖТ-ын дарга Удирдлагын академийн докторын хөтөлбөрт тус тус суралцаж байна. Соёлын яам, СУИС, Монголын соёлын төвүүдийн "Хөгжлийн эрин" холбоотой хамтран зохион байгуулсан соёлын төвийн ажилтнуудыг чадавхжуулах сургалтад 120 ажилтан хамрагдаж, мэргэжил боловсролоо дээшлүүлэн 2 кредитийн сертификат авсан байна.	90
2.6 ДУГААР ЗОРИЛТЫН ДҮН									53.81
ХОЁРДУГААР БҮЛГИЙН ДҮН									64.78
ГУРАВ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО									
	3.1	Эдийн засгийн тогтвортой өсөлт иргэн бүрт хүрсэн, дундаж давхарга зонхилсон, эдийн засгийн суурийг бүрдүүлж, хөрөнгө оруулалт хуримтлалын чадавхаа бэхжүүлсэн, олон тулгуурт эдийн засагтай аймаг болно							
Макро эдийн засгийг хөгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг эрчимжүүлнэ	3.1.1.1	Аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлтийг нэмэгдүүлнэ	2021-2024	АЗДТГ,ХХААГ	0	7%	-2%	Аймгийн хэмжээнд 2020 онд дотоодын нийт бүтээгдэхүүн 488 тэр бум 807 сая төгрөгт хүрсэн байна. 2021 онд Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл эхний 10 сарын байдлаар 26 тэрбум 498 сая төгрөг болж, өнгөрсөн оноос 37.3 хувиар буюу 7 тэр бум 200 сая төгрөгөөр өссөн байна.	30
Орон нутгийн эдийн засгийн бүтцийг шинэчлэхэд чиглэсэн эдийн засгийг бодлого явуулна	3.1.2.1	Дотоодын нийт бүтээгдэхүүнд боловсруулах үйлдвэрлэлийн нэмэгдэл өртгийн эзлэх хувийг нэмэгдүүлнэ.	2021-2024	АЗДТГ,ХХААГ	0	12.1%	15.60%	2020 оны жилийн эцсээр 26669.6 сая төгрөгийн борлуулалт хийсэн бол 2021 оны 10 дугаар сарын байдлаар 20027.3 сая төгрөгийн борлуулалт хийсэн байна.	30
	3.1.2.2	Үйлчилгээний салбар /аялал жуулчлал/-ын салбарын нэмэгдэл өртгийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувийг нэмэгдүүлнэ	2021-2024	АЗДТГ,ХХААГ	0	41.7%	43.60%	2021 оны дотоодын нийт бүтээгдэхүүнийг 2022 оны хагас жилд тооцох тул хугацаа болоогүй.	0
	3.1.2.3	Хөдөө аж ахуйн салбарын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувийг нэмэгдүүлнэ	2021-2024	АЗДТГ,ХХААГ	0	46.2%	40.80%	Аймгийн хэмжээнд 2020 онд дотоодын нийт бүтээгдэхүүн 420.6 тэрбум төгрөг болсон байна. Үүнээс дотоодын нийт бүтээгдэхүүн хөдөө аж ахуйн салбарт 194.8 тэрбум буюу 46.3 хувийг бүрдүүлж байна.	70
	3.1.2.4	Дотоодын нийт бүтээгдэхүүнд хувийн хэвшлийн нэмэгдэл бүтээгдэхүүний эзлэх хувийг нэмэгдүүлнэ	2021-2024	АЗДТГ,ХХААГ	0	63.2%	68.10%	2020 оны жилийн эцсийн байдлаар ААНэгийн үйлдвэрлэл нь 28 тэрбум 327.1 сая төгрөг, иргэдийн үйлдвэрлэл нь 6 тэрбум 457.9 сая төгрөг болсон байна. 2021 оны 10 дугаар сарын байдлаар ААНэгийн үйлдвэрлэл нь 23 тэрбум 510.8 сая төгрөг, иргэдийн үйлдвэрлэл нь 2 тэрбум 987.9 сая төгрөг болсон байна.	30
Орон нутгийн татварын орлогыг нэмэгдүүлнэ	3.1.3.1	Орон нутгийн татварын орлогыг нэмэгдүүлнэ	2021-2024	ТХ,АЗДТГ		7669.5	9,657.60	2021 оны эхний 10 сарын байдлаар орон нутгийн татварын орлого төлөвлөгөөгөөр 7.8 тэрбум төгрөг байхаас 11.5 тэрбум төгрөгийн орлого орж, 142.7 хувийн гүйцэтгэлтэй байна. Аймгийн төсвийн орлого 118.5 хувь, сумдын татварын орлого нь 252.4 хувийн гүйцэтгэлтэй байна.	100
Төсвийн үр ашигтай, ил тод, шуурхай байдлыг хангуулна	3.1.4.1	Төсвийн үр ашигтай, ил тод, шуурхай байдлыг хангуулна	2021-2024	АЗДТГ,СЗДТГ		22,151.90	26,247.40	2021 оны эхний 10 сарын байдлаар орон нутгийн төсвийн зарлага хүлээгдэж буй гүйцэтгэлээр 84.9 тэр бум төгрөг төсөвлөгдсөнөөс 77.9 тэр бум төгрөг буюу 91.7 хувь нь зарцуулагдсан байна. Монгол Улсын Засгийн газрын 43 дугаар тогтоолын дагуу дээрх зардлын хэмнэлт бий болсон.	100
Үйлдвэрийн аргаар боловсруулсан махны хэрэглээ,	3.1.5.1	Жилд 500-1000 тонн мах боловсруулах хүчин чадалтай махны үйлдвэрүүдийн үйл ажиллагааг эрчимжүүлнэ	2021-2024	ХХААГ, АЗДТГ	50.0	4,373.6	4,810.96	Мах боловсруулах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа Завхан хүнс групп ХХК, Нисэг-Агро ХХК, Баян Нью пүүд центури ХХК, Тэс Шим хоршооны үйлдвэрийн үйл ажиллагаа эхэлсэн бөгөөд 70-500 тн мах бэлтгэх төлөвлөгөөтэй ажиллаж байна. Тэс шим хоршоо нь 120 тн ыг үйлдвэрийн аргаар бэлтгэхээр ажиллаж байна.	70

экспортыг нэмэгдүүлнэ	3.1.5.2	Орон нутгийн нөөцөд тулгуурлан бие даасан махны экспортын гэрээ хэлэлцээрт оролцоно	2021-2024	АЗДТГ-ын ТЗУХ	20	суурь түвшин гараагүй	2	Зарим аймгуудад малын гоц халдварт өвчин гарсан тул махны экспортыг зогсоосон.	0
Орон нутаг дахь үйлдвэрлэлийн аргаар боловсруулсан сүү, сүүн бүтээгдэхүүний гарцыг нэмэгдүүлнэ	3.1.6.1	Суманд пробиотек бүтээгдэхүүн нийлүүлэх хөнгөн үйлдвэрийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөрийн "ENSURE" төсөлтэй хамтран бий болгоно	2020-2021	АЗДТГ-ын ХОХБТХ	120	0	1	Их-Уул суманд пробиотек бүтээгдэхүүн нийлүүлэх хөнгөн үйлдвэрийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөрийн "ENSURE" төсөлтэй хамтран хэрэгжүүлж, ашиглалтад хүлээн авахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.	70
	3.1.6.2	Бяслагы үйлдвэрийн үйл ажиллагааг эхлүүлнэ	2021-2022	ХХААГ	50	0	1	АДРА Олон улсын байгууллагын 155.0 мянган ам долларын хөрөнгө оруулалтаар Идэр суманд бяслагны үйлдвэр байгуулахаар шийдвэрлэж барилгын ажил дууссан, COVID цар тахлын улмаас үүссэн нөхцөл байдалтай холбоотойгоор тоног төхөөрөмжийн асуудал шийдэгдээгүй байна.	70
	3.1.6.3	Гэрийн нөхцөлд боловсруулсан цагаан идээний сав баглаа боодлыг сайжруулна	2021-2024	ХХААГ	10	5	5	Сумдын ХААТ-ийн мэргэжилтнүүдээр дамжуулан хүнсний зориулалттай сав баглаа боодлын зөвлөмжийг нийт 124 малчид, аж ахуйн нэгжүүдэд сурталчилсан.	70
Малаас гаралтай бүтээгдэхүүнийг боловсруулах үйлдвэрлэлээр дамжуулж, хөдөө аж ахуйн салбарын орлогыг нэмэгдүүлнэ	3.1.7.1	Малын дайвар бүтээгдэхүүнийг стандартын дагуу бэлтгэж, хагас боловсруулан, зах зээлд нийлүүлэх цехийн үйл ажиллагааг дэмжинэ	2021-2024	ХХААГ	80	4	4	Анх-Энэрлэн ХХК 2020 оны 12 дугаар сард ЖДҮХөгжүүлэх сангаас 50.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлд хамрагдаж малын дайвар бүтээгдэхүүнээр 10 нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна.	100
	3.1.7.2	Махны эрүүл ахуй, чанар стандартад хяналт тавьж экспортлогч үйлдвэрүүдтэй уялдуулан борлуулалтад дэмжлэг үзүүлнэ	2021-2024	ХХААГ	20	0.50%	2%	Аймгийн хэмжээнд 14.9 мянган малчин болон мал бүхий өрх, 3,6 сая мал, мал эмнэлгийн нэгдсэн системд бүртгэгдсэн байна. Зах, худалдааны төвд чанар эрүүл ахуйн шаардлага хангасан, гарал үүслийн гэрчилгээтэй, малын махыг худалдан борлуулж байна. Мал эмнэлгийн газартай хамтран Завхан хүнс групп ХХК махны үйлдвэрийн үйл ажиллагаатай танилцаж мэдээлэл зөвлөмжийг хүргүүлсэн.	100
Орон нутгийн барилгын материалын нөөцөд тулгуурлан, нөхцөл	3.1.8.2	Хувийн орон сууцны бэлдэцийг нийлүүлэх төвлөрсөн цэгүүд бий болгоно	2021-2024	ХХААГ		0		Ковид-19 цар тахлын улмаас барилгын материалын хомсдол үүссэн, үнийн өсөлтийг хязгаарлах зорилгоор барилгын материалын бэлдэц /цемент/ борлуулах цэгийг богдын гол багт байгуулан ажиллаж байна.	30
	3.1.9.1	Гамшгийн үед хувийн салбарын санхүүгийн алдагдлыг багасгана	2021-2024	АЗДТГ	50	5	8	Онцгой байдлын газраас Гамшгаас хамгаалах тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг 2021 онд хангуулах чиглэлээр төсөв хөрөнгөтэй холбоотой дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүллээ. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 11 дүгээр тогтоолоор Гамшгаас хамгаалах, эрсдлийг бууруулах арга хэмжээний зардалд 320.0 сая төгрөг, Хөгжлийн төлөвлөгөөнд батлагдсан 2 ажил үйлчилгээг аймгийн Засаг даргын 2021 оны А/08 дугаар захирамжаар эрх шилжүүлэн зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангасан. Аймгийн 2021 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөнд гамшгаас хамгаалах чиглэлээр тусгагдсан орон нутгийн хөгжлийн сангаас 98.6 сая төгрөг, Засаг даргын нөөц сангаас 97.4 сая төгрөг нийт 196 сая төгрөг, Засаг даргын 2021 оны нөөц санд нийт 806.1 сая төгрөг төсөвлөгдсөн. 240.0 сая төгрөгийг гамшгаас хамгаалах арга хэмжээнд зарцуулахаар хуваарь хийж батлуулсан. Улсын онцгой комиссын ажлын албанд хагас бүтэн жилээр хөрөнгө зарцуулалтын тайланг гаргаж хүргүүлсэн.	90

Гамшгийн үеийн эдийн засгийг тогтворжуулж, хувийн салбарын санхүүгийн чадамжийг дээшлүүлнэ	3.1.9.2	Гамшгийн үед төр, хувийн хэвшлийн бэлэн байдлыг хангуулан, хамтын ажиллагааг өргөжүүлнэ	2021-2024	АЗДТГ	50	5	6	Монгол Улсын Шадар сайдын 2021 оны 22 дугаар тушаал, аймгийн Онцгой комиссын шуурхай штабын 32 дугаар хурлын шийдвэрийн дагуу Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын үеийн орон нутгийн шуурхай штаб, шуурхай хариу арга хэмжээний багуудыг аймгийн Засаг даргын 2021 оны А/141 дүгээр захирамжаар 7 баг, 10 бүлэгтэйгээр шинэчлэн байгуулсан. Аймгийн гамшгаас хамгаалах 12 алба, 35 мэргэжлийн ангийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан тухай бүр тодотгол хийлгэн ажилласан. Аймгийн Засаг даргын баталсан удирдамж, хөтөлбөр төлөвлөгөөний дагуу Отгон, Их-Уул, Баянхайрхан сумдад Гамшгаас хамгаалах команд штабын сургууль, Тосонцэнгэл суманд Гамшгаас хамгаалах Иж бүрэн сургууль, Яруу, Алдархаан сумдад гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэг зохион байгуулсан. Сургалтад нийт 1570 гаруй хүн, 71 машин техник хамрагдсан. Сумын үнэлгээ: Улиастай, Тосонцэнгэл, Их-Уул, Тэлмэн, Яруу, Алдархаан, Сонгино, Нөмрөг, Түдэвтэй нийт 9 суманд гамшгийн эрсдлийн ерөнхий үнэлгээг хийж сумын гамшгийн эрсдлийн түвшинг анхан шатанд тодорхойллоо. Ерөнхий боловсролын үнэлгээ: Улиастай, Тосонцэнгэл, Их-Уул, Тэлмэн, Яруу, Алдархаан, Сонгино, Нөмрөг, Түдэвтэй сумдын нийт 10 ерөнхий боловсролын сургуульд гамшгийн эрсдлийн ерөнхий үнэлгээг Сургуулийн гамшгийн эрсдлийн үнэлгээний аргачлалаар хийсэн. Үнэлгээний ажлын хэсэгт сургуулийн захирал, сургалтын менежер, сургуулийн эмч, багш, сурагч, эцэг эхийн төлөөлөл гэсэн бүрэлдэхүүнтэйгээр ажилласан ба гамшгийн эрсдэл, гамшиг, аюулт үзэгдэл эмзэг байдал, чадавхын талаар мөн тахимын сургалтыг орсон. Үнэлгээнд нийт 112 хүн оролцсон. Байгууллагын гамшгийн эрсдлийн менежментийн чадавхын үнэлгээ: Тэлмэн, Яруу, Алдархаан, Нөмрөг, Түдэвтэй, Сонгино сумдын Эрүүл мэндийн төв, цэцэрлэг, Соёлын төвд нийт 16 байгууллагад гамшгийн эрсдлийн ерөнхий үнэлгээг холбогдох аргачлалын дагуу үнэлж, гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө хийж, гамшгаас хамгаалах бэлэн байдлын төлөвлөгөөнд нь тодотгол хийлгэсэн.	90
	3.1.9.3	Гамшгийн үеийн нөхцөл байдалтай уялдуулан стратегийн нөөц бүрдүүлнэ.	2021-2024	АЗДТГ	40	7	10	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар батлагдсан Засаг даргын нөөц сан, аймгийн 2021 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөнд гамшгаас хамгаалах чиглэлээр тусгагдсан орон нутгийн хөгжлийн сангаас 98.6 сая төгрөг, Засаг даргын нөөц сангаас 97.4 сая төгрөг Орон нутаг хөгжүүлэх сангаас өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд 200 сая төгрөгийн аюулгүй нөөцийн өвс бэлтгэсэн. Нийт 396 сая төгрөг зарцуулсан байна.	90
Технологи мэдээллийн паркард суурилсан ХАА, хүнс, барилга, биотехнологийн туршилтын лабораториудыг байгуулахад дэмжлэг үзүүлнэ.	3.1.10.2	Инженер техникийн салбарын мэргэжилтэн болон чадварлаг боловсон хүчнийг бодлогоор дэмжинэ	2021-2024	ХХААГ	20	0	8	Барилга угсралтын мужаан-32, барилгын засал чимэглэл, сан техникийн чиглэлээр 120 мэргэжилтэн боловсон хүчинг сургаж байна.	100
Орон нутгийн брэнд бүтээгдэхүүнийг үйлдвэрлэлийн түвшинд хөгжүүлнэ	3.1.11.1	Гарааны бизнес төслүүдийн санхүүжилтийг нэмэгдүүлнэ	2021-2024	ХХААГ	150	48	68	ХААН банк ажлын байрыг нэмэгдүүлэх хөнгөлөлттэй зээлийг 39 аж ахуйн нэгжид 7.2 тэр бум, 133 иргэнд 4.1 тэр бум төгрөг, Төрийн банк 9 аж ахуйн нэгжид 1,5 тэр бум, 231 иргэнд 6.7 тэр бум төгрөгийн зээл олгосон байна.	100
	3.1.11.2	Улс, бүс нутаг, аймагт үзэсгэлэн худалдааг зохион байгуулна	2021-2024	ХХААГ	50	5	5	"Намрын ногоон өдрүүд-Үндэсний үйлдвэрлэл 2021" арга хэмжээнд Завхан Баялаг ХК, Мөнхөд мандаг ХХК, Анхил Дөрвөн Баатар ХХК-нууд оролцож 50 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүнийг сурталчлан 26 сая төгрөгийн борлуулалт хийсэн байна. Аймгийн ЗДТГ, ХАУТанхимтай хамтран "Алтан намар 2021" үзэсгэлэн худалдааг 2021 оны 10 дугаар сарын 29-30-ны өдрүүдэд зохион байгуулж энэ арга хэмжээнд 10 гаруй сумын 52 тариалан эрхлэгч оролцож 19,0 сая төгрөгийн борлуулалт хийсэн байна.	100
	3.1.11.3	Аймгийн хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ	2021-2024	ХХААГ	0	25980.4	26500.01	2021 оны 10 сарын байдлаар нийт үйлдвэрлэлийн 20.2 хувь буюу 3183.2 сая төгрөгийн хүнсний үйлдвэрлэл эзлэж, энэ онд СХСангаас хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхэлдэг 5 аж ахуйн нэгжид зээл олгосон байна.	70
	3.1.11.6	Орон нутгийн давуу талыг түшиглэн хөрш зэргэлдээ улс, аймгуудад бүтээгдэхүүн нийлүүлэх сувгийг өргөжүүлнэ	2021-2024	ХАУТ	50	3	5	Завхан аймгаас 2021 оны 11 сарын 20-ноос 12 сарын 20 хүртэл 145.7 тонн махыг УБ хотын 3 цэг худалдан борлуулах зорилгоор сумдад хуваарь гарган хүргүүлж, бэлтгэн нийлүүлэх ажлыг зохион байгуулж байна.	50

	3.1.11.7	Орон нутгийн брэнд бүтээгдэхүүнийг борлуулдаг албан ёсны платформ бий болгож борлуулалтыг дэмжинэ	2021-2024	ХХААГ	60	0	30000	Намрын ногоон өдрүүд-Үндэсний үйлдвэрлэл 2021 арга хэмжээ Улаанбаатар хотод зохион байгуулагдаж, Завхан Баялаг ХК, Мөнхөд мандаг ХХК, Идэр сумын Анхил Дөрвөн Баатар ХХК оролцсон. "Аптан намар 2021" үзэсгэлэн худалдааг Улиастай суманд зохион байгуулан аймгийн брэнд бүтээгдэхүүнийг сурталчлах, борлуулалтыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлж борлуулалтын цэг, талбайгаар хангаж ажилласан.	70
	3.1.11.8	"Завханд үйлдвэрлэв" лого-г эзэмшүүлж үйлдвэрлэгчдийг дэмжинэ	2021-2024	ХАҮТ	10	5	20	"Завханд үйлдвэрлэв" логог хэрэглэх журмыг аймгийн ХАҮТанхим боловсруулсан. 2021 оны 11 дүгээр сарын 24-нд нийтийн сонсгол зохион байгуулан, иргэдээр хэлэлцүүлж тус журмыг 12 дугаар сард багтаан аймгийн ИТХурлаар хэлэлцүүлэхээр хүлээгдэж байна.	70
Төрийн худалдан авах ажиллагаагаар дамжуулан орон нутгийн жижиг дунд үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний борлуулалтыг дэмжинэ	3.1.12.1	Томоохон төслүүдийг орон нутгийн цахим сүлжээнд байршуулж, иргэдийн оролцох боломжийг нэмэгдүүлнэ	2021-2024	ХХААГ	1	60%	80%	Ажлын байрыг нэмэгдүүлэх 3 хувийн 3 жилийн хугацаатай зээлийн мэдээллийг 2 удаа, Малчдыг дэмжих, Ноолуур бэлтгэл, Хаврын тариалалтын зээлийн мэдээллийг 1 удаа цахим хэлбэрээр байршуулж, сумдын ХААТасгаар дамжуулан мэдээллийг хүргүүлсэн.	100
Бичил, жижиг, дунд үйлдвэрлэлийн бэлтгэн нийлүүлэлт, борлуулалтын тогтолцоог кластерийн	3.1.13.2	Маркетингийн үйлчилгээ үзүүлэх зөвлөх компаниудтай хамтран ажиллана	2021-2024	ХХААГ	20	1	3	ХХААХҮЯам, ХААДСан, төсөл хөтөлбөрүүдээс ирсэн мэдээ, мэдээллийг байгууллагын za.hhaag.gov.mn вэб сайт, сумдын ХААТасгийн нэгдсэн цахим хаяг, завхан аймгийн нэгдсэн зарын групп дээр байршуулан иргэд болон аж ахуйн нэгжид хүргэж байна. Одоогийн байдлаар орон нутагт маркетингийн үйлчилгээ үзүүлдэг аж ахуйн нэгж байхгүй байна.	100
Гарааны бизнес эхлүүлж буй аж ахуйн нэгж, иргэдийн ЖДҮХС, СХС, ХЭДС-ийн зээлийн хамрагдалтыг нэмэгдүүлнэ	3.1.14.1	ЖДҮХС, СХС, ХЭДС -ийн зээлийн материал бүрдүүлэлт, шалгаруулалтыг цахим системээр дамжуулан хийнэ	2021-2024	ХХҮГ		5%	10%	Монгол улсын Засгийн газрын 2020 оны 113 дугаар тогтоолоор баталсан "Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын дагуу ЖДҮХСангийн зээлд хамрагдах хүсэлтэй аж ахуйн нэгжийн материалыг хүлээн авч шийдвэрлэж байна. 2021 онд ЖДҮХСангийн эх үүсвэр батлагдаагүй тул зээл олгогдоогүй байна.	70
	3.1.14.2	Банкууд, бизнес эрхлэгчдийн уулзалт зохион байгуулна	2021-2024	ХХҮГ	3	500	600	Аймгийн Худалдаа аж үйлдвэрийн танхимаас 2021 оны 02 дугаар сарын 26-ны өдөр бизнес эрхлэгчидтэй уулзалт зохион байгуулж энэ арга хэмжээнд 120 гаруй хүн хамрагдсан. Жижиг Дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгжүүдэд жилийн 3 хувийн хүүтэй, 500 сая хүртэлх төгрөгийн зээлийг эхний жил зөвхөн хүүгийн төлбөр төлөх нөхцөлтэйгөөр 3 жилийн хугацаатайгаар орон нутагт үйл ажиллагаа явуулж буй бүх банкаар дамжуулан олгохоор болсон.	100
	3.1.14.3	СХС, ЖДҮХС, ХЭДС-ийн зээлийг орон нутгийн үйлдвэрлэлийн тэргүүлэх чиглэлтэй уялдуулна	2021-2024	ХХҮГ	500	10%	20%	Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх зорилгоор СХСангаас Цагаанчулуут, Тэлмэн, Эрдэнэхайрхан сумдууд 24 иргэнд 147 сая төгрөгийн зээл олгосон. 2021 оны 5 сарын байдлаар олгогдсон зээлүүд 100 хувь тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа иргэдэд олгосон байна. СХСангаас 178 иргэнд 1086.2 сая төгрөгийн зээл олгогдсон байна.	90
	3.1.14.4	Банкны болон төслийн зээлийн шалгуурт шинэ бизнесийг дэмжих хэмжээг нэмэгдүүлнэ	2021-2024	ХХҮГ	1000	суурь түвшин гараагүй	5%	2021 онд 178 иргэн, аж ахуйн нэгжид 1 тэр бум 86 сая төгрөгийн зээлийг сум хөгжүүлэх сангаас олгож, үйлдвэрлэл үйлчилгээг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлсэн.	70
	3.1.15.2	Орон нутагт хэрэгжиж буй төслүүдийн дэмжлэгтэй байгуулагдсан бүлэг, хоршоодын үйл ажиллагааг дэмжинэ	2021-2024	ХХААГ	500	300	350	Европын холбооны санхүүжилтээр Дэлхийн зөн байгууллагаас хэрэгжүүлж байгаа "Завхан аймгийн эдийн засгийн хөгжил, өсөлтөнд Иргэний нийгмийн байгууллагуудын оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэх нь" төслийн хүрээнд төсөл хэрэгжиж байгаа 12 сумын 24 бүлэгт нийт 120 гаруй сая төгрөгийн гутал, цагаан идээ, жимс, жимсгэнэ, гурилан бүтээгдэхүүн, арьс шир боловсруулах, мод модон эдлэл, газар тариалангийн тоног төхөөрөмж, ноос, арьс шир боловсруулах тоног төхөөрөмжийг нийлүүлсэн.	100

Малчид тариаланчид, сумын төвийн өрхүүдийн хамтын сан, хоршооны үйл ажиллагааг дэмжиж, өрхийн орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлнэ.	3.1.15.3	Хөрөнгийн зах зээлийн мэдлэг олгох түргэвчилсэн сургалтуудыг зохион байгуулна	2021-2025	ХХААГ	10	0	100	"BEST" сургалтын төвөөс компанийн засаглал, бизнес төсөл боловсруулах арга, санхүүгийн мэдлэг олгох зэрэг 31 удаагийн сургалтаар 310 бизнес эрхлэгчдийг хамруулсан байна.	100
	3.1.15.4	Бизнес эрхлэгчдэд "Зээлийн батлан даалтын сан"-гаас дэмжлэг үзүүлэхэд зуучлах үйлчилгээг өргөжүүлнэ	2021-2024	ХХААГ	0	1%	2%	Зээлийн батлан даалтын санд зуучлах үйл ажиллагааг орон нутагт хөгжлийн шийдэл "BEST" сургалтын төв явуулж байна. Энэ онд "Завханы улаан хальст саримс" ХХК 150 сая төгрөгийн зээлийн 50 хувьд зээлийн батлан даалт гаргуулсан байна.	100
	3.1.15.5	Өрхүүдэд санхүүгийн боловсрол олгох сургалт сурталчилгааг нэмэгдүүлнэ	2021-2024	ХХААГ	20	1500	2500	Европын холбооны санхүүжилтээр Дэлхийн зөн байгууллагаас хэрэгжүүлж байгаа "Завхан аймгийн эдийн засгийн хөгжил, өсөлтөд Иргэний нийгмийн байгууллагуудын оруулах хувь нэмрийг нэмэгдүүлэх нь" төслийн хүрээнд 21 бүлгийн давхардсан тоогоор 610 иргэнд "Нэмүү өртөгийн сүлжээ", "Байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэл", "Бүлэг байгуулах, хөгжүүлэх", "Бүлгийн санхүү, багийн менежмент", "Маркетинг" зэрэг сургалтуудыг зохион байгуулсан.	70
3.1 ДҮГЭЭР ЗОРИЛТЫН ДҮН									74.29
	3.2	Байгальд ээлтэй технологи бүхий ил тод, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлнэ							
Уул уурхайн ил тод, хариуцлагатай байдлыг нэмэгдүүлнэ	3.2.1.1	Үйл ажиллагаа явуулж буй уул уурхайн компаниудтай хариуцлагын гэрээ байгуулж ажиллана	2021-2024	АСЗДТГ	0	0	2	Ургамал сум ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч Түүчээ тэрэг ХХК-тай 10 дугаар сарын 22-нд хамтын ажиллагааны гэрээ байгуулж талуудын байгаль орчныг хамгаалах, сумын хөгжлийг дэмжих дэд бүтэц, нийгмийн асуудлыг шийдвэрлэх талаар хүлээх үүрэг хариуцлагын талаар нийт 59 заалт тусган, ажиллаж байна.	100
	3.2.1.2	Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулж, тусгай зөвшөөрөл дахин олгохыг дэмжихгүй.	2021-2024	БОАЖГ	5	0	2	Ашигт малтмалын ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй Баян-Айраг эксплорейшн ХХК, Түүчээ тэрэг ХХК, Шувуун хар уул ХХК-иудын үйл ажиллагааг шалгах ажлын хэсэг газар дээр нь очиж ажиллан мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд явцын хяналт шалгалт хийсэн. Засгийн газрын 2018 оны 243 дугаар тогтоолоор батлагдсан ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох боломжтой талбай дээр нэмж Дөрвөлжин, Завханмандал, Ургамал сумдад 22082.85 га, 11261.63 талбайг хасаж Сонгино, Баянтас сумдад 11260.55 га талбайг нэмж санал ирүүлснийг судлан аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн саналыг авч аймгийн Засаг даргын 2021 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 2/712, 8 дугаар сарын 17-ны 1/905 дугаар албан бичгээр дэмжихгүй саналыг тус тус хүргүүлсэн.	100
	3.2.1.3	Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг нэмэгдүүлнэ	2021-2024	БОАЖГ	3		1	Орон нутагт төвлөрүүлсэн татвар, төлбөр хураамж, хандив дэмжлэгийн 2020 оны тайланг гаргаж, цахимаар УУХҮЯ, ОУИТБС-ын ажлын албанд хүргүүлсэн. Тайланг аймгийн http://zavkhan.gov.mn сайтад байршуулж мэдээлсэн. Эрдэс баялгийн гэрээний мэдээллийн санг эрхлэх үйл ажиллагааны журмын талаарх сургалтад аймгийн Засаг даргын орлогч, Ургамал, Завханмандал, Дөрвөлжин сумдын Засаг дарга нарыг хамруулсан.	90
	3.2.1.4	Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн байршуулсан барьцаа хөрөнгийн ашиглалт, зарцуулалтад хяналт тавина	2021-2024	БОАЖГ	1	5%	40%	Ашигт малтмалын 4 тусгай зөвшөөрөл эзэмшигч Байгаль орчин, аялал жуулчлалын яамны тусгай дансанд 32.8 сая төгрөг байршуулан ашиглалтын үйл ажиллагаа явуулсан. Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч 6 аж ахуйн нэгж сумын дансанд 7 сая төгрөгийн барьцаа хөрөнгийг байршуулан хайгуулын үйл ажиллагаа явуулсан. одоогоор барьцаа хөрөнгийг буцааж авах хүсэлт ирүүлсэн аж ахуйн нэгж байхгүй болно.	90
3.2 ДУГААР ЗОРИЛТЫН ДҮН									95
	3.3	Бэлчээрийн даацад нийцсэн ашиг шим өндөртэй эрүүл малыг өсгөн, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалтын сүлжээг өргөжүүлнэ							
	3.3.1.1	"Чинээлэг малчин" арга хэмжээ хэрэгжүүлнэ	2021-2024	ХХААГ, МЭГ,СЗДТГ	0	0	24	Арга зүйг боловсруулан аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр бэлтгэж байна.	30
	3.3.1.2	Малын эрүүл мэндийн мөшгөх тогтолцоог ISO стандартад нийцүүлнэ	2021-2024	ХХААГ, МЭ,СЗДТГ	0	22540	50000	Швейцарын хөгжлийн агентлагийн Малын Эрүүл Мэнд Ногоон Алт төсөл Завхан аймагт амжилттай хэрэгжиж Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуульд тусгагдсаны дагуу 24 суманд мал эмнэлгийн гэрчилгээг боловсронгуй болгох замаар малын эрүүл мэнд, гарал үүслийг баталгаажуулах гэрчилгээний системийг 2019 онд нэвтрүүлж vet.certificate.mn онлайн системд холбогдсон.	100

Эрүүл өндөр ашиг шимт мал сүргийг үржүүлнэ	3.3.1.3	Хөдөө аж ахуйн тасаг, мал эмнэлэг үйлчилгээний нэгжүүдийн ажиллах нөхцлийг сайжруулна	2021-2024	ХХААГ, МЭГ,СЗДТГ	20	2	4	2021 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн байдлаар аймгийн 24 сумын Хөдөө аж ахуйн тасагт нийт 52 ажилтан албан хаагч ажиллаж ажиллах хүчний бүрдэлт 72.2 хувь байна. 2021 оны 05 дугаар сарын 25-ний өдөр Аймгийн Засаг даргын тамгын газарт Хөдөө аж ахуйн тасгийн ажилтан албан хаагчдад шаардлагатай байгаа тоног төхөөрөмжийг "Эрдэнэт" үйлдвэрт ашиглагдаж байсан тоног төхөөрөмжөөс олгох тухай саналыг албан бичгээр хүргүүлэн ажилласан. Мөн сумдын Хүний нөөцийн судалгааг эхний хагас жилээр гарган цалингийн шатлал, ангилал зэрэглэлийн талаарх мэдээллийг ХХААХҮЯ-нд хүргүүлэн ажилласан. Бод, бог малын ангилагч шинжээч бэлтгэх дадлага, сургалт ХААИС-тай хамтран зохион байгуулж 24 сумын ХААТ, МҮТН-ийн 20 мал зүйчид ангилагч, шинжээчийн мэргэжлийн үнэмлэх олгов. Швейцарын хөгжлийн агентлагийн Ногоон алт-Малын эрүүл мэнд төсөл амжилттай хэрэгжиж Сантмаргаз суманд мал эмнэлгийн ерөнхий газартай байгуулсан гэрээний үндсэн дээр, Швейцарын хөгжлийн агентлагийн Ногоон алт-Малын эрүүл мэнд төслөөс 20,0 сая төгрөг, сумын орон нутгийн хөгжлийн сангаас 20,0 сая төгрөгийн санхүүжилт гарган мал эмнэлгийн тасаг, мал эмнэлгийн нэгж, малын эмийн сан, мал эмнэлгийн лабораторийн нэгдсэн байртай болсон. 2021 онд Эрдэнэхайрхан, Их уул сумын байр баригдахаар санхүүжилт шийдвэрлэгдэн барилгын ажил явагдаж байна.	70
	3.3.1.4	Эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлнэ	2021-2024	ХХААГ, МЭ,СЗДТГ	10	27	28	Эрчимжсэн мал аж ахуйг дэмжих арга хэмжээний хүрээнд аймгийн хэмжээнд 7 суманд 27 иргэн, ААН сүүний чиглэлийн эрлийз үхрийг үржүүлэх, 4 суманд 6 иргэн ААН гахай, шувууны аж ахуй эрхлэж байна.2021 онд Тэлмэн суманд сүүний чиглэлийн 1 аж ахуйн нэгж шинээр байгуулагдан үйл ажиллагаа явуулж байна.	100
	3.3.1.6	Мал сүргийн чанар, үүлдэр угсааг сайжруулахад "Завхан цөм сүргийн салбар"-тай хамтран ажиллана	2021-2024	ХХААГ,СЗДТГ	10	2	3	Завхан аймгийн цөм сүргийн салбар нь Эрдэнэхайрхан, Цагаанхайрхан сумд байгаа сартуул үүлдрийн 1680 хонь, завхан буурал үүлдрийн 120 ямаанд үзлэг ангилалтыг хийж гүйцэтгэсэн байна. Баталгаажсан үүлдрийн малд үзлэг ангилалт хийж ажлыг хийж Эрдэнэхайрхан, Яруу сумын 27 өрхийн Сартуул үүлдрийн хонь 3,2 мянга, Дөрвөлжин сумын 13 өрхийн Завхан буурал үүлдрийн ямаа 4,0 мянга, Тэс, Баянтэс сумын 14 өрхийн Тэс үүлдрийн адуу 0,5 мянга, Их-Уул,Тосонцэнгэл, Идэр сумын 86 өрхийн сарлаг 2,8 мянга нийт 9 сумын 140 малчин өрхийн 10,6 мянган мал хамрагдсан байна. Ангилалтын үеэр цөм сүргийн завхан салбар, Сартуул үржүүлэг, технологийн нэгж 350 хуц хурга шинээр сонгон тавьсан. Цөм сүргийн салбар 310 хуц, 20 ухна, мал үржүүлэг технологийн нэгжүүд 200 хуц, 80 ухна малын чанарыг сайжруулахаар зах зээлд борлуулах, түрээсээр ашиглуулж малын удмын санг баяжуулах, малын чанар ашиг шимийг сайжруулж байна.	100
	3.3.1.7	Мал сүргийг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамрагдалтыг нэмэгдүүлнэ	2021-2024	ХХААГ,СЗДТГ	10	23%	30%	Мал сүргийг Халдварт, паразиттах өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах аймгийн засаг даргын 2021 оны 05 сарын 03-ны өдрийн А/182 тоот захирамж, Бруцеллээ өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах 2021 оны 08 сарын 10-ны өдрийн А/295 тоот захирамж гаргуулан сумдад хүргүүлэн вакцинуулалтын ажлыг зохион байгуулан ажиллалаа. Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 1249,8 мянган мал вакцинуулалтад хамруулахаас 1249,0 мянган мал хамрагдсан. Мөн бруцеллээ өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 945,0 мянган мал хамрагдахаас 937,8 мянган мал хамрагдсан.	100
Бэлчээр ашиглалтыг сайжруулан, малын тэжээл тариалалтыг нэмэгдүүлнэ	3.3.2.1	Атаршсан тариалангийн талбайг эргэлтэд оруулж, малын тэжээл тариалалтыг нэмэгдүүлнэ	2021-2024	ХХААГ,СЗДТГ	100	1525	1700	Энэ онд аймгийн хэмжээнд 2100 га-д малын тэжээл тариалж 4830 тн ногоон тэжээл хураан авах зорилт тавин ажиллаа. 2021 онд малын тэжээл 4940,6 га-д тариалалт хийж тэжээлд шилжиж ирсэн 451,8 га нийт 5392,4 га-гаас 12608,9 тн ногоон тэжээл хураан авсан байна.	100
	3.3.2.3	Усны хайгуул судалгааг хийж, уст цэгийн тоог нэмэгдүүлнэ	2021-2024	ХХААГ,СЗДТГ	50	538	545	24 сумаас худгийн судалгааг 2021 оны 1,5 дугаар сард 2 удаа авсан. Сумдаас авсан судалгаагаар 30 гаруй худаг шинээр гаргуулах санал ирүүлснийг эрэмбэлж, аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-т хүргүүлсэн. Аймгийн 2021 оны Хөгжлийн төлөвлөгөөнд 100 сая төгрөгөөр бэлчээрийн 5 худаг говийн сумдад гаргахаар төлөвлөгдөж, тендер зарлагдсан боловч одоогоор гүйцэтгэгч тодроогүй тул инженерийн хийцтэй 3 худаг гаргуулахаар Тэсийн бүрд ХХК-тай гэрээ хийж Яруу сумын Цэцэн-Улаан багийн Улаанбэлчир хэмээх газарт инженерийн хийцтэй худаг ашиглалтанд орж 2021 оны 11 сарын 01-ний өдөр аймгийн комисс хүлээн авсан бол Эрдэнэхайрхан сумын Алтан багийн Их-Дэвсгэр, Завханмандал сумын Олонтөрүү багийн Улаантолгой зэрэг газруудад шинээр гаргасан инженерийн хийцтэй худгийг аймгийн комисс хүлээн авсан.	100
	3.3.2.6	Малын тэжээл болон хүнсний ногоо тариалагчдын техник дундын төв байгуулна	2021-2024	ХХААГ,СЗДТГ		0		Баянтэс суманд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төмс, хүнсний ногооны техникийн иж бүрдэл нийлүүлэх төслийн саналыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны хөрөнгө оруулалтын жагсаалтад оруулахаар хүргүүлсэн.	30
	3.3.2.7	Бэлчээр ашиглагчдын хэсгийн үйл ажиллагааг эрчимжүүлж, "Малчдын дундын сан"-г байгуулна	2021-2024	ХХААГ,СЗДТГ	10	183	195	Тосонцэнгэл 19, Завханмандал 4, Баянтэс 15, Цэцэн-Уул 3, Шилүүстэй 11, Цагаанхайрхан 10, Асгат 4, Тэлмэн 13, Их-Уул 32, Идэр 9, Түдэвтэй 12, Сантмаргаз 5, Тэс 5, Ургамал 4 буюу нийт сумд бэлчээр ашиглагчдын холбоотой. Бэлчээр ашиглагчдын холбоо нь хадгаламж зээлийн хоршоо чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна. Сум бүр бэлчээрийн менежментийн төлөвлөгөөтэй болох зорилт тавин боловсруулж, бэлчээрийн менежментийн төлөвлөгөөний загварыг хүргүүлж хяналт тавил ажиллаж байна.	100

Малчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлнэ	3.3.4.1	Малчдын залуу үеийг бэлдэнэ	2021-2024	ХХААГ,АЗДТГ	10	50	100	Малжуулах төслийн хуваарийг хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөлөөр орж батлагдсанаар 24 малчин 120 сая төгрөгөөр малжуулах төсөлд хамруулахаар төсөвлөсөн төслийн материалыг хүлээж аваад шаардлага хангасан сумын малчидтай гэрээ хэлэлцээр хийж 24 өрхийг малын тоо толгойноос нь хамаарч 4-5 сая төгрөгөөр малжуулсан. Аймгийн Политехник коллежийн Малчны ангид Улиастай, Тэс, Эрдэнэхайрхан, Цагаанхайрхан, Шилүүстэй, Идэр, Сантмаргаз, Тэлмэн, Алдархаан, Отгон, Баянхайрхан, Ургамал гэсэн 12 сумаас болон Ховд аймгаас 15-18 насны эрэгтэй -16, эмэгтэй -5 нийт 21 суралцагч суралцаж байна.	100
	3.3.4.2	Хүн амын усан хангамжийг нэмэгдүүлнэ	2021-2024	ХХААГ,АЗДТГ	10	538	5	Аймгийн хэмжээнд хүн амын усны хэрэгцээг хангах байнгын цэвэр усны 182 гүнийн худаг байна. Энэ онд бэлчээрийн 3 шинэ худаг гаргуулахаар Тэсийн бүрд ХХК-тай гэрээ байгуулан Яруу суманд инженерийн хийцтэй гүнийн өрөмдлөгтэй шинэ худгийг хүлээн авсан байна.	100
	3.3.4.3	Малчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулан, эрүүл дадал хэвшил төлөвшүүлнэ	2021-2024	ХХААГ,АЗДТГ	20	4000	5000	Сумын ХААТ-ын мэргэжилтнүүдээр дамжуулж коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх заавар зөвлөмж хүргүүлэн ажиллаж байна. Мөн вакцинуудын арга хэмжээг тухайн отор нүүдлээр яваа газраа харьяалал харгалзахгүйгээр хамруулж байна.	100
	3.3.4.4	Малчид өвөлжөөндөө орон сууцтай болоход дэмжлэг үзүүлнэ	2021-2024	ХХААГ,АЗДТГ	50	50	50	Тосонцэнгэл, Сонгино, Тэлмэн, Асгат, Их-Уул, Түдэвтэй сумын малчид өвөлжөөндөө орон сууцтай байна. Энэ онд Түдэвтэй, Нөмрөг суманд нийт 3 өрх өвөлжөөндөө орон сууц барьсан.	100
	3.3.4.5	Малчид, малчдын бүлэг, хоршооны сайн туршлагыг түгээн дэлгэрүүлж, алдаршуулна	2021-2024	ХХААГ,АЗДТГ	20	120	200	Аймгийн хэмжээнд 2020 оны байдлаар нийт 421 хоршоо бүртгэлтэй байгаагаас 108 хоршоо Улиастай суманд, 313 хоршоо бусад суманд үйл ажиллагаа явуулж байна. Хоршоо манай аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа нийт аж ахуйн нэгжийн 30.9 хувийг эзэлж байна. Алдархаан суманд 2021 оны 10 сарын 16-ний өдөр малчдын зөвлөгөөн зохион байгуулагдаж 30 малчдад өвөлжилтийн бэлтгэл ажлын талаарх болон ХАА-н талаарх мэдээллийг бэлтгэн хүргэсэн. Хоршооны сайн туршлагыг алдаршуулах үйл ажиллагаа цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан хойшлогдоод байна.	70
Газар тариалангийн үйлдвэрлэлийг дэмжиж, борлуулалтын сүлжээг өргөжүүлнэ	3.3.5.1	Төмс, хүнсний ногоо, жимс жимсгэний тариалалт, хадгалалт, борлуулалтыг дэмжинэ	2021-2024	ХХААГ,АЗДТГ	20	36.5%	40%	Аймгийн хэмжээнд төмс 211.2 га, хүнсний ногоо 156.9 га-д тариалалт хийж төмс 2122.7 тн, хүнсний ногоо 1594.8 тн-ыг хураан авсан. Аймгийн хүн амын хэрэгцээт төмсний 69.6 хувь, хүнсний ногооны 36.6 хувийг орон нутгийн үйлдвэрлэлээр хангаж байна.	90
	3.3.5.3	"Завханы улаан хальст саримс"-ийг брэндийн түвшинд хөгжүүлнэ	2021-2024	ХХААГ,АЗДТГ	5	23.2	25	"Завханы улаан хальст саримс" дэд хөтөлбөрийн хүрээнд Улиастай сумын 46 иргэнд саримсны үр үржүүлэх гэрээ байгуулан нийт 180.1 кг үрийг олгосон. 2021 оны байдлаар 100 гаруй аж ахуйн нэгж, иргэд 13.8 га-д тариалалт хийж 36.7 тн саримс хураан авсан нь тариалсан талбай 5.5 дахин хураан авсан ургац 9.9 дахин нэмэгдсэн байна.	100
Төв суурин газрын хүн амыг түшиглэн хүлэмжийн аж ахуйг хөгжүүлнэ	3.3.6.1	Төв суурин газрын хүн амыг түшиглэн хүлэмжийн аж ахуйг хөгжүүлнэ	2021-2023	ХХААГ,АЗДТГ	20	1800	2000	Хамгаалагдсан хөрсний аж ахуйг дэмжих зорилгоор Хөдөө аж ахуйг дэмжих сангаас 2.1 сая төгрөгийн 20х6 хүлэмжийн 10 ширхэг нийлэг хальсан хулага гэрээ байгуулан авч Улиастай, Тэлмэн, Тосонцэнгэл сумын хүлэмжийн тариалан эрхэлж байгаа 13 өрхөд нийлүүлсэнээр 1200 м2 хүлэмжинд тариалалт хийх боломжтой болсон. Мөн Улиастай суманд 120 м2 хүлэмж 1 ширхэг шинээр ашиглалтад орсон.	100
Тариаланчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, залуу тариаланч бэлтгэхэд дэмжлэг үзүүлнэ	3.3.7.1	Тариаланчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, залуу тариаланч бэлтгэхэд дэмжлэг үзүүлнэ	2021-2024	ХХААГ,АЗДТГ	0	150	120	Хаврын тариалантын бэлтгэл ажил, тариалантын ажил эхлэхтэй холбоотой 727 тариаланчийн нэрсийг гаргаж аймгийн ОК-ын Шуурхай штаб, Эрүүл мэндийн газарт хүргүүлж вакцинд хамруулсан. Өрхийн тариалан эрхлэгч нарт хүнсний ногооны үрийг 80 хувийн хөнгөлөлттэй үнээр 155 өрхөд ХААТасгаар дамжуулан нийлүүлсэн. "Завханы улаан хальст саримс" дэд хөтөлбөрийн хүрээнд Улиастай сумын 46 өрхөд үрийн саримсыг гэрээ байгуулан олгосон. Нийт 201 өрхийн тариаланчдад хүнсний ногооны үрийг нийлүүлсэн.	90
3.3 ДУГААР ЗОРИЛТЫН ДҮН									88.42
3.4 Байгальд ээлтэй аялал жуулчлалыг хөгжүүлж, эдийн засаг, нийгмийн үр өгөөжийг нэмэгдүүлнэ									
Аймгийн аялал жуулчлалын гол, туслах маршрутдад түшиглэн үйлчилгээ, мэлээпийн	3.4.1.2	Аялал жуулчлалын гол, туслах маршрутдад дагуу эко ариун цэврийн байгууламж бий болгоно	2021-2024	БОАЖГ,СЗДТГ	50	0	2	Их-Уул, Эрдэнэхайрхан сумдад 2.4 метрийн харьцаатай 2 ариун цэврийн байгууламжийг Баян ангирт нуур ХХК гүйцэтгэж, хүлээлгэн өгсөн. БХНСАХЗардлаас 10 сая төг.	100

Төвүүдийг байгуулахад дэмжлэг үзүүлнэ.	3.4.1.3	Амрах, үдлэх цэгүүд байгуулна	2021-2024	БОАЖГ,СЗДТГ	50	0	2	Отгонтэнгэр уулын өвөр хэсэгт аялалын гол маршрутын дагуу түр буудаллах цэгийн тохижилтыг Амь Ус Трейд ХХК гэрээгээр гүйцэтгэн, хүлээлгэн өгсөн. Мөн Тосонцэнгэл, Их-Уул сумын авто зам дагуу түр буудаллах цэгийн байршлыг тогтоож аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн хурлаар батлуулан, холбогдох дээд шатны байгууллагад хүрүүлсэн.	100
Завхан аймагт аялал жуулчлалыг хөгжүүлэх маркетингийн арга хэмжээг хэрэгжүүлнэ	3.4.3.1	"Zavkhan.travel" сайт, аппликэйшн, видео контент, танилцуулгыг олон нийтэд сурталчлан, хэрэглээг нэмэгдүүлнэ	2021-2024	БОАЖГ,СЗДТГ	10	250	1500	Zavkhan.travel сайтыг шинэчлэх ажил хийгдэж байна.	70
	3.4.3.2	Аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчилна	2021-2024	БОАЖГ,СЗДТГ	15	30%	40%	БОАЖЯ, Ihotel.mn хамтран ХЯМД АМАР аяныг зохион байгуулж аймгийг төлөөлөн Б.Эрдэнэцэцэг (СТА, жүжигчин), Б.Цэнддоо (Сэтгүүлч, зохиолч) нарыг оролцуулан аймгийн үзэсгэлэнт газрууд, аяллын бүтээгдэхүүнүүдийг сурталчлан богино хэмжээний нэвтрүүлэг бэлтгэсэн. Бичлэгийг iHotel.mn хуудаснаас нийт 4,8 мянган иргэн үзэв. Мөн AIR1 Орон нутгийн телевизтэй гэрээ байгуулан 9 гайхамшиг болон аялал жуулчлалын талаарх мэдээ мэдээллийг иргэдэд хүргэсэн.	100
	3.4.3.3	Аялал жуулчлалын салбарын хүний нөөцийг чадавхжуулна	2021-2024	БОАЖГ,СЗДТГ	10	4	4	Их-Уул, Тосонцэнгэл Тэлмэн, Нөмрөг, Түдэвтэй, Сонгино, Сантмаргаз, Баянхайрхан Цэцэн-Уул, Тэс, Баянтэс сумдад 8-9 дүгээр саруудад Хөтөн ном, Видео танилцуулга, Маршрутад орсон газруудыг танилцуулсан.	100
3.4 ДҮГЭЭР ЗОРИЛТЫН ДҮН									94
Эрчим хүчний найдвартай, аюулгүй тогтвортой байдлыг хангана									
Эрчим хүчний хангамжийг нэмэгдүүлнэ	3.5								
	3.5.1.2	21-р зуун хорооллын инженерийн дэд бүтцийг бий болгоно.	2021-2024	ГХБХБГ,АЗДТГ	500	1.8	1	2021 онд цэвэр бохир, халаалт, ЦДАШ, сүлжээ, дэд станцын ажил үргэлжлэн хийгдэж байна. Он дамнан баригдах тул ашиглалтанд орох хугацаа болоогүй.	70
	3.5.1.5	Сэргээгдэх эрчим хүчний ашиглалтыг нэмэгдүүлнэ.	2021-2024	ГХБХБГ,АУЭХС	100	0	100	2021 онд ЭХЯ-тай хамтарч Алдархаан, Тэлмэн сумдад 5 МВт-ын нарны станц байгуулах саналыг хүргүүлснээр ТЭЗҮ, зураг төсвийн судалгаа хийгдэж Алдархаан сумд 5 Мвт-н нарны станцын угсралтын ажил хийгдэж байна.	70
Аймаг, сумын төвийн нэгдсэн халаалтад холбогдсон өрхийн тоог нэмэгдүүлнэ	3.5.2.1	Сумдыг төвлөрсөн халаалтад холбоно	2021-2023	ААН,АЗДТГ	1100	18	20	2021 онд Цагаанхайрхан, Шилүүстэй, Баянхайрхан, Яруу сумдын төвлөрсөн халаалт цэвэр усны шугам сүлжээний угсралтын ажил эхэлсэн хийгдэж байна.	90
3.5 ДУГААР ЗОРИЛТЫН ДҮН									76.67
Улсын болон орон нутгийн авто замын сүлжээг өргөжүүлнэ									
Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх зам, барилгын ажлуудыг хийж гүйцэтгэнэ	3.6								
	3.6.1.1	Нөмрөг сумыг "Арц суурь" хилийн боомттой холбох 199 км хатуу хучилттай авто замын ТЭЗҮ, зураг төслийг боловсруулна.	2021-2024	ЗТХЯ,АЗДТГ	500	0		Нөмрөг-Арц суурийн хилийн боомт хүртэлх 167 км хатуу хучилттай автозамын ТЭЗҮ-ийг боловсруулах ажлын тендерийг Зам, тээврийн хөгжлийн яаманд зарласан, гүйцэтгэгчээр Аварга зам ХХК шалгарч зураг төсвийн ажил хийгдэж байна.	70
	3.6.1.7	Шаардлагатай газруудад сайжруулсан шороон зам, гүүр, хатуу хучилттай замын арчлалт засварыг хийж, шинээр барина	2021-2024	ЗТХЯ,АЗДТГ	200		10	Орон нутгийн замын сангаас Идэр сумын Цагааннуурын гүүрийн засварт 8,0 сая, Түдэвтэй сумын Жарантайн гүүрийн засварт 5,0 сая, Улиастай сумын зам засварт 20,0 сая, Яруу сумын Нарийн давааны замын засварт 5,0 сая, Тэс сумын замын засварт 10 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус олгож зам засварын ажлыг хийлгэсэн.	70
Нийтийн тээврийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна	3.6.2.1	Нийтийн тээврийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна	2021-2024	АЗДТГ,ЗТХЯ	100	3	5	Хот хоорондын нийтийн зорчигч тээвэрлэлтийн үйлчилгээнд "Жавхлант хийморь", "Гранд автобус" ХХК, "Жигд эргэлт"ХХК, "Хараацайн жигүүр"ХХК- ны том оврын автобусууд үйлчилдэг бөгөөд замнал зураглалын дагуух сумдын зорчигчид үйлчлүүлэхдээ цахимаар бичүүлэх, зорчих тасалбар авч үйлчлүүлж байна. Бусад сумдын зорчигчид шуудан үйлчилгээний автомашин болон хувийн тээврийн хэрэгслээр зорчиж байна. 2021 оны 11 дүгээр сараас Улиастай суманд өмнө нь явж байсан дунд оврын 2 ногоон автобус үйлчилгээнд явж байна.	100
3.6 ДУГААР ЗОРИЛТЫН ДҮН									80
Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын нэгдмэл удирдлагыг хэрэгжүүлж, иргэдийн орон сууцны хангамжийг нэмэгдүүлнэ									
	3.7								

Сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөг боловсруулж, хамрах хүрээг нэмэгдүүлнэ	3.7.1.2	Сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг веб хувилбарт оруулан, иргэдэд нээлттэй байдлаар зохион байгуулна	2021-2024	ГХБХБГ,СЗДТГ	5	3	10	24 сумын 2021 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөг газар зохион байгуулалтын цахим системээр дамжуулан хэрэгжилтийг ханган хяналт тавьж, www.egazar.gov.mn болон "Е газар" гар утасны аппликейшнээр дамжуулан иргэд олон нийтэд нээлттэй сурталчлан, 2022 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд санал авах ажлыг цахимаар зохион байгуулан ажилласан. Мөн "Цахим шилжилт" аяны хүрээнд 24 сум, Төрийн болон ТББ-дад сургалт мэдээлэл хийж, Нээлттэй хаалганы өдөрлөгийг зохион байгуулсан. 2021 оны 11 дүгээр сарын 10-ны байдлаар 1300 иргэнд үйлчилж, ГЗБТ-ний хэрэгжилт 26 хувьтай хэрэгжсэн. Төлөвлөгөөний биелэлтийг хангуулж ажиллахыг газрын даамлуудад 10 хоногийн хугацаатай үүрэг өгч жилийн эцэст 100 хувьд хүргэхээр ажиллаж байна.	90
Газар, үл хөдлөх хөрөнгийн нэгдсэн бүртгэл, үнэлгээ, төлбөр, татварыг биржийн системээр хөгжүүлнэ	3.7.2.1	Аймгийн хэмжээнд газрын биржийг хэрэглээнд нэвтрүүлнэ	2021-2024	ГХБХБГ,СЗДТГ	0	760	1140	Газрын цахим биржийг хэрэглээнд нэвтрүүлснээс хойш нийт 179 дуудлага худалдаа, 9 төсөл сонгон шалгаруулалт, 1297 зах зээлийн үнийн мэдээг цахим биржид байршуулсан байна. Сумын Засаг дарга, Газрын даамалд 2 удаагийн албан чиглэл хүргүүлж, нийт 16 сумын 108 байршилд 183,67 га газрын дуудлага худалдаа, 2 сумын 5 байршилд 32.1 га газрыг төсөл сонгон шалгаруулалт зохион байгуулж, 10 дуудлага худалдаа цуцлагдаж, 21 нэгж талбарт дахин дуудлага худалдаа зарлан, төсөвт 82.6 сая төгрөг төвлөрүүлээд байна. Үүнээс 70 нэгж талбарыг цахим хэлбэрээр, 38 нэгж талбарыг танхимын хэлбэрээр зохион байгуулж аймгийн хэмжээнд газрын биржийг бүрэн хэрэглээнд нэвтрүүлсэн. 2021 оны турш нийт 321 иргэн, аж ахуйн нэгж дуудлага худалдаанд оролцсон байна. □	100
Төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх барилга, байгууламж, засвар, их засварын ажлыг эрэмбэлж үе шаттайгаар шийдвэрлэнэ	3.7.3.1	Төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх барилга, байгууламж, засвар, их засварын ажлыг эрэмбэлж үе шаттайгаар шийдвэрлэнэ	2021-2024	ГХБХБГ,СЗДТГ				2021 онд улсын төсвийн хөрөнгөөр Шилүүстэй сумын сургуулийн засвар, Алдархаан сумын 80 хүүхдийн дотуур байрны засвар, ОНХС-ийн хөрөнгөөр Асгат сумын цэцэрлэгийн барилгын засвар, Их-Уул сумын 75 хүүхдийн дотуур байрны барилгын засвар, Их-Уул сумын цэцэрлэгийн барилгын засвар, урлаг заалны барилга, Шинээр Насан туршын боловсролын төвийн барилга, Улиастай сумын 9-р цэцэрлэг, Жавхлантай цогцолбор сургуулийн дотуур байрны барилга угсралтын ажлыг эхлүүлсэн. Мөн Улсын төсөв болон БХБСайдийн багцад хөрөнгийн асуудал шийдвэрлэгдэж Улиастай сумын багуудын цэвэр бохир усны шугамын ажил, Товчоог багийн нэгдсэн бохир усны шугамын ажлын зургийг Некст стейп инженеринг ХХК, Товчоог багийг цэвэр усны шугам сүлжээнд холбох, Өлзийт багийн үйлдвэрийн районы цэвэр бохир усны шугамын зургийн ажлыг Дөрвөн гүн ХХК, Улиастай сумын төв цэвэрлэх байгууламжаас БУНС хүртэлх 2 км ариутгах татуургын шугамын шинэчлэлийн зураг төсвийн ажлыг Инж байгууламж ХХК, Улиастай сумын дулааны станцын цэвэр усны шугамын ажил, Богдын гол багийн 1.5 км үерийн далангийн ажлын зураг төсвийг Их мянган инженерчлэл ХХК, Жаргалант, Чигэстэй багийн 5км үерийн далангийн ажлын зураг төсвийг Гидросооружение ХХК гүйцэтгэж байна. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар Баянхайрхан сумын 15 ортой эрүүл мэндийн төвийн барилга, Түдэвтэй сумын 100 хүүхдийн цэцэрлэгийн барилгын зураг төслийг Алтай газрын хүч ХХК, Улиастай сумын Политехник коллежийн дотуур байрны зураг төслийг Өлзий-Иш ХХК тус тус гүйцэтгэж байна. Зураг төсөв хийх санхүүжилт бага батлагдаж байгаагаас хөрөнгө оруулалтын ажлуудын зураг төсвийн ажил бүрэн хийгдэхгүй байна.	70
3.7 ДУГААР ЗОРИЛТЫН ДҮН									86.67
ГУРАВДУГААД БҮЛГИЙН ДҮН									85.01
ДӨРӨВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО									
	4.1	Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны давхардлыг арилгах, төрийн чиг үүргийн уялдааг хангах замаар бүтэц зохион байгуулалтыг оновчтой болгоно.							
Ухаалаг системд суурилсан төрийн үйлчилгээг иргэдэд хүргэнэ	4.1.1.1	е-mongolia цахим хэрэглэгдэхүүнийг иргэдэд сурталчилж, хэрэглээг нэмэгдүүлнэ	2021-2024	АЗДТГ,СЗДТГ	5.0	15%	30%	Төрийн үйлчилгээний "E-Mongolia" нэгдсэн системийн болон гар утсанд зориулсан аппликейшныг ашиглах АЗ танилцуулга 700, А5 танилцуулга 2500-г 24 сумдад тараан, үйлчилгээг сурталчлан ажиллаж байна.	70
	4.1.1.2	Төрийн архивын цаасан баримтыг тоон хэлбэрт шилжүүлэх ажиллагааг эрчимжүүлнэ.	2021-2024	АЗДТГ,СЗДТГ	5.0	215 хөмрөг, 226 данс	235 хөмрөг 626 данс	Төрийн архивын захирамжлалын баримт бичгийн 235 хөмрөг үүсгэгч байгууллагын нийт-570 данс, 707 хадгаламжийн нэгжийн 29436 хуудас баримтыг сканнердаж, photoshop программд засварлан 35189 хүний нэр цахим хэлбэрт оруулж PDF холболт хийж цахимжууллаа.	90
Төрийн албан хаагчдыг цахим хэрэглэгдэхүүн ашиглан сургана	4.1.2.1	Төрийн байгууллагын дотоод үйл ажиллагаанд удирдлагын системийг нэвтрүүлнэ.	2021-2024	АЗДТГ,СЗДТГ	10.0	5	8	Аймгийн Засаг даргын Тамгын газарт 100 хувь нэвтрүүлсэн. Цаашид сумдад нэвтрүүлэх хүсэлтийг Харилцаа, холбоо мэдээллийн технологийн газарт хүргүүлсэн байгаа. Төрийн байгууллагын албан бичиг солилцооны цахим систем www.docs.gov.mn-ийг нэвтрүүлэх бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.	50

Төрийн үйлчилгээнд чанарын стандартыг нэвтрүүлж, иргэд, олон нийт хяналт тавих нөхцөл бүрдүүлнэ.	4.1.3.1	Чанарын удирдлагын нэгдсэн тогтолцоог нэвтрүүлсэн төрийн байгууллагыг нэмэгдүүлж, иргэдийн оролцоотой хяналт, үнэлгээг бэхжүүлнэ	2021-2024	АЗДТГ,СЗДТГ	100.0	1	2	Чанарын удирдлагын нэгдсэн тогтолцоог нэвтрүүлэх талаарх судалгаа хийгдэж, танилцуулагдсан боловч аймгийн хөгжүүлэх жилийн төлөвлөгөөнд хөрөнгө тусгагдаагүй. СХС, ЖДҮЖС, ХЭДС-ийн хэрэгжилтэд нээлттэй сонголт зохион байгуулсан. Жендерийн дэд хөтөлбөрийн хэрэгжилт болон аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээнд хяналт үнэлгээг ИНБ-удаар гүйцэтгүүлж байна.	30
4.1 ДҮГЭЭР ЗОРИЛТЫН ДҮН									60
4.2		Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны давхардлыг арилгах, төрийн чиг үүргийн уялдааг хангах замаар бүтэц зохион байгуулалтыг оновчтой болгоно.							
Иргэдээ сонсдог, иргэдийн санал бодолд тулгуурлан шийдвэр гаргадаг тогтолцоог бэхжүүлнэ.	4.2.1.1	Иргэдийн санал бодлыг сонсох цахим хэрэглэгдэхүүнийг бий болгоно.	2021-2024	АЗДТГ,СЗДТГ	85.0	0	1	Иргэдийн санал, хүсэлтийг аймгийн Засаг даргын Тамгын газрын 70461212 дугаарын утсаар хүлээн авахаас гадна аймгийн Засаг даргын Тамгын газрын цахим хуудсаар дамжуулан санал, хүсэлтийг хүлээн авч байна. 2021 онд нийт 612 иргэдийн санал хүсэлтийг хүлээн авч, 51 иргэний гомдлыг шийдвэрлэн 561 иргэнд хуулийн хугацаанд хариу өгсөн. □	100
Төр, иргэний нийгмийн байгууллага, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг өргөжүүлнэ.	4.2.2.1	Төрийн зарим чиг үүргийг иргэний нийгмийн байгууллагуудаар гүйцэтгүүлнэ.	2021-2024	АЗДТГ,СЗДТГ		10	23	Гэр бүлийн хүчирхийлэлтэй "Нэг цэгийн үйлчилгээний төв"-ийн үйл ажиллагаанд жендэрт суурилсан хүчирхийллээс сэргийлэхэд аймгийн Засаг даргын Захирамжаар 10.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон. Мөн жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөрт оролцооны хяналт шинжилгээ үнэлгээ хийлгэж байна. Хэрэгжилтийн хүрээнд 1.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлсэн. Мөн аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ажилд ИНБ-р хяналт хийгдэж байна. 2021 оны 12 дугаар сард багтаан тайлан, зөвлөмжийг хүргүүлэхээр ажиллаж байна.	50
Төрийн албаны мэргэшсэн тогтвортой байдлыг хангаж, нийгмийн асуудлыг шийдвэрлэнэ	4.2.3.1	Төрийн албаны мэргэшсэн тогтвортой байдлыг хангаж, нийгмийн асуудлыг шийдвэрлэнэ.	2021-2024	АЗДТГ,Төрийн байгууллагууд	80.0	45.0	50	Төрийн албан хаагчдыг сургаж дадлагуулах, мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрийн дагуу 2021 оны төлөвлөгөөг боловсруулж батлуулсан. 2021 онд Удирдлагын академийн сургалтын төлөвлөгөөний дагуу улсын төсвийн санхүүжилтээр эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 3, ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 5, дунд хугацааны давтан сургалтад 28, төрийн албанд анх томилогдсон албан хаагчийг мэргэшүүлэх анхан шатны сургалтад 26, богино хугацааны сургалтад 30, нийт 92 албан хаагч цахим хэлбэрээр хамрагдаж мэдлэг боловсролоо дээшлүүлээ. Мөн төрийн байгууллагуудын 2021 оны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу цахим сургалтыг салбар бүрээр зохион байгуулж, давхардсан тоогоор 2000 гаруй албан хаагч хамрагдсан байна. Түүнчлэн Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулж буй 7 хоног бүрийн "Пүрэв" гарагийн сургалтад хэлтэс, агентлагийн дарга нар болон аймаг, сумдын ЗДТГ-ын дарга мэргэжилтнүүдийг хамруулан энэ ажил тогтмолжсон.Төрийн албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлын хүрээнд төрийн байгууллагуудад шаардлагатай байгаа тоног төхөөрөмжийн болон сургалтын хэрэгцээний саналыг авч нэгтгэн УИХ-ын Б.Баярсайханд уламжилсан. Түүнчлэн төрийн байгууллагуудын дарга, эрхлэгч, төсвийн шууд захирагч нарт төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн асуудлыг сайжруулах талаар хөдөлмөрийн дотоод журманд тусгаж, хөтөлбөр төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх үүрэг чиглэлийг өгсөн. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсаны дагуу төрийн байгууллагуудын дунд "Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа"-г сайжруулах чиглэлээр болзолт уралдаан зарлаж, үр дүнг тооцон ажиллаж байна.	100
Төрийн албан хаагчийн хүний нөөцийг бэлтгэж, чадавжуулна	4.2.4.1	Төрийн албаны бүх томилоонд улс төрийн нөлөөллийг хязгаарлана	2021-2024	АЗДТГ, ТАЗСЗ,СЗДТГ	5.0	85%	87%	Төрийн албаны тухай хуулийн дагуу Төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх, чадавжуулах, ёс зүй, сахилга хариуцлагатай төрийн албыг бүрдүүлэх бодлого баримтлан ажиллаж байна. Нутгийн захиргааны байгууллагуудад сул орон тоо гарсан тухай бүр Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд хууль заасан хугацаанд захиалгаа ирүүлэх, Төрийн албаны тухай хууль тогтоомжийн дагуу шаардлага хангасан иргэдийг томилон ажиллуулах чиглэлийг байгууллагын дарга, удирдлагуудад өгч, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. Нутгийн захиргааны байгууллагуудаас ирүүлсэн төрийн захиргааны удирдахын 10, гүйцэтгэхийн 65, туслахын 12 сул ажлын байрны захиалгыг Төрийн албаны зөвлөлд хүргүүлж, 2021 оны 12 дугаар сард сул орон тоог нөхөх тусгай шалгалтыг зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангаж байна. 2021 онд төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийн сонгон шалгаруулалтыг томилох эрх бүхий албан тушаалтнуудын саналыг үндэслэн 1 удаа зохион байгуулж, 13 ажлын байр нөхөгдсөн. Төрийн албаны зөвлөлөөс томилогдсон ажлын хэсэг 2021 оны 11 дүгээр сард тус аймагт ажиллаж, Төрийн албаны тухай хууль тогтоомж, төрийн албаны шинэтгэлийн бодлогын хэрэгжилт болон аймгийн ИТХ, ЗДТГ, Засаг даргын дэргэдэх газар, хэлтэс, агентлагуудын хүний нөөцийн бодлого, үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийж, төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга хариуцлага сайжруулах чиглэлээр сургалт зохион байгуулан, төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагааны түвшинд үнэлэлт өгөх болон иргэдээс судалгаа авч, аймгийн удирдлагууд, төрийн албанд ажиллаж байсан ахмадуудын төлөөлөлтэй уулзалт зохион байгуулсан. □	100

Төрийн албан хаагчийн сахилга, хариуцлагыг өндөржүүлж, шударга, ёс зүйтэй төрийн албыг төлөвшүүлнэ	4.2.5.1	Төрийн албан хаагчийн сахилга, хариуцлагыг өндөржүүлж, шударга, ёс зүйтэй төрийн албыг төлөвшүүлнэ	2021-2024	АЗДТГ, ТАЗСЗ,СЗДТГ	5.0	68.0	66.0	Монгол Улсын Төрийн албаны тухай хууль тогтоомж болон Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм", төрийн албан хаагчдын сахилга хариуцлагыг өндөржүүлэх чиглэлээр тус аймгийн Засаг даргын Тамгын газар, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлөөс ихээхэн анхаарч, Төрийн албаны зөвлөл болон холбогдох дээд шатны байгууллагуудаас өгсөн үүрэг, чиглэлийг орон нутагт хэрэгжүүлэн ажиллаж байна. 2021 онд Төрийн албан хаагчийн сахилга, хариуцлагыг өндөржүүлж, шударга, ёс зүйтэй төрийн албыг төлөвшүүлэх, ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулах чиглэлээр төрийн байгууллагуудад 2 удаа зөвлөмж хүргүүлсэн. УИХ-ын ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо, Төрийн албаны зөвлөлөөс Канад Улсын Засгийн газрын дэмжлэгтэйгээр НҮБХХ-ийн "Монгол улсад мэргэжлийн иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх нь" төсөлтийг хамтран төрийн байгууллагын дэргэдэх ёс зүйн зөвлөл, хүний нөөцийн ажилтнуудыг чадавжуулах, төрийн албан хаагчдад цогц чадамжийн ойлголтыг бий болгох, ёс зүйн зөрчлөөс сэргийлэх сургалтыг 24 сумын 100 орчим төрийн албан хаагчдыг хамруулан зохион байгуулсан нь орон нутагт анхных бөгөөд чухал үр дүнтэй сургалт боллоо. Түүнчлэн энэхүү сургалтыг Завхан аймагт баруун 5 аймгийн 40 гаруй төрийн албан хаагчдыг хамруулан зохион байгууллаа. Энэхүү сургалтын үр дүнд хамтдаа мэдлэг бүтээх, мэдлэг туршлагаа хуваалцах, сэтгэлгээний өөрчлөлт, танин мэдэхүйн өрөөсгөл хандлагын талаар тодорхой ойлголттой болж, төрийн албан хаагчийн цогц чадамжийн тухай ойлголт, цогц чадамжийг нэвтрүүлснээр бий болох үр нөлөө, ач холбогдлын мэдэж, ёс зүйтэй төрийн бодлогыг хэрэгжүүлэх, шинэ мэдлэгт суралцлаа.	100
Авлигаас ангид аймаг байна	4.2.6.1	Авлигаас ангид аймаг байна.	2021-2024	АЗДТГ	20	81%	83.6%	2021 оны авлигын эсрэг төлөвлөгөөг аймгийн Засаг даргаар батлуулан ажиллаж байна. Авлигын эрсдлээс урьдчилан сэргийлэх, авлигын эсрэг хууль тогтоомж сэдэвт сургалтыг USAID-н санхүүжилтээр хөгжлийн шийдэл төрийн бус байгууллагын хэрэгжүүлж буй best хөтөлбөртэй хамтран зохион байгуулж, нийт 30 албан хаагч хамрагдлаа. Авлигын эсрэг хуулийг сурталчлах ажлын хүрээнд Авилгатай тэмцэх газраас ирүүлсэн видео контентийг аймгийн сайт болон пейж хуудсаар иргэдэд хүргэх мөн 2000 ширхэг постер хэвлэн 24 сумын төрийн байгууллагуудад тарааж, цахим орчинд байршуулсан.	70
"Аз жаргалтай ажлын байр" арга хэмжээг хэрэгжүүлнэ	4.2.7.1	"Аз жаргалтай ажлын байр" арга хэмжээг хэрэгжүүлнэ.	2021-2024	АЗДТГ	50	0%	70.0%	Аймгийн ЗДТГ-ын даргаар ахлуулсан "Аз жаргалтай ажлын байр" арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хэсэг аймгийн Засаг даргын захирамжаар томилогдон ажиллаж байна. Монгол Улсын Үндсэн хуулийн 46 дугаар зүйлийн 46.3, Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар бүлэгт тусгагдсан "Төрийн албан хаагчийн нийтлэг баталгаа" болон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн тухайн жилд дэвшүүлсэн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор төрийн байгууллагуудын дунд "Төрийн албан хаагчийн ажиллах нөхцлийг сайжруулж, нийгмийн баталгааг хангах", ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр шинэлэг ажлыг үр дүнтэй зохион байгуулсан байгууллага, хамт олныг шагнаж урамшуулах болзолт уралдаан зарлаад байна. Болзолт уралдааны үр дүнг 12 дугаар сард дүгнэж, үр дүнг тооцох, жилийн эцсийн ажил дүгнээд нэг шалгуур үзүүлэлт болгох, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх, бүтээлч санал, санаачилгыг дэмжих зорилгоор ажиллаж байна.	100
Хэвлэл мэдээллийн хэрэгслээр орон нутгийн онцлог үйл явдлыг сурталчлан ард иргэдэд түгээнэ	4.2.8.1	Хэвлэл мэдээллийн хэрэгслээр орон нутгийн онцлог үйл явдлыг сурталчилж, ард иргэдэд түгээнэ	2021-2024	АЗДТГ	20	120	150	Завхан аймагт болж буй онцлох үйл явдлын мэдээ мэдээллийг орон нутгийн болон төвийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр ард иргэдэд чанартай, шуурхай, хүртээмжтэй хүргэн ажиллаж байна. 2021 онд орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр 270 гаруй мэдээ мэдээлэл бэлтгэж ажиллалаа. Мөн Монголын Үндэсний Олон Нийтийн Телевизээр 60 гаруй удаагийн мэдээлэл нэвтрүүлж, орон нутагт зохион байгуулж буй онцлох үйл явдлын мэдээ мэдээллийг улс орон даяар үзэгчдэд хүргэлээ.	100
4.2 ДУГААР ЗОРИЛТЫН ДҮН								90.00	
4.3		Иргэдийн аюулгүй, амар тайван байдлыг хангана							
Гэмт хэргийн гаралтыг бууруулж, илрүүлэлтийг нэмэгдүүлнэ	4.3.1.1	Хулгайн гэмт хэргийн гаралтыг бууруулж, илрүүлэлтийг нэмэгдүүлнэ.	2021-2024	АЗДТГ,ЦГ	-	51.4%	55%	Энэ оны 10 сарын байдлаар нийт 150 гэмт хэрэг статистик мэдээгээр тоологдсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 13 хэрэгээр буюу 8.6 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Бүртгэгдэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй 90 гэмт хэрэг бүртгэгдсэнээс 53 гэмт хэргийн сэжигтнийг тогтоож, яллагдагчаар татсанаар гэмт хэргийн илрүүлэлт 58.9 хувьтай тооцогдлоо. Хагас жилийн байдлаар 20 төрлийн гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 4 хэрэгээр буюу 20 хувиар гэмт хэргийн төрөл нь өссөн байна. Нийт гэмт хэргийн дийлэнх хувийг хүний эрүүл мэндэд хохирол учруулах, залилах, мал хулгайлах, хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргүүд эзэлж байх тул дээрх хэргүүдийн шалтгаан нөхцлийг тодорхойлон бууруулах чиглэлээр Мал-мах 2021, Ятгах тусам нягтал, Илрүүлэлт оргодол-2021, Малчин таны төлөө, Байгалиа хамгаалъя, мэдээлэх илрүүлэх, зогсооё зэрэг нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээнүүдийг шат дараалалтай зохион байгуулан ажиллаж байна.	70
	4.3.1.2	Хүүхдийг гэр бүлийн хүчирхийлэл,гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлнэ.	2021-2024	АЗДТГ,ЦГ	0	0	30	Нуугдмал далд хэлбэрт байгаа гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлийг илрүүлэх зорилгоор "Мэдээлэх, Илрүүлэх, Зогсооё" нэг сарын аяныг зохион байгуулсан.	100

	4.3.1.3	Мэдээлэл, удирдлагын системийг боловсронгуй болгож, төв суурин газрыг камержуулна.	2021-2024	АЗДТГ,ЦГ	10.0	61.4	63	Улиастай сумын Чигэстэй багт "Tiandy" брэндийн 4 мв камерыг 10-н цэгт суурилуулах ажлыг 10 сард "Төгс электроникс" ХХК хийж гүйцэтгэсэн. Тосонцэнгэл сумын гудамж талбай, зам дагуу 15 цэгт "Tiandy" брэндийн камер тавих ажлыг "Төгс электроникс" ХХК гүйцэтгэж, 12-р сард багтаан ашиглалтад оруулахаар ажиллаж байна. Улиастай сумын ЗДТГ-аас шөнийн цагаар харах хүчин чадалтай 2 ширхэг "Dahua" брэндийн PTZ камер Жинст, Товцог багт ашиглалтад оруулахаар ажиллаж байна.	90
Зам тээврийн осол, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлж, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангана	4.3.2.1	Улсын чанартай автозамын дагуух хяналтын постуудыг тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангана	2021-2024	АЗДТГ,ЦГ	35.0		3.0	Монгол Улсын Стандартчлал хэмжил зүйгээр баталгаажсан COMLASER-TP CAM H10 маркийн зөөврийн хурд хэмжигч 3 ширхэгийг шийдвэрлүүлснээр улсын чанартай авто зам дагуу хурд хэтрүүлсэн 850 зөрчил илрүүлсэн нь өмнөх оноос 44.7 хувь өссөн, хурд хэтрүүлсэн зам тээврийн осол 37 хувь буурсан.	100
	4.3.2.2	Улсын чанартай авто зам дагуух сумдад олон нийтийн цагдаа ажиллуулахад дэмжлэг үзүүлнэ.	2021-2024	АЗДТГ,ЦГ	10.0		30.0	Их-Уул суманд 2 олон нийтийн цагдааг тус сумын ИТХ-аас баталсан төсвөөр цалинжуулан ажиллуулж байна.	70
	4.3.2.3	Улсын чанартай авто зам болон Улиастай сумын хөдөлгөөнт эргүүлийн автомашиныг үе шаттай шинэчлэхэд дэмжлэг үзүүлнэ	2021-2022	АЗДТГ,ЦГ			25.0	Улсын чанартай авто зам дагуух Их-Уул, Сонгино, Тэлмэн зэрэг сумдад Probox маркийн автомашин, Улиастай сумд Plius маркийн авто машиныг шийдвэрлэснээр зам тээврийн осол, хэргийн дуудлагад түргэн шуурхай очих, улсын чанартай авто замуудад хөдөлгөөнт эргүүлийн үүрэг гүйцэтгэж хяналт шалгалт зохион байгуулж ажилласнаар улсын чанартай авто замд үйлдэгдэх зам тээврийн осол хэрэг 25 хувь буурсан.	100
Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлнэ	4.3.3.1	Хууль зүйн зөвлөгөө, мэдээллийн цахим сан e-khutuch.mn сайтыг өргөжүүлнэ.	2021-2024	АЗДТГ	4.0	0%	2%	Хууль зүйн зөвлөгөө, мэдээллийн цахим сан e-khutuch.mn сайтыг сумдын эрх зүйн хөтөч нараар дамжуулан иргэдэд сурталчлан таниулан ажиллаж байна. Аймгийн Засаг даргын Тамгын газрын нэг цонхны үйлчилгээний төвд эрх зүйн хөтчийн буланг тохижуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.	70
	4.3.3.2	Эрх зүйн хөтчийг бэлтгэнэ.	2021-2024	АЗДТГ	1.0	3	24	Хууль зүйн үндэсний хүрээлэнтэй хамтран 2020 оны 12 сарын 21-нд аймгийн 54 албан хаагчийг эрх зүйн хөтөөр бэлтгэсэн. Коронавируст халдварын нөхцөл байдлаас хамаарч эрх зүйн хөтөч нарын танхимаар зохион байгуулагдах давтан сургалт түр хугацаагаар хойшлогдон хүлээгдэж байна.	70
4.3 ДУГААР ЗОРИЛТЫНЫ ДҮН									83.75
	4.4	Хараат бус шүүх, хүний эрхийг дээдэлсэн эрх зүйн шинэтгэлийг хэрэгжүүлнэ.							
Орон хууль сахиулах байгууллагын чадавхыг бэхжүүлнэ	4.4.1.1	Шүүхийн шинжилгээний албаны гэмт хэргийн илрүүлэлт, нотлох ажиллагаанд орчин үеийн техник, тоног төхөөрөмж ашиглалтыг нэмэгдүүлнэ	2021-2024	АЗДТГ,ШША	9.5	0	2	Дүрс дуу бичлэгийн шинжилгээ хийх, хүний гадаад дүр төрх адилтгах, аман зураг гаргах, программ бүхий өндөр хурдны багтаамжтай цахим системтэй болоход дэмжлэг үзүүлсэн.	100
	4.4.1.2	Архивын баримтын хадгалалт, хамгаалалтын нөхцөлийг сайжруулна	2021-2024	АЗДТГ,Архивын тасаг	2	0	2	Төрийн архивын цаасан болон цахим баримтын хадгалалт хамгаалалтыг сайжруулах, мэдээллийн сангийн аюулгүй байдлыг хангах зорилгоор 2021 онд 15 компьютер 3 ширхэгийг 6.4 сая төгрөг, хэргийн шүүгээ, баримт хамгаалах хайрцаг 200 ширхэгийг 1.7 сая төгрөгөөр тус бүр авч, лицензтэй вирусний программ, галын хор 2 ширхэг, галын хучлага 4 ш мөн хүрээ, жоотуу зэрэг болзошгүй гамшгаас хамгаалах тоног төхөөрөмж авсан.	100
	4.4.1.3	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх төвийн ажилтнуудын нийгмийн баталгааг хангаж, ажиллах орчныг сайжруулна.	2021-2024	АЗДТГ,ШША	40	6	6	Жендерт суурилсан хүчирхийллийн хохирогчид үйлчилгээ үзүүлэх "Нэг цагийн үйлчилгээний төв"-ийн үйл ажиллагаанд 10.0 сая төгрөгийн дэмжлэгийг 2021 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн А/192, 2021 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн А/365 дугаар захирамжаар тус тус олгосон.	100

	4.4.1.4	Хууль зүйн туслалцааны төвөөс төлбөрийн чадваргүй иргэнд өмгөөллийн үйлчилгээг хүртээмжтэй хүргэнэ.	2021-2024	АЗДТГ,ШШГГ	2.5	253	270	2021 онд нийт 84 иргэнд хууль зүйн туслалцаа үзүүлснээс 70 иргэнд хууль зүйн зөвлөгөө, төлбөрийн чадваргүй 14 иргэнд өмгөөллийн үйлчилгээ үзүүлсэн байна.	30
	4.4.1.5	Хилийн боомтын аюулгүй байдал, шалган нэвтрүүлэх үйл ажиллагаанд орчин үеийн техник, технологийг нэвтрүүлж, ажиллах орчин нөхцөлийг сайжруулна.	2021-2024	АЗДТГ,0277 цэргийн анги	5.0	0	2	Хилийн боомтын аюулгүй байдал, шалган нэвтрүүлэх үйл ажиллагаанд орчин үеийн техник, технологийг нэвтрүүлж, ажиллах орчин нөхцөлийг сайжруулах арга хэмжээ Арц суурь хилийн боомт хаасантай холбоотойгоор хүлээгдэж байна.	0
Кибер аюулгүй байдлын хяналтыг сайжруулж, гэмт халдлагаас урьдчилан сэргийлнэ	4.4.2	Кибер аюулгүй байдлын хяналтыг сайжруулж, гэмт халдлагаас урьдчилан сэргийлнэ	2021-2024	ТЕГ-ын харьяа Завхан аймаг дахь хэлтэс	2	90%	92%	Завхан аймаг дахь Салбар зөвлөлийн 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг Терроризмтой тэмцэх ажиллагааг зохицуулах зөвлөлийн даргаар батлуулсан хэрэгжүүлэн ажиллаж байна.	70
4.4 ДҮГЭЭР ЗОРИЛТЫН ДҮН									66.67
	4.5	Гадаад бодлого, харилцаа хамтын ажиллагааг тогтвортой хэрэгжүүлнэ.							
Гадаад, харилцаа хамтын ажиллагааг өргөжүүлнэ	4.5.1	Гадаад, харилцаа хамтын ажиллагааг өргөжүүлнэ	2021-2024	АЗДТГ		2	3	Монгол Улс, Оросын Холбооны улс хоорондын найрамдалт харилцаа тогтоосны 100 жилийн ой тохиож буйтай холбогдуулан Оросын холбооны улсын элчин сайдын 2 дугаар нарийн бичгийн дарга Анна Сергеевна Акулова болон дипломат албан хаагчдыг урьж, Арц суурийн боомттой танилцуулах, найрамдалт харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх ажлыг 12 сард зохион байгуулахаар бэлтгэл ажил хийгдэж байна. Хоёрдугаар нарийн бичгийн даргад урилга болон ажиллах хөтөлбөрийг хүргүүлсэн бөгөөд хугацааг товлохоор хүлээгдэж байна. Л.Банганы нэрэмжит театр нь ЖАНГАР хүүхдийн жүжиг туурвиж, театрын тайзнаас хүүхэд багачуудын оюун санаанд амилуулснаар Оросын холбооны улсын Халимаг улсын Засгийн газартай хамтран цахимаар тус улсын иргэдэд хүргэхээр шийдвэрлэж, 1.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгоод байна.	50
4.5 ДУГААР ЗОРИЛТЫН ДҮН									50
	4.6	Батлан хамгаалах тогтолцоог бэхжүүлж, мэргэжлийн чадварлаг боловсон хүчнийг бэлтгэнэ.							
Орон нутгийн хамгаалалтын бэлэн байдлыг бэхжүүлнэ	4.6.1.1	Өсвөр үе, залуучуудад цэрэг эх оронч хүмүүжил олгож, оюутан цэрэг сургалтад суралцагчдын тоог нэмэгдүүлнэ	2021-2024	АЗДТГ,БСУГ	15.0		1	"Зэвсэгт хүчин 100" гар зургийн уралдаан, "Эрхмийн дээд Монгол эр хүн" эссе бичлэгийн уралдаан, Монгол хүн сансарт ниссэний 40 жилийн ой, Хугацаат цэргийн алба хаагчдын ар гэрт дэмжлэг үзүүлэх, хугацаат цэргийн албан хаагчдын албаны нөхцөл байдалтай танилцах зэрэг арга хэмжээг зохион байгуулан явуулж орон нутгийн "Шинэ Завхан" телевизээр 8 удаагийн 150 минутын нэвтрүүлэг бэлтгэн олон нийтэд сурталчилсан. Мөн Улиастай сумын төвд "Нутгийн генералууд" хүндэтгэлийн талбайг шинэчлэн засварлаж хүүхэд, залуус, иргэдийн чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, эх оронч үзэл хүмүүжлээр төлөвших орчин болгон тохижуулсан.	100
	4.6.1.2	Орон нутгийн хамгаалалтын бэлэн байдлыг бэхжүүлнэ	2021-2024	Аймгийн Цагдаагийн газар,СЗДТГ	30.0		1	2021 онд цэргийн дүйцүүлэх албаны мөнгөн төлбөрийн дансанд төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийн 5%-ийг орон нутгийн хамгаалалтын нөөцийг бүрдүүлэхэд зориулан хуримтлуулахаар шийдвэрлэсэн. Орон нутгийн хамгаалалтын томилоот нэгжийн бүрэлдэхүүнийг оногдуулан данслах, тодотгол хийх ажлыг хэрэгжүүлэн ажиллав.	70
	4.6.1.3	Цэргийн дайчилгааны төлөвлөлтийг хэрэгжүүлэх, дайчилгааны даалгаварт тодотгол хийнэ	2021-2024	АЗДТГ,СЗДТГ	20.0		1	Цэргийн дайчилгааны төлөвлөлтийг шинэчлэх ажлын хүрээнд "Зэвсэгт хүчний нэгтгэл ангийг дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүн, техникээр нөхөн хангах төлөвлөгөө", Цэргийн штабыг "Байлдааны бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх төлөвлөгөө", "Орон нутгийн цэргийг байгуулах төлөвлөгөө"-г шинэчлэн боловсруулж ЗХЖШ-ын даргаар батлуулсан. Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын 2021 оны "Оператив-тактикийн хээрийн сургууль явуулах тухай" мн/115 дугаар тушаалаар батлагдсан "Зэвсэгт хүчнийг дайны байдлын бүтэц, зохион байгуулалтад шилжүүлж, стратегийн операцад бэлтгэх" сэдэвт стратегийн команд-штабын сургуульд амжилттай оролцлоо. Дайчилгааны даалгаврын дагуу Зэвсэгт хүчний 274 дүгээр тусгай салбарт оногдуулан данслагдсан бэлтгэл үүрэгтэн, техникийг дайчлан татаж, сургуульд оролцуулсан.	100
	4.6.1.4	Хил хамгаалах зөвлөлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ	2021-2024	АЗДТГ,ЦГ				Хил хамгаалах туслах хүчний зөвлөлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн Улсын хилийн зурвасыг Хил хамгаалах ерөнхий газартай хамтран шинэчлэн тогтоон мөрдүүлэн ажиллаж байна.	70

4.6 ДУГААР ЗОРИЛТЫН ДҮН								85	
ДӨРӨВДҮГЭЭР БҮЛГИЙН ДҮН								72.57	
ТАВ. НОГООН ХӨГЖИЛ									
Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөжүүлнэ									
5.1									
Онцлог экосистем бүхий газар нутгийг тусгай хамгаалалтанд авна	5.1.1.1	Шаардлагатай газар нутгийг орон нутгийн тусгай хамгаалалтад авна	2021-2024	АСЗДТГ, ГХБХБГ, БОАЖГ, СЗДТГ	1	25.1%	25.7%	Тосонцэнгэл, Их-Уул сумын авто зам дагуу түр буудаллах цэгийн байршлыг тогтоож аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн хурлаар батлуулан, улсын тусгай хэрэгцээнд оруулахаар холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлсэн. Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан улс орон нутгийн тусгай хэрэгцээнд авах газрын төлөвлөлтийн талаар сумдын Засаг нарт мэдээлэл хийсэн.	70
	5.1.1.2	Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгааллын менежментийг сайжруулна	2021-2024	СЗДТГ, БОАЖГ, АЗДТГ, ГХБХБГ, ТХ	2	0	2	Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалтын бус, зурвас газрыг газар зохион байгуулалтын цахим системд оруулах ажил хийгдэж байна. Энэхүү ажил хийгдсэнээр тус хамгаалалттай газрын хориглолт, хязгаарлалтын бүсэд газар олголт хийгдэхгүй болно. Монголын унаган байгалийн хүлээл тогтворжилтыг хангах төсөлтэй хамтран Тосонцэнгэл сумын Дэлгэрэхийн орон нутгийн тусгай хамгаалалттай газрын /146 800 га талбайтай/ хамгаалалтын менежментийг сайжруулах ажлыг Ногоон тэс ТББ-аар гүйцэтгүүлсэн. Тус иргэний нийгмийн байгууллага сумын Засаг даргатай гэрээ байгуулан тусгай хамгаалалттай газрын суурь судалгааны, тэмдэг тэмдэглэгээ хийх, сургалт сурталчилгаа явуулах, биотехникийн арга хэмжээ авах зэрэг ажлуудыг гүйцэтгэсэн.	100
5.1 ДҮГЭЭР ЗОРИЛТЫН ДҮН								85	
5.2	Байгалийн нөөцийг хамгаалж, нөхөн сэргээж, зохистой ашиглалтыг бий болгоно								
Амьтны нөөцийг хамгаална	5.2.1.3	Ховор болон ашиглалтанд өртөмтгий амьтдыг (хойлог, тарвага, хүдэр) үржүүлж, сэлгэн нутагшуулна	2021-2024	БОАЖГ, ТХГНХЗ, Эрдэм шинжилгээний байгууллага	5	1	2	Биологийн сорилын хүрээлэнтэй хамтран Тосонцэнгэл суманд тарвага сэлгэн нутагшуулах ажлыг үргэлжүүлэн зохион байгуулж, ENSURE төсөл, биологийн хүрээлэнтэй хамтран Тосонцэнгэл сумын хожуулын голд нийт 25 монгол тарвага нутагшуулаад байна. Мөн Тарвагатайн нуруунд хүдэр сэргээн нутагшуулах талаар судалгаа, мониторинг хийхээр төлөвлөн ажиллаж байна.	90
	5.2.1.4	Зэрлэг амьтны амьдрах орчныг тэтгэх биотехникийн арга хэмжээ хэрэгжүүлнэ	2021-2024	БОАЖГ, СЗД	5	17	20	Зэрлэг амьтдын амьдрах орчныг тэтгэж Идэр, Түдэвтэй, Сонгино, Алдархаан Цагаанхайрхан, Яруу, Шилүүстэй, Отгон сумдад нийтдээ 28 цэгт 275 боодол өвс, 58 уут хужир буюу 2,9 тн хужир тавьж биотехникийн арга хэмжээ авсан. 12 дугаар сард 20 уут хужир тавихаар нөөцлөөд байна.	100
Ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээг нэмэгдүүлнэ.	5.2.3.1	Ойжуулалт, ойн нөхөн сэргээлт хийнэ	2020-2024	БОАЖГ, СДОА, Ойн мэргэжлийн байгууллага	139	173	373	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр Их-Уул, Тосонцэнгэл суманд 28.4 га, ensure төслийн санхүүжилтээр Их-Уул, Тосонцэнгэл суманд 52 га нийт 80.4 га талбайд ойжуулалтын ажлыг Хавчгийн ногоон мод ХХК, Их-Уул, Тосонцэнгэл сумын нийт 10 ойн нөхөрлөл гүйцэтгэсэн. Идэр суманд 14.4 га талбайд Мөнх Давжих Хангай ХХК нь ойжуулалтын ажил гүйцэтгэхээр гэрээг байгуулсан.	70
	5.2.3.2	Шилмүүст модны тарьц суулгац үржүүлдэг мод үржүүлгийн газрын тоог нэмэгдүүлнэ	2020-2024	БОАЖГ, СДОА		3.5	4.5	Төслийн санхүүжилтээр Их-Уул суманд Нисдэг үр ББН 0.3га, Тосонцэнгэл суманд Агь наран булаг хангай ББН 3 га талбайд мод үржүүлгийн газрын хашаа хамгаалалт, тоног төхөөрөмжийг сайжруулж, аймгийн хэмжээнд нийт шилмүүст модны 2.2 сая тарьц, суулгац тарьж ургуулсан.	100
Ойн сангийн төлөв байдлыг сайжруулна.	5.2.4.1	Байгалийн сэргэн ургалтад тусална	2021-2024	БОАЖГ, СДОА	10	200	250	Тосонцэнгэл, Их-Уул сумдад нийт 280 га талбайд байгалийн сэргэн ургалтад туслах ажлыг ойн мэргэжлийн байгууллага, нөхөрлөлөөр гүйцэтгүүлсэн.	100
	5.2.4.2	Ойн цэвэрлэгээ хийнэ	2021-2024	БОАЖГ, СДОА, ТХГНХЗ		300	450	Тосонцэнгэл сумын ойн санд 150 га талбайд ойн цэвэрлэгээ болон байгалийн сэргэн ургалтад туслах ажлыг Зулзган мод төгөл ХХК нь 50 га-д, Ойн их хишиг ХХК нь 50 га талбайд, Говийн Улиас ХХК 50 га-д тусгаарлалт хийлгэж, гүйцэтгэсэн.	100
	5.2.4.3	Ойн арчилгааны огтлолт хийнэ.	2021-2024	БОАЖГ СДОА	12	380	480	Улсын төсвийн хөрөнгөөр Тосонцэнгэл сумын ойн сангийн 100 га талбайд хийх арчилгааны огтлолтын ажлын гүйцэтгэгчээр Тосонцэнгэл сум дахь сум дундын ойн анги шалгарч гэрээ байгуулсан боловч санхүүжилт олгогдоогүй. Их-Уул сумын ойн санд 4 га, Тосонцэнгэл сумын ойн санд 16 га, нийт 20 га арчилгааны огтлолтыг нөхөрлөлүүд гүйцэтгэсэн.	100
	5.2.4.4	Ойн хөнөөлт шавж, хортонтой тэмцэх ажлыг зохион байгуулна	2021-2024	БОАЖГ, СДОА	30	8000	10,000	Их-Уул сумын ойн сан тархсан хөнөөлт шавжтай тэмцэх ажлыг Цэн эко төгөл ХХК 786 га, Нью грийн форест ХХК 3370 га нийт 4156 га талбайд тэмцлийн ажил гүйцэтгэсэн.	100
Усны нөөцийн	5.2.6.2	Булаг, шандны эхийг хашиж, хамгаална	2021-2024	БОАЖГ	10	94	99	Цагаанчулуут сумын Улаан хужирын булаг, Эрдэнэхайрхан сумын Элст хошууны булаг, Сантмаргаз сумын Сөнчийн булаг, Ургамал сумын Зөөхий булгийн эхийг нутгийн иргэд хашиж хамгаалан хүлээлгэн өгсөн.	100

цөхирдөл, хомсдолоос сэргийлнэ.	5.2.6.3	Усны сан бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалтын бүсийн дэглэмийг мөрдүүлнэ.	2021-2024	СЗДТГ	2	10	15	Аймгийн ИТХ-ын 54-р тогтоолын хэрэгжилтийг хангахаар хамгаалалтын бүсийн дэглэмийг тогтоосон мэдээллийг ГХБХБГ-т хүргүүлэн мэдээллийг нэгтгэн ажиллаж байна. Мөн 24 сумдад эргэлтийн цэгийг файл хэлбэрээр хүргүүлэн хамгаалалтын бүсийн дэглэмийг мөрдөж ажиллах цаашид газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд усны сан бүхий газрын хамгаалалтын бүсэд газар олгохгүй байх талаар төлөвлөгөөнд тусгаж ажиллах зөвлөмжийг хүргүүлсэн.	100
Байгалийн нөөц ашигласны төлбөрийн механизмыг хэрэгжүүлэн, нөөцийн зохистой ашиглалт, хамгаалалтыг сайжруулна.	5.2.6.1	Агнуурын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг сайжруулна	2021-2024	Агнуурын бүс нутаг бүхий СЗДТГ	5	30	45	Завхан аймгийн Алдархаан суманд 5 тэх. 2 халиун буга Шилүүстэй суманд 1 угалз, Цагаанхайрхан суманд 2 халиун буга, Яруу суманд 1 угалз агнан төлбөр хураамжийг орон нутгийн төсөвт бүрэн төвлөрүүлээд байна.	100
	5.2.6.2	Сумын ойн менежментийн төлөвлөгөөг баталж, хэрэгжүүлнэ.	2021-2024	Ойн сан бүхий СЗДТГ, СДОА	5	0	2	ENSURE төслийн 20 сая төгрөгийн санхүүжилтээр Тосонцэнгэл, Их-Уул сумдын ойн менежментийн төлөвлөгөөг аймгийн Засаг даргын 2021 оны А/109 дүгээр захирамжаар батлуулсан. Төлөвлөгөөний дагуу 80.4 га талбайд ойжуулалт, 280 га талбайд байгалийн сэргэн ургалтанд туслах ажил, 150 га талбайд цэвэрлэгээ, 20 га талбайд ойн арчилгааны огтлолт хийж гүйцэтгэсэн.	100
5.2 ДУГААР ЗОРИЛТЫН ДҮН									96.67
	5.3	Хүрээлэн буй орчны бохирдол, доройлтыг бууруулна.							
Эвдэрсэн, доройтсон газрыг нөхөн сэргээнэ.	5.3.1.1	Уул уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн талбайд нөхөн сэргээлт хийнэ.	2021-2022	БОАЖГ, СЗДТГ, ААН	10	15.64	21.34	Дөрвөлжин сумын Таван толгой багт 5.8 га газрын нөхөн сэргээлтийн ажлыг "Чу макс" ХХК хийж гүйцэтгэсэн.	100
Байгальд ээлтэй технологи нэвтрүүлэх замаар орчны бохирдлыг бууруулна.	5.3.2.1	Улиастай, Түдэвтэй, Нөмрөг, Тосонцэнгэл, Алдархаан, Тэс сумын уурын зууханд шүүлтүүр суурилуулна	2021-2024	Дулаан үйлдвэрлэгч нар, СЗДТГ		5	4	Улиастай сумын дулаан хангагч байгууллага Ургамал сүлжээ ХХК нь байгууллагын өөрийн хөрөнгөөр шүүлтүүр суурилуулсан байна. Шинээр Шилүүстэй, Цагаанхайрхан, Баярнайрхан сумд шүүлтүүр бүхий нэгдсэн халаалтын уурын зуухтай болсон.	90
	5.3.2.4	Улиастай суманд агаарын чанарыг сайжруулах бүс тогтооно.	2021	АЗДТГ, УЦОШТ, Улиастай СЗДТГ, БОАЖГ		0	1	Улиастай сумын агаарын чанар, төлөв байдлын судалгааг хийж гүйцэтгэсэн бөгөөд агаар бохирдуулагч гол элемент нь хүхэрийн давхар исэл, том ширхэгт тоосонцор, ялангуяа халаалтын улиралд PM10 хувьд MNS 4585:2016 стандартаас давсан бүсүүд Жаргалант багт 43-386 мкг/м3, Жинст багт 38-320мкг/м3, Богдын гол багт 65-258 мкг/м3, Товцог багт 76-266 мкг/м3 үүсч байна.	90
5.3 ДУГААР ЗОРИЛТЫН ДҮН									93.33
	5.4	Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, даван туулах арга хэмжээг хэрэгжүүлнэ.							
Ус, цаг уурын ажиглалтын болон орчны хяналт шинжилгээний сүлжээг өргөжүүлнэ.	5.4.1.1	Цаг агаарт зориудаар нөлөөлж, хур тунадсыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ	2021-2024	УЦУОШТ	10	65%	75%	Аймгийн хэмжээнд цаг агаарын хуурайшилтыг бууруулах зорилгоор цаг агаарт зориудаар нөлөөлж хур тунадас нэмэгдүүлэх ажлыг 4 дүгээр сарын 10-аас эхлэн нийт 10 удаа, газрын генератор 3 удаа нийт 13 удаагийн үйл ажиллагаа явуулсан. Хур тунадасны хазайлтыг олон жилийн дундажтай харьцуулж үзэхэд манай аймгийн нутгаар 5.6 дугаар саруудад олон жилийн дундажаас бага, 4, 7, 8 дугаар саруудад олон жилийн дундажаас ахиу хур тунадас орсон байна. Цаг агаарт зориудаар нөлөөлж хур тунадас нэмэгдүүлснээр Богдын гол, Гацаа, Галуутай, Тайшир, Идэр-Тосонцэнгэл усан цахилгаан станцуудын хэвийн тасралтгүй үйл ажиллагаа явуулах нөхцлийг бүрдүүлж өгсөн. Зуншлагын байдал нийт нутгаар бэлчээрийн ургамлын гарц сайжирч, ургамлын дундаж өндөр 5-25 см, ургамлын ургалтын байдал аймгийн хэмжээнд 100 буюу үүнээс 80% нь сайн, 20% хэвийн үнэлгээтэй байна.	100
	5.4.1.2	Цаг агаарын аюулт үзэгдлийг урьдчилан мэдээлэх, сэрэмжлүүлэх чадварыг бэхжүүлнэ	2021-2024	УЦУОШТ		75%	78%	Цаг агаарын аюулт үзэгдлийг урьдчилан мэдээлэх, сэрэмжлүүлэх зорилгоор нийт 105 удаа АНХААРУУЛГА, 8 удаа СЭРЭМЖЛҮҮЛЭГ, 5 удаа УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ мэдээ зохиож, олон нийтийн сүлжээ болон багц мессежээр ард иргэдэд шуурхай хүргэж ажилласан. Багц мессежээр нийт 19 удаа (шар ус, хүйтэн бороо, их бороо, цочир хүйтрэлт, цасан болон шороон шуурга, хүчтэй салхи) зэргээр нийт 192000 хүнд хүргэж үйлчилсэн байна. Цаг агаарын мэдээний илрүүлэлт 100%, таарц 90.8%, оич 92.5% байна.	100
	5.4.1.3	Ус, цаг уурын харуулыг автомат станц болон автомат хэмжигчээр хангана	2021-2024	УЦУОШТ		12	7	10	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Цаг уур, орчны шинжилгээний газарт Хятад улсаас автомат хэмжигч багаж тоног төхөөрөмжийн нийлүүлэлт хийгдсэн боловч экстремаль утгууд тодорхойлох боломжгүй багаж төхөөрөмж ирсэн. Иймд Хятад улсын талд эргүүлэн буцааж тендерийн шаардлагад нийцсэн багаж авах, багаж төхөөрөмжийг буцаасан ба 11-дүгээр сард нийлүүлэх гэрээний дагуу хүлээгдэж байсан ч Ковид-19 цар тахлын халдвараас шалтгаалан хил гааль хаагдаж тодорхойгүй хугацаагаар хүлээгдэж байна. Энэ онд багтааж багаж төхөөрөмжийн хангалт хийгдэхээр хүлээгдэж байна

Байгаль орчны салбарын хамтын ажиллагааг нэмэгдүүлнэ	5.4.2.1	Сумдын байгаль хамгаалагчдын ажиллах нөхцөлийг сайжруулан, нэн шаардлагатай техник, тоног төхөөрөмжөөр хангана	2021-2024	БОАЖГ, МХГ, СЗДТГ	23	3	10	Тэлмэн, Идэр, Цагаанхайрхан, Цагаанчулуут, Баянхайрхан, Баянтэс, Сантмаргаз, Сонгино сумдын байгаль хамгаалагчдад нийт 8 мотоцикл, газрын албан хаагчдад 2 принтер, 2 суурин компьютерийн асуудлыг шийдвэрлэж тоног төхөөрөмжөөр хангах ажил үе шаттай хийгдэж байна.	90
	5.4.2.2	"Байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөл"-ийн үйл ажиллагааг дэмжинэ.	2021-2024	БОАЖГ, СЗДТГ	2	10	15	Тосонцэнгэл, Их-Уул сумын 10 нөхөрлөлийн ойн менежментийн төлөвлөгөөг боловсруулан батлуулсан. Агь наран булаг ББН 3 га, Нисдэг үр ББН 0.3 га нийт 3.3 га мод үржүүлгийн газрын хашаа хамгаалалтыг сайжруулж, усралтын систем, хүлэмж зэрэг тоног төхөөрөмжөөр хангаж шинэсний үр түүж боловсруулах сургалт зохион байгуулсан. Зулзган мод нөхөрлөлийн эзэмшлийн ойн захад 2 га талбайг хашиж хамгаалан ургацыг нэмэгдүүлэх байдлаар хадлан тэжээл авах нөхцөл бүрдүүлсэн. Нийт 13 нөхөрлөлийн үйл ажиллагааг дэмжсэн.	90
5.4 ДҮГЭЭР ЗОРИЛТЫН ДҮН									90
ТАВДУГААР БҮЛГИЙН ДҮН									91.25
ЗУРГАА. БҮС, ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО									
	6.1	Хүн амын нутагшилт, суурьшлын зохистой тогтолцоонд тулгуурлан, бүс, орон нутаг, төв суурин газрын төлөвлөлтийг оновчтой хийнэ							
"Шинэ сум" төслийг хэрэгжүүлж, сумын төвийн инженерийн шугам сүлжээг нэмэгдүүлнэ	6.1.1.2	Сумдад шат дараатайгаар цэвэрлэх байгууламж барина.	2021-2024	АЗДТГ, ГХБХБГ	1,100.0	3	1	Сумын төвийн шинэчлэл төслийн хүрээнд 2021 онд Алдархаан, Отгон суманд шинээр 50м3/х хүчин чадалтай цэвэрлэх байгууламж ашиглалтад оруулахаар барилга угсралтын ажил хийгдэж байна. 2021 онд сумдад үе шаттайгаар цэвэрлэх байгууламжийг шинээр барих шаардлагатай байгаа тул сумдын бохир усны хоногийн хэрэглээ, ариутгах татуургын ашиглалтын байдлыг харгалзан үзэж эрэмбэлж цэвэрлэх байгууламж нэн түрүүнд шаардлагатай сумдын нэрсийг БХБЯ-нд хүргүүлсэн. Мөн Сумын сургууль цэцэрлэг, дотуур байрны нүхэн жорлонг бага оврын ариун цэврийн байгууламжаар солих ажлын хүрээнд Тэс, Баянтэс, Асгат сумдын бага оврын цэвэрлэх байгууламжийн ажлыг Жавхлантүр ХХК, Отгон, Яруу, Ургамал, Баянхайрхан сумын ажлыг Сити медиа ХХК, Сантмаргаз, Нөмрөг, Сонгино сумын ажлыг Сантех-Увс ХХК, Цагаанхайрхан, Дөрвөлжин Түдэвтэй Алтан түнгэл ХХК тус тус шалгаран зураг төслийн ажил хийгдэж байна.	50
	6.1.1.4	Сумын ахуй үйлчилгээ, нийтийн халуун усны барилгыг засварлаж, шинэчилнэ	2021-2024	ГХБХБГ	200.0	18	2	2021 онд НҮБ-ын хүүхдийг ивээх сангийн хөрөнгөөр Сонгино, Шилүүстэй суманд сургуулийн хүүхдийн халуун усны барилга, Цэцэн-Уул, Цагаанчулуут сумдын Эрүүл мэндийн төвд ариун цэврийн байгууламжийн ажлыг тус тус хийж гүйцэтгэж байна. 2020 оны ОНХС-ийн хөрөнгө оруулалт 65.0 сая төгрөгийн санхүүжилтээр он дамнан баригдаж байгаа Сантмаргаз сумын халуун усны барилга нь санхүүжилт хүрэхгүй байгаа тул бохир усны цооног хийгдээгүй хүлээгдэж байна.	30
Төв суурин газруудын ногоон байгууламжийн талбайг нэмэгдүүлж, соёл амралтын хүрээлэн байгуулна.	6.1.2.1	Цэцэрлэгжүүлэлт, ногоон байгууламжийг өргөжүүлэхэд хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлнэ.	2021-2024	СЗДТГ	5	128	133	Сонгино сум Бор өндөр баг Дэлгэрлэнд 5 га талбайд бичил цэцэрлэг байгуулан 420 ширхэг мод, бут тарьсан. Тэлмэн сумын нутагт 5 га талбайг хашиж хамгаалан 500 ширхэг чацарганы суулгац тарьж ургуулж байна. Аж ахуйн нэгжүүд өөрийн хөрөнгөөр хийж гүйцэтгэсэн.	100
	6.1.2.2	"Өрх бүр хашаандаа мод тарих" аяныг зохион байгуулна	2021-2024	СЗДТГ	10.0	319	500	Хавар намрын бүх нийтээр мод тарих өдрийн хүрээнд 24 суманд 30601 ширхэг шилмүүст болон навчит төрлийн мод, бут тарьсан. Үүнээс 1094 айл өрх хашаандаа 6431 ширхэг мод бут тарьсан байна. Мод тарих ажилд 332 аж ахуйн нэгж байгууллага, 5036 иргэн оролцож 89.8 сая төгрөг зарцуулсан байна.	100
Хаягжилтын нэгдсэн системийг нэвтрүүлэх ажлыг эхлүүлнэ.	6.1.5	Хаягжилтын нэгдсэн системийг нэвтрүүлэх ажлыг эхлүүлнэ	2021-2024	АЗДТГ	60.0	9	13	ГХБХБГ дээр төв суурин газрын газрын систем шинэчлэгдэж, цахимд шилжүүлэх ажил хийгдсэн. Энэ ажлын хүрээнд 13 сумын хаягжуулалтын ажлыг хийж нэгдсэн мэдээллийн системд оруулсан.	100
Шаардлага хангасан ундны усны эх үүсвэрээр хангагдсан хүн амын эзлэх хувийг нэмэгдүүлнэ	6.1.7.2	Ус зөөлрүүлэх төхөөрөмж суурилуулна	2021-2024	АСЗДТГ	120.0	1	2	2021 онд Шилүүстэй сумын төвийн ундны цэвэр усны худагт ус зөөлрүүлэх төхөөрөмж суурилуулсан.	70
	6.1.7.3	Ундны усны худгийг ухаалаг төлбөрийн системтэй болгоно	2021-2024	АСЗДТГ	30.0	6	8	2021 онд Улиастай сумын 6 худаг, Цэцэн-Уул сумын 2 худагт ухаалаг төлбөрийн систем суурилуулсан.	100

Инженерийн бүрэн хангамжтай орон сууцаар хангагдсан өрхийн эзлэх хувийг нэмэгдүүлнэ	6.1.8.1	Байгууллага, айл өрхийн нүхэн жорлонг эко жорлонгоор солих ажлыг эхлүүлнэ	2021-2024	АСЗДТГ	72%	24	Аймгийн хэмжээнд байгаа нийт нүхэн жорлонгийн судалгааг гаргаж, Идэр, Тэлмэн, Нөмрөг, Түдэвтэй сумдын албан тушаалтнууд нийт 60 хүнд ус, ариун цэврийн байгууламжийн төлөвлөгөө боловсруулах арга зүйн сургалт зохион байгуулсан. Асгат, Баянтэс, Тэс, Түдэвтэй, Цагаанхайрхан, Дөрвөлжин сумдын нийт 20 хичээлийн байр, дотуур байр, цэцэрлэгийн нүхэн жорлонг шинэчлэхээр батлагдаж угсралтын ажил хийгдэж байна. Улиастай суманд инженерийн бүрэн хангамжтай орон сууцанд 120 айл, өрх орсон.	90	
Дахивар бүтээгдэхүүн худалдан авах цэгүүд, боловсруулах цех байгуулна	6.1.9.1	Сумдыг дахин боловсруулах бүтээгдэхүүнийг бутлах төхөөрөмжтэй /пресслэгч/ болгох ажлыг эхлүүлнэ	2021-2024	АСЗДТГ	5.0	1	3	Дахивар хог хаягдлыг шахаж нягтаршуулах төхөөрөмжийг хариуцсан Завхан Ногоон Гарц ТББ нь төхөөрөмж хүлээн авсан цагаас одоог хүртэл үйл ажиллагаа явуулаагүй тул дахивар хог хаягдлын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Тосонцэнгэл сумын иргэн А.Уламбаярт хог хаягдлыг шахаж нягтаршуулах төхөөрөмжийг гэрээ байгуулан хүлээлгэн өгсөн.	70
6.1 ДУГААР ЗОРИЛТЫН ДҮН								78.89	
ЗУРГААДУГААР БҮЛГИЙН ДҮН								78.89	
НЭГДСЭН ДҮН								81.25	